

 ГОЛОМТ БАНК

2025

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН  
ТАЙЛАН

## ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Ерөнхий мэдээлэл	4
Гүйцэтгэх захирлын мэндчилгээ	6
Тогтвортой байдлын онцлох мэдээллүүд	8
Хүлэмжийн хийн ялгарал	9

## ЗАСАГЛАЛ

Тогтвортой байдлын он цагийн товчоо	11
Стратеги	12
Засаглал	13
ТУЗ-ийн олон талт байдал	19
Материаллаг байдлын үнэлгээ	21
2030 болон 2050 оны зорилго	23

## ТОГТВОРТОЙ, НОГООН САНХҮҮЖИЛТ

Тогтвортой, ногоон зээлийн багц	25
Тогтвортой, ногоон зээлийн бүтээгдэхүүн	28
Тогтвортой, ногоон эх үүсвэр	30
“Цэнхэр” санаачилгууд	31
Бидний үзүүлж буй нөлөө	32
Санхүүжүүлсэн хүлэмжийн хийн ялгарал	33
ХХЯ өндөр салбарууд ба бууруулах нарийвчилсан төлөвлөгөө	36

## ТОГТВОРТОЙ, НОГООН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хүлэмжийн хийн ялгарлын тооцоолол	40
Өөрийн үйл ажиллагаанаас ялгарах ХХЯ-ыг бууруулах нь	43
Ажилтнуудын оролцоо	46

## НИЙГЭМ

Хүний нөөц-Үл ялгаварлах, тэгш эрх, оролцоо	49
Ажилтнуудын хангамж	50
НҮББОХ-ХБЗ 2030 он хүртэлх хамрах хүрээ	52
Хүний эрхийг хүндэтгэн дээдлэх	53
Бүтээгдэхүүн үйлчилгээгээр дамжуулан нийгэмд үзүүлж буй эерэг нөлөөлөл	55
Жижиг дунд бизнес эрхлэгчдийн өрсөлдөх чадавхыг бэхжүүлэх	58
Нийгмийн хариуцлага	59
Төсөл хөтөлбөр, аян	60
Оюутнуудыг дэмжих хөтөлбөр	64

## ОЛОН ТАЛТ ОРОЛЦОО

Мэдлэгээ хуваалцах, бусдыгаа манлайлах нь	66
Оролцогч талуудын хамтын ажиллагаа	67
Гишүүнчлэл ба хамтын ажиллагаа	68

### УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЭРСДЭЛ

Уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэл	70
Уур амьсгалын өөрчлөлтийн сценари анализ	73
Харилцагчдын байгаль орчин нийгмийн эрсдэлийг удирдах нь	77

### ТООН ТОДРУУЛГА

Ажилтнуудын тоон мэдээлэл	80
Байгаль орчинтой холбоотой тоон мэдээлэл	82
Хүлэмжийн хийн ялгаруулалт	84
Бусад мэдээлэл	86
БОНЗ-той холбоотой шагнал	90
Ил тод, нээлттэй тайлагнал	91

### БОНЗ ТАЙЛАГНАЛЫН ОУ-ЫН СТАНДАРТУУДЫН НИЙЦЭЛ

НҮББОХ-Банк Санхүүгийн Санаачилга, Хариуцлагатай банкны зарчмуудын хэрэгжилтийн тайлан	93
Монголын хөрөнгийн биржийн БОНЗ, тогтвортой байдлын тайлагналын стандартын дагуух тайлан (ОУ-ын GRI стандарт)	101
Хүлэмжийн хийн тооцооллын тодруулга	108



### **Тайлан бэлтгэсэнтэй холбоотой мэдэгдэл**

Голомт банк ХК-ийн 2025 оны Тогтвортой хөгжлийн тайлан (цаашид “Тайлан” гэх) нь Голомт банк ХК (цаашид “Голомт банк”, “банк” эсвэл “бид” гэх)-ийн Байгаль орчин, Нийгэм, Засаглал (цаашид БОНЗ гэх) болон ногоон санхүүжилтийн чиглэлээр 2025 онд хийгдсэн үйл явц, ахиц дэвшлийн талаар мэдээлэл өгөх зорилготой юм. Үүнд банкны ногоон болон нүүрстөрөгч багатай санаачилгуудыг дэмжсэн болон ногоон санхүүжилтийг уриалсан ололт амжилтуудыг багтаасан болно. Өөрөөр заагаагүй бол, энэхүү тайлан нь 2025 оны 1-р сарын 1-нээс 12-р сарын 31-нийг хүртэлх санхүүгийн жилийн мэдээллийг агуулна.

### **Тайлангийн тухай**

Энэхүү Тогтвортой хөгжлийн тайлан нь Гүйцэтгэх захирлаар баталгаажсан ба дараах хууль дүрэм, стандарт, удирдамжийн дагуу бэлтгэгдсэн болно.

Монголын хөрөнгийн бирж- БОНЗ, Тогтвортой байдлын тайлагналын удирдамж (2022 онд гарсан)

НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр, Санхүүгийн санаачилга- Хариуцлагатай банкны зарчмууд, (2019 онд гарсан)

Монгол улсын Тогтвортой санхүүжилтийн зарчмууд (2015 онд гарсан)

Санхүүгийн Тогтвортой байдлын зөвлөл/ISSB-ийн Уур амьсгалтай холбоотой санхүүгийн тодруулга хийх ажлын хэсгийн (TCFD) зөвлөмжүүд (2023 онд гарсан)

### **Өгөгдлийн мэдэгдэл**

Тайлан дахь тоо баримтууд нь 2025 оны 1-р сарын 1-нээс 2025 оны 12-р сарын 31-ний хооронд байна. Өөрөөр заагаагүй бол, тайланд дурдсан мөнгөн дүн төгрөгөөр илэрхийлэгдсэн болно.

### **Нийтлэлийн хэлбэр**

Тайланг онлайн хэлбэрээр гаргасан ба банкны вэбсайтаас татан авах боломжтой. Тайлан нь англи, монгол хэл дээр гарсан бөгөөд хоёр хувилбарын хооронд зөрүү гарсан тохиолдолд монгол хувилбарыг баримтална.

**Холбоо барих:** [sfd@golomtbank.com](mailto:sfd@golomtbank.com)

**Дотоод аудитаар баталгаажуулах нь**

Дотоод аудитын газар нь НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн “Хариуцлагатай банкны зарчим”-д нэгдсэн банкнуудын “Хариуцлагатай банкны зарчмын тайлан” бэлдэх удирдамжийн дагуу тайланг бэлтгэсэн эсэх болон тус тайланд тусгасан 6 зарчмын хэрэгжилтийг нотлох мэдээлэл, тооцоолол, үр дүнд 2024.12.31-ний өдрийн байдлаар баталгаажуулалт хийсэн.

“Хариуцлагатай банкны зарчмын тайлан”-д хийсэн баталгаажуулалтаар тус 6 зарчмын хүрээнд хийгдсэн ажил, тооцоолол нь бодит байдлаас зөрүүтэй тусгагдсан эсвэл материаллаг хэмжээний өөрчлөлт, сайжруулалт хийхүйц асуудал тухайн үед илрээгүй. Харин баталгаажуулалтын явцад сайжруулах шаардлагатай асуудлууд гарсныг тухай бүр явцын үүрэг өгч засварлуулсан ба тооцоололд ашиглагдах өгөгдлийн чанар, хамрах хүрээг нэмэгдүүлэх, автоматжуулах боломжийг судлах, үйл ажиллагаанд нэвтрүүлэх чиглэл өгч, 2025 болон 2026 онд төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Хэрэгжүүлж дуусах огноо	Ажлын тоо	Хэрэгжилтийн явц
2025.06.30	4	Хэрэгжилтийг хангаж, Дотоод аудитын газарт тайлагнасан
2026.04.15	3	Хэрэгжилтийг хангаж, Дотоод аудитын газарт тайлагнасан
2026.06.30	4	Хэрэгжилтийг хангахаар ажиллаж байна

## ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

Голомт банк эх орны хөгжлийн голомт, иргэн бүрийн жаргалтай амьдралын төлөө “Сайн сайхныг санхүүжүүлнэ” уриан дор үйл ажиллагаагаа явуулдаг. Бид өнгөрсөн 30 жилийн хугацаанд иргэд, харилцагчид, хамтрагч байгууллагууд, хувьцаа эзэмшигчдийнхээ хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, гарц боломжийг байнга эрэлхийлэх, бизнесийн үйл ажиллагааны бүх шатанд тусган хэрэгжүүлэх зэргээр салбартаа манлайлан ажиллахыг эрмэлзсээр ирсэн билээ.

2025 он Голомт банкны хувьд онцлох жил байлаа. Бид хурдацтай хувьсан өөрчлөгдөж буй зах зээлд өөрсдийн байр суурийг дахин бататгаж, оролцогч талуудад үзүүлэх дэмжлэг, хамтын ажиллагаагаа өргөжүүллээ. Түүнчлэн урт хугацааны тогтвортой өсөлт, цаашлаад тогтвортой ирээдүйг цогцлоох хариуцлагатай үүргээ ухамсарлаж, инновац болон нягт хамтын ажиллагааг чухалчилсаар байна. Бидний хувьд харилцагч, хамтран ажиллагсад болон нийгэмдээ тогтвортой ирээдүйг хэрхэн хуваалцаж, үлгэрлэснээр урт хугацааны ололт амжилтаа тодорхойлдог бөгөөд Голомт банкны үйл ажиллагаа тогтвортой хөгжлийн салбарт Дэлхийн жишиг Монголын банк болоход чиглэсээр байна.

Бид харилцагчдаа нүүрстөрөгч бага ялгаруулдаг эдийн засаг руу шилжих, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой эрсдэл, боломжуудаа үнэлэхэд нь дэмжиж ажилладаг. Голомт банкны тогтвортой хөгжлийн стратегийн хүрээнд бид 2019 оноос хойш нүүрстөрөгчийн хийн ялгарлыг бууруулах чиглэлд нийт 1.1 их наяд төгрөгийн санхүүжилтийг олгосон бөгөөд байгаль орчны шилжилтийг дэмжихэд бүх нөөц бололцоогоо дайчлан 2030 он гэхэд тогтвортой санхүүжилтийг нийт зээлийн багцын 10 хувьд хүргэх зорилтыг тавьсан. Ингэснээр нүүрстөрөгчийн ялгаруулалт өндөртэй салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниудад дэмжлэг үзүүлэх боломжийг нэмэгдүүлж байгаа юм.

2025 онд бид өөрсдийн хамрах хүрээ 1, 2-ын зорилтын хүрээнд томоохон ахиц гаргаж, жил бүр тооцооллыг сайжруулж байна. Хамрах хүрээ 3-ын хувьд бид нүүрстөрөгчийн ялгаруулалт өндөртэй эдийн засгийн салбаруудад зээл олгох зорилтыг тодорхойлж, шилжилтийн санхүүжилтийн арга барилаа улам боловсронгуй болгоод байна. Бид тогтвортой хөгжлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхээс гадна энэ салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниудад өөрсдийн шилжилтийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд нь шаардлагатай дэмжлэг тусалцааг үзүүлэхэд анхаарч ажиллаж байна.



Хувьсан өөрчлөгдөж буй макро эдийн засгийн болон зохицуулалтын орчинд Голомт банк харилцагчдадаа ногоон эдийн засаг руу шилжих, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой эрсдэлийг удирдах, үүнээс үүдэх боломжуудыг давуу тал болгох зэрэг ач холбогдлын талаар нөлөөллийн ажлуудыг хийж байна. Нүүрстөрөгч бага ялгаруулдаг эдийн засгийн шилжилтээс үүдэн бизнесийн болон хөрөнгө оруулалтын орчин хувьсан өөрчлөгдсөөр байгаа билээ. Иймд бид харилцагчидтайгаа нягт хамтран ажиллаж, энэхүү шилжилтийн үйл явцын нөлөөллийг ойлгоход нь дэмжлэг үзүүлж, ил тод байдлыг нэмэгдүүлэх арга хэрэгслүүдийг хөгжүүлэн, мэдээлэлд суурилсан шийдвэр гаргалтыг дэмжин ажиллаж байна.

Голомт банк уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, тогтвортой ногоон эдийн засгийг цогцлооход хувь нэмрээ оруулах зорилгынхоо хүрээнд тууштай ажиллаж байгаа ч биднээс үл хамаарах бодлого, зохицуулалтын орчин болон салбар хоорондын уялдаа холбоог илүү сайжруулснаар бодит ахиц дэвшил гаргах юм.


Түүнчлэн бид тогтвортой хөгжил, уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийг тодорхойлох, хэмжих, хянах, удирдах, тайлагнах эрсдэлийн удирдлагын тогтолцооны үндэс суурийг тавьсан. Манай банкны тогтвортой хөгжил, уур амьсгалын эрсдэлийн хүрээ нь шилжилтийн болон биет эрсдэлийн үнэлгээ, сценарийн шинжилгээнд тулгуурласан дотоод аргачлалуудаас бүрддэг. 2025 онд бид тогтвортой хөгжил, уур амьсгалын эрсдэлийг санхүүгийн болон санхүүгийн бус эрсдэлийн уламжлалт тогтолцоонд гүнзгийрүүлэн нэгтгэх бат бөх суурийг бүрдүүлэн удирдаж байна.

Энэхүү тогтвортой хөгжлийн тайланд бид тогтвортой, нүүрстөрөгч бага ялгаруулдаг эдийн засагт шилжсэнээр бий болох боломж, эрсдэлүүдийг онцолсон ба бүх оролцогч талуудтайгаа хамтдаа өсөж хөгжин, тогтвортой ногоон ирээдүйг цогцлоох нь бидний хариуцлагатай хөгжлийн үндсэн зорилго билээ.

Эрхэм харилцагчид, хамтрагч түншүүд болон нийт ажилтнууд та бүхэндээ талархал илэрхийлье. 2026 онд Голомт банк тогтвортой хөгжлийг бэхжүүлж нүүрстөрөгч бага ялгаруулдаг эдийн засгийн шилжилтийг эрчимжүүлэн, улс эрх орныхоо хөгжилд хувь нэмрээ оруулж, үлгэрлэн манлайлж ажиллах болно.



А.ОДОНБААТАР  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



# ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ОНЦЛОХ МЭДЭЭЛЛҮҮД

## 1.1 ИХ НАЯД ТӨГРӨГ

2019 оны 3-р улирлаас 2025 оны 4-р улирлын хооронд 1.1 их наяд төгрөгийн тогтвортой, ногоон санхүүжилтийг олгосон бөгөөд үүнээс 270 (2024:308) тэрбум төгрөгийг 2025 онд олгосон байна.

## 406 ТЭРБУМ ТӨГРӨГ

Ногоон зээлийн багц 406 (2024:265) тэрбум төгрөг болсон байна. Энэ нь:

Банкны нийт зээлийн багцын **4.9%** Зах зээлийн **17.4%**-ийг эзэлж байна.

## 0.2 сая тнCO2e

Өөрийн үйл ажиллагаанаас ялгарч буй ХХЯ

## 0.7 сая тнCO2e

Санхүүжүүлсэн багцаас ялгарч буй ХХЯ

## 1.5 сая тнCO2e

Хөрөнгө оруулалтаас ялгарч буй ХХЯ

# 2,800

Нийт ажилтны тоо



30% эрэгтэй



70% эмэгтэй

Усны нөөц



2030: 5%  
2050: 10%

Хүлэмжийн хийн ялгарал



2030: 30%  
2050: 50%



GREAT PLACE TO WORK

# 179 САЯ АМ.ДОЛЛАР

2025 онд нийт татсан тогтвортой, ногоон эх үүсвэрийн дүн



ОУСК-иас Монголын анхны **ЦЭНХЭР САНХҮҮЖИЛТ**-ыг татлаа.

Ногоон зээлийн багцаар дамжуулж:



# 4,477

ажлын байр



# 205 ТЭРБУМ ₮

нэмүү өртгийг бий болгов.



ТоС Шилдэг Банк 2025



ТоС Манлайлагч Байгууллага 2026



Усны Элч Банк 2025

## ХАМРАХ ХҮРЭЭ 1 (тнCO2e)



Түлш:  
2025: 234,961.16  
2023: 231,794.22

## ХАМРАХ ХҮРЭЭ 2 (тнCO2e)



Эрчим хүч:  
2025: 715.47  
2023: 881.30



Дулаан:  
2025: 296.74  
2023: 278.52

## ХАМРАХ ХҮРЭЭ 3 БУСАД (тнCO2e)



Хог хаягдал:  
2025: 1,711.33  
2023: 2,175.73



Томилолт:  
2025: 155.27  
2023: 145.44



Ажилтнуудын гэр-ажил:  
2025: 148.36  
2023: 185.56

## ХАМРАХ ХҮРЭЭ 3 САНХҮҮЖҮҮЛСЭН (тнCO2e)



Санхүүжилт:  
2025: 662,926  
2023: 447,590



Хөрөнгө оруулалт:  
2025: 1,462,352  
2023: 582,892

2023 суурь онтой харьцуулав.



- Хамрах хүрээ 1  
**9.94%**
- Хамрах хүрээ 2  
**0.04%**
- Хамрах хүрээ 3 бусад  
**0.09%**
- Хамрах хүрээ 3 санхүүжилт  
**28.05%**
- Хамрах хүрээ 3 хөрөнгө оруулалт  
**61.88%**



Тэрбум мод сангаар дамжуулан Хүлэмжийн хийн шингээлт:  
**2,020.48 тнCO2e**



Виртуал картаар дамжуулан нүүрстөрөгчийн ялгарлыг бууруулав:  
**36.57 тнCO2e**

\*Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг дэмжин 2022 оноос 2025 оны хугацаанд 440,432.16 ширхэг мод тарьж 2,020.48 тнCO2e шингээн хувь нэмрээ оруулсан байна.

\*Тайлант хугацаанд Голомт банк дижитал шийдэлдээ тулгуурлан 206,196 ширхэг виртуал картыг зах зээлд гаргалаа. Ингэснээр 3.4 тэрбум төгрөгийн пластик материалын зардал хэмнэсэн төдийгүй 36.57 тонн нүүрстөрөгчийн ялгарлыг бууруулж, банкны тогтвортой хөгжлийн зорилтыг бататгалаа.

 **ГОЛОМТ БАНК**  
*Сайн сайхныг санхүүжүүлнэ*

УСНЫ ЭЛЧ  
БАНК

**ЗАСАГЛАЛ**

# ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ОН ЦАГИЙН ТОВЧОО

Уур амьсгалын өөрчлөлт нь харилцагчид болон банкны хувьд томоохон эрсдэл, боломжуудыг бий болгож байна. Хүлэмжийн хийн ялгарлыг дэлхийн хэмжээнд мэдэгдэхүйц бууруулахын тулд зах зээлийн гол салбаруудад томоохон хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай болоод байгаа нь Голомт банк болон харилцагчдад ногоон, тогтвортой эдийн засгийн шилжилт хийх хэрэгцээ болон боломж байгааг илтгэж байгаа билээ. Иймд Голомт банк уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг сааруулах, дасан зохицоход чухал үүрэг, хариуцлага хүлээн ажиллаж байна.

2015-2016

- Тогтвортой санхүүжилтийн бодлого батлав.
- 50 сая төгрөгөөс дээш дүнтэй зээл бүрд БОНЭУ хийж эхлэв.

2017-2019

- Жендэрийн тэгш байдлыг хангах бодлого батлав.
- Тогтвортой хөгжлийн бодлого батлав.
- “Хариуцлагатай Банкны Зарчмууд”-д албан ёсоор нэгдэв.

2020-2021

- Жендэрийн тэгш байдлын хороо болон Тогтвортой хөгжлийн хороо байгуулагдав.
- Тогтвортой хөгжлийн жилийн тайлан гаргаж эхлэв.
- Тогтвортой санхүүжилтийн хэлтэс байгуулагдав.
- Тогтвортой хөгжлийн стратеги 2022-2025 батлагдав.

2022-2023

- Тогтвортой, ногоон зээлийн бүтээгдэхүүнүүдийг нэвтрүүлэв.
- “Partnership for Carbon Accounting Financials” буюу “Нүүрстөрөгчийн нягтлан бодох бүртгэлийн санхүүгийн түншлэл” олон улсын байгууллагад гишүүнээр элсэв.
- Санхүүжүүлсэн ХХЯ тооцож эхлэв.
- Уур амьсгал болон усны зорилтуудаа тодорхойлов.

2024

- JIM Foundation-д гишүүнээр элсэв.
- Тогтвортой санхүүжилт, нөлөөллийн хамрах хүрээ баримт бичиг батлагдав.
- Тогтвортой хөгжлийн нөлөөллийн үнэлгээг J.P.Morgan хөгжлийн санхүүгийн институттэй хамтран хийлгэв.
- S&P Global Тогтвортой байдлын үнэлгээг хийлгэв.
- Тогтвортой, ногоон үйл ажиллагааны стандарт батлагдав.
- Ногоон барилгын LEED GOLD O+M гэрчилгээг төв оффисын барилгад авав.
- СТОУС ТБ1, ТБ2 бэлэн байдлын үнэлгээг хийж гүйцэтгэв.

2025

- Усны Элч банк 2025
- Шилдэг ToC банк 2025
- ToC Манлайлагч байгууллага 2026
- ОУСК-иас МУ-ын анхны цэнхэр санхүүжилт татав.
- Олон улсад ногоон болон нийгмийн бонд гаргав.
- Ногоон арилжааны банкны эвсэлд нэгдэв.
- БОНЭУ журам ОУСК-ийн стандарттай нийцэв.
- Шилжилтийн төлөвлөгөө батлагдав.

Голомт банк тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг бизнесийн стратегид бүрэн тусгаж, Үндэсний тодорхойлсон хувь нэмэр баримт бичиг болон Парисын хэлэлцээрийн хэрэгжилтийг хангахад хувь нэмрээ оруулан ногоон санхүүгийн хүчирхэг тогтолцоог бүрдүүлэхийн төлөө бүхий л хүчин чармайлтаа гарган ажиллаж байна.



## СТРАТЕГИ ЗОРИЛГО #1

Тогтвортой засаглал  
Өөрийн болон харилцагчдын  
ногоон, тогтвортой эдийн засгийн  
шилжилтийг хийх зорилго,  
төлөвлөгөөг хэрэгжүүлэх

## СТРАТЕГИ ЗОРИЛГО #2

Тогтвортой, ногоон санхүүжилт  
Тогтвортой, ногоон санхүүжилтийн  
хүрээг тэлэх

## СТРАТЕГИ ЗОРИЛГО #3

Уур амьсгалын эрсдэлийн удирдлага  
Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэн  
гарах эрсдэлийг удирдах

## СТРАТЕГИ ЗОРИЛГО #4

Олон талт оролцоог хангах  
Зорилго, зорилтуудаа хэрэгжүүлэхэд  
оролцогч талуудтай хамтын  
ажиллагааг бэхжүүлэх

## ЗАСАГЛАЛ


Голомт банк компанийн засаглалын хамгийн өндөр стандартыг хэрэгжүүлэх зарчмыг тууштай баримталж ирсэн бөгөөд зохистой сайн засаглалыг бүрдүүлэх нь урт хугацааны санхүүгийн уян хатан байдал, оролцогч талуудын итгэл, тогтвортой үнэ цэнийг бий болгоход чухал ач холбогдолтой. 2025 оны хүрээнд Төлөөлөн удирдах зөвлөл нь стратеги, эрсдэл, дотоод хяналт, ёс зүй болон БОНЗ асуудалд үр дүнтэй хяналт тавьж, тогтвортой хөгжлийн зарчмыг шийдвэр гаргалтад бүрэн шингээж ажиллалаа.

## ЗАСАГЛАЛЫН ТОГТОЛЦОО

Голомт банкны Засаглалын тогтолцоо нь Монгол Улсын Банкны тухай хууль, Компанийн тухай хууль, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж зэрэг зохицуулагч байгууллагуудын холбогдох дүрэм, журамтай нийцэхээс гадна олон улсын засаглалын үндсэн зарчмууд, шилдэг туршлагууд Эдийн засгийн хамтын ажиллагаа ба хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ) болон Базел зэрэг баримт бичиг, стандартын дагуу зохистой засаглалын тогтолцоогоо улам бэхжүүлэн ажиллаж байна.



Голомт банк ХК-ийн Тогтвортой хөгжил, уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийн удирдлагын засаглалын бүтцийн тойм





### ЗАСАГЛАЛ

Голомт банкны Төлөөлөн удирдах зөвлөл (ТҮЗ), Гүйцэтгэх удирдлага, Удирдлагын баг болон бусад холбогдох хороод нь тогтвортой хөгжил, уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэл ба боломжуудыг хянах, удирдах ажлыг хэрэгжүүлэх тогтолцоог бий болгон бэхжүүлсээр байна.

2025 онд Голомт банк Эрсдэлийн удирдлагын тогтолцоондоо “Тогтвортой хөгжлийн болон уур амьсгалын эрсдэл”-ийг харгалзан үзэх бодлогын чиглэл нэмж эрсдэлийн таксономид тусган Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулсан юм. Ингэснээр тогтвортой хөгжлийн болон уур амьсгалын эрсдэлийг бусад банкны уламжлалт эрсдэлүүдтэй эн зэрэгцэн тодорхойлох, үнэлэх, удирдах, хянах болон тайлагнах тогтолцоо, зарчим, удирдлагыг тодорхойлж урт хугацаанд тогтвортой үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэх, хөрөнгө оруулагч, харилцагч, ажилтан болон бусад оролцогч талуудыг ашиг сонирхлыг хамгаалах, Монгол Улсын хууль тогтоомж, Монголбанк болон бусад холбогдох эрх бүхий байгууллагуудын шаардлагыг ханган ажиллаж байна.

### ТҮЗ-ИЙН ТҮВШИНД

Төлөөлөн Удирдах Зөвлөл нь Банкны урт хугацааны тогтвортой үйл ажиллагаа, стратегийг хариуцах бөгөөд хороод нь стратегийн шийдвэрийг хянаж, удирдан чиглүүлэхдээ тогтвортой хөгжил, уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэл ба боломжуудыг хянах, удирдах тогтолцоог бий болгох ажил эхэлсэн байна. Стратегийн хүрээнд тогтвортой хөгжил, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй санхүүгийн болон санхүүгийн бус эрсдэлүүдийг хянах, удирдах; Парисын хэлэлцээрийн дагуу банкны үйл ажиллагаа, тэр дундаа харилцагчдад санхүүгийн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой ялгаруулж буй хүлэмжийн хийн хэмжээг бууруулахад оршино.

## ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА БОЛОН УДИРДЛАГЫН БАГИЙН ТҮВШИНД

Удирдлагын багийн гишүүн бүр өөрийн нэгжийн чиг үүргийн хүрээнд стратегийн болон бизнесийн шийдвэрийг 2050 он хүртэлх БОН-ийн зорилго зорилтод нийцүүлэн гаргах үүрэгтэй ба Хороодоор дамжуулан мэдээлэл авах, шийдвэр гаргах, хяналт хийн ажиллаж байна. БОН-ийн бодлогын хэрэгжилтийг хангах, банкны бусад нэгжүүдэд дэмжлэг үзүүлэх зорилгоор тусдаа бүтэц ажиллаж байна.



Холбоос: [Гүйцэтгэх удирдлага](#)

	Тогтвортой хөгжлийн хороо	Жендэрийн тэгш байдлын хороо	Тогтвортой санхүүжилтийн хэлтэс
Дарга	Гүйцэтгэх захирал	Гүйцэтгэх захирал	1 захирал
Гишүүд	Гүйцэтгэх удирдлагын баг	Гүйцэтгэх удирдлагын баг	3 менежер, 3 БОНЭУнэлгээчин
Үндсэн үүрэг	Банкны тогтвортой санхүүжилт, тогтвортой хөгжлийн стратегийн хэрэгжилтэд хяналт тавих	Банкны бүтээгдэхүүн үйлчилгээ, дотоод үйл ажиллагаанд жендэрийн эрх тэгш байдлыг хангах	Банкны тогтвортой хөгжлийн бодлого болон стратегийн хэрэгжилтийг хангах, чиглүүлэх, олон улсын болон үндэсний стандартын хэрэгжилтийг хангах, харилцагчдын БОН эрсдэлийг үнэлэх, хянах, бууруулах, ногоон санхүүжилтийг тодорхойлох, баталгаажуулах, тайланг оролцогч талуудад хүргэх
Хурлын давтамж	Доод тал нь жилд 2 удаа	Доод тал нь жилд 2 удаа	

Тогтвортой хөгжил, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй санхүүгийн болон санхүүгийн бус эрсдэлийг тодорхойлох, хянах, удирдах чиг үүргийг "хоёрдугаар шугам"-д хамаарах **Эрсдэлийн удирдлагын газар (100 хувийн үүрэгтэй)**, **Олон улсын банкны газрын Тогтвортой санхүүжилтийн хэлтэс (20 хувийн үүрэгтэй)**, **Зээлийн газар (хэлтсийн чиг үүргээс хамааран 60-100 хувийн үүрэгтэй)** болон **Санхүү удирдлагын газар (100 хувийн үүрэгтэй)** хамтран хариуцаж "Нэгдүгээр шугам"-д хамаарах нэгжүүдийн чиг үүргийн хүрээнд уур амьсгалын өөрчлөлт болон байгаль орчин, нийгэм (БОН)-ийн эрсдэлээ хэрхэн удирдаж байгаад хяналт тавих, банкны хэмжээнд ямар хэмжээний эрсдэл хүлээж байгааг хянах, хязгаарлах чиг үүргийг хүлээн хамтран ажиллаж байна.



#### **ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ, САНХҮҮЖИЛТ БОЛОН УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТТЭЙ ХОЛБООТОЙ УРАМШУУЛЛЫН БҮТЭЦ**

Голомт банкны тогтвортой хөгжил, тогтвортой санхүүжилт болон уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлтэй холбоотой зорилго, зорилтууд нь ажилтнууд болон нэгжүүдийн үнэлгээ, урамшууллын тогтолцоонд тусгагдсан бөгөөд Санхүүгийн удирдлагын газрын дэргэдэх Төлөвлөлт, үнэлгээний хэлтэс үүнд хяналт тавин ажиллаж байна.

#### **ХАГАС ЖИЛИЙН УРАМШУУЛАЛ**

Урамшуулал нь Байгууллагын банкны газар, Жижиг дунд банкны газар болон Иргэдийн банкны газруудын тогтвортой, ногоон багц бүрдүүлэх зорилттой тавигдсан билээ. Үүнээс гадна банкны хэмжээнд батлагдсан өөрийн үйл ажиллагаа, санхүүжилт болон хөрөнгө оруулалтаар дамжуулан ялгаруулж буй хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, СТОУС ТБ1 болон ТБ2 тайлагналын стандартын хэрэгжилтийн бэлэн байдлыг хангах болон банкны БОН өгөгдлийн чанар сайжруулах, автоматжуулах үзүүлэлтүүдийг нэмж тусган ажиллаж байна.

2025 оны БОН болон уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийн үнэлгээний үзүүлэлтүүд

Үзүүлэлт КРИ-д суусан хугацаа	Гүйцэтгэлийн хэмжүүр	Жин	Босго
2024Н1	Тогтвортой, ногоон зээлийн багц бүрдүүлэх	6% хүртэл	Тогтвортой хөгжил болон санхүүжилтийн хүрээнд тавьсан зорилго, зорилгоо хэрэгжүүлэх <ul style="list-style-type: none"> <li>• Нийт багцын 10%-ийг тогтвортой, ногоон болгох зорилт</li> <li>• Санхүүжилтээ Парисын хэлэлцээр, НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтуудтай (ТХЗ) уялдуулах банкны зорилт</li> </ul>
2025Н2	Өөрийн үйл ажиллагаанд ногоон шилжилт хийх (холбогдох удирдлагууд)	2%	Өөрийн үйл ажиллагаанд ногоон шилжилт хийх <ul style="list-style-type: none"> <li>• Тогтвортой хөгжлийн бодлогын баримт бичгийн хүрээнд: Эрчим хүчний хэмнэлт</li> <li>• Тогтвортой хөгжлийн бодлогын баримт бичгийн хүрээнд: Усны хэмнэлт</li> <li>• Тогтвортой, ногоон үйл ажиллагааны стандарт баримт бичгийн хүрээнд: Ногоон худалдан авалтыг нэмэгдүүлэх</li> </ul>
2025Н2	Уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийг бэхжүүлэх (холбогдох нэгжүүд)	1%	<ul style="list-style-type: none"> <li>• СТОУС ТБ1 болон ТБ2 хэрэгжилтийг хангах</li> </ul>
2025Н2	БОНЗ өгөгдлийн чанар сайжруулах	1%	<ul style="list-style-type: none"> <li>• Банкны БОНЗ-тай холбоотой Тогтвортой хөгжлийн тайланд үзүүлэлт болон тусгагддаг өгөгдлүүдийн чанарыг сайжруулах</li> </ul>

## БАНКНЫ УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХЭРЭГЖИЛТИЙН БЭЛЭН БАЙДАЛ

2025 онд шинээр батлагдсан Эрсдэлийн аппетитийн мэдэгдэлд тогтвортой хөгжил, уур амьсгалын өөрчлөлтийн хэмжүүрүүдийг нэвтрүүлэн баталсан. БОН-ийн эрсдэлийг стратегийн түвшинд үнэлж, тодорхойлох боломжтой болсон бөгөөд энэ нь эрсдэлийн удирдлагын тогтолцооны уялдаа, тогтвортой байдлыг нэмэгдүүлж, БОН-ийн үзүүлэлтүүдийг стратегийн зорилттой уялдуулан хэрэгжүүлэх, хянах суурийг тавьж өгсөн.

Тайлант хугацаанд Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/ ТБ1: Тогтвортой байдалтай холбоотой мэдээллийн ил тод байдлын ерөнхий шаардлага болон СТОУС ТБ2: Уур амьсгалтай холбоотой тодруулга стандартуудыг хэрэгжүүлэх бэлэн байдлын төлөвлөгөөний дагуу холбогдох нэгжүүд хэрэгжилтийг ханган улирал бүр Удирдлагын хороонд тайлагнаж байна. 2025 оны 12-р сарын 31-ний байдлаар хэрэгжилтийн бэлэн байдал СТОУС ТБ1-90%, СТОУС ТБ2-91%-тай байна. Банк 2026 оны тайланг СТОУС ТБ1 болон ТБ2 стандарттай бүрэн нийцүүлж тайлагнахаар зорин ажиллаж байна.

## ТУЗ-ИЙН ОЛОН ТАЛТ БАЙДАЛ

Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) нь банкны бүхий л стратегийн чиглэл, удирдлага, хяналтыг хариуцдаг. ТУЗ нь Аудитын хороо, Эрсдэлийн удирдлагын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Засаглал, Ёс зүй, Цалин урамшууллын хороо гэсэн дөрвөн байнгын хороотой. 2025 оны 12-р сарын 31-ний байдлаар ТУЗ нь нийт 4 энгийн, 5 хараат бус гишүүнтэй ажилласан байна.

## ХАРААТ БУС БАЙДАЛ



## ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙН ТУРШЛАГА БОЛОН МЭРГЭШИЛ

### МАНЛАЙЛЛЫН ТУРШЛАГА

Санхүүгийн салбар дахь гүйцэтгэх удирдлагын туршлага (>10 жил)	9
Хөрөнгийн биржид бүртгэлтэй компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүн	9
Хөрөнгө босгох, хувьцаа санал болгох	3

# ТУЗ-ИЙН ОЛОН ТАЛТ БАЙДАЛ

## МЭРГЭШИЛ

Хөрөнгө оруулалтын менежмент	3
Санхүү / аудит	2
Эрсдэл, хууль эрх зүй / нийцэл	2
Хүний нөөц, компанийн соёл	3
БОНЗ	3
Засгийн газар, зохицуулалтын байгууллага / академи	3
Эдийн засгийн шинжлэх ухаан	4
Бизнесийн удирдлага	7
Уул уурхай	2
Олон улсын харилцаа / Олон улсын эдийн засаг	4
Социологи	1

Холбоос: [ТУЗ-ийн гишүүд](#)

Засаглал, ТУЗ-ийн үйл ажиллагааны дэлгэрэнгүй мэдээллийг Жилийн тайлангаас авна уу.

## ДАВХАР МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

Банкны болон оролцогч талуудад хамааралтай БОНЗ, тогтвортой байдлын чухал үзүүлэлтүүдийг тодорхойлох давхар материаллаг байдлын үнэлгээг анх удаа хийн үр дүнг тайлагнаж байна. Давхар материаллаг байдал нь банкны бизнес болон оролцогч талуудад хамгийн өндөр хамааралтай, санхүүгийн байдалд нөлөө үзүүлэхүйц, анхаарал хандуулаагүйн улмаас богино, дунд, урт хугацаанд бизнесийн тогтвортой өсөлтөд нөлөө үзүүлж болзошгүй үзүүлэлтүүдийг хэлнэ.

## МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭГ ХИЙСЭН АЛХМУУД:

### Алхам 1:

Зорилго, хамрах хүрээг тодорхойлох

### Алхам 2:

Гол оролцогч талуудыг тодорхойлох

### Алхам 3:

Материаллаг үзүүлэлтүүдийг тодорхойлох

### Алхам 4:

Эрэмбэлэх

### Алхам 5:

Удирдлагын түвшинд баталгаажуулах

### Алхам 6:

Ил тод, нээлттэй тайлагнах

Материаллаг үзүүлэлтүүдийг тодорхойлоход MSCI, SASB, Дэлхийн эдийн засгийн форумаас жил бүр нийтэлдэг болзошгүй эрсдэлүүд 2025, дотоодын болон олон улсын банкнуудын жишиг үзүүлэлтүүдээс шинжлэн БОНЗ-ын нийт 20 үзүүлэлтийг тодорхойлон дотоод (нийт ажилтнууд, удирдлагын баг), гадаад (харилцагчид, хөрөнгө оруулагчид, дотоодын болон олон улсын байгууллагууд) оролцогч талуудаас судалгаа авав.

## ЗАСАГЛАЛ

- Бизнесийн ёс зүй
- Комплаенс
- Ил тод байдал
- Борлуулалт
- Улс төрийн тогтвортой байдал
- Эрсдэлийн удирдлага

## БАЙГАЛЬ ОРЧИН

- Байгаль орчны үл мөр
- Усны нөөцийн менежмент
- Хог хаягдлын менежмент
- Биологийн олон янз байдал
- Байгалийн гамшиг (өөрийн хөрөнгө)
- Байгалийн гамшиг (санхүүжилт, хөрөнгө оруулалт)
- Тойрог эдийн засаг
- Хариуцлагатай санхүүжилт, хөрөнгө оруулалт

## НИЙГЭМ

- МАБ
- Хувийн мэдээллийн нууцлал
- Хүний эрх, ялгаатай байдал, тэгш боломж
- Санхүүгийн хүртээмж
- Олон талт оролцоо
- Хүмүүн капитал

Давхар материаллаг байдлын үр дүнг нөлөөллийн материаллаг байдал болон санхүүгийн материаллаг байдлын үр дүнгээр тодорхойлж дараах 14 үзүүлэлтүүд ач холбогдол өндөр хэмээн үнэлэгдлээ. Давхар материаллаг байдлын үнэлгээний үр дүнг 2025 оны 12-р сарын 17-ны өдрийн Удирдлагын хорооны хурал болон 2025 оны 12-р сарын 23-ны өдрийн Тогтвортой хөгжлийн хороогоор тус тус танилцуулан батлуулав.



- ◆ Засаглалын үзүүлэлтүүд
- Нийгмийн үзүүлэлтүүд
- Байгаль орчны үзүүлэлтүүд

## 2030 БОЛОН 2050 ОНЫ ЗОРИЛГО

Голомт банкны хувьд санхүүжилтийн болон хөрөнгө оруулалтын үйл ажиллагаагаа Парисын хэлэлцээрийн зорилгуудтай уялдуулан дэлхийн дулаарлыг аж үйлдвэржилтийн өмнөх үетэй харьцуулахад 2 хэмээс хэтрүүлэхгүй байж, улмаар 1.5 хэмд хязгаарлах зорилттой нийцүүлэх зорилго зорилт тавин ажилласаар байна. Иймд Монгол Улсын Үндэсний Тодорхойлсон Хувь Нэмэр (ҮТХН) 2.0 баримт бичгийг харгалзан үзэж, бид 2030 он болон 2050 он гэхэд нийт зээлийн багцаар дамжуулан санхүүжүүлсэн болон өөрийн үйл ажиллагаанаас ялгаруулж буй хүлэмжийн хийн хэмжээг 30 хувь болон 50 хувиар тус тус бууруулах амбицлаг зорилгыг 2024 онд албан ёсоор батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

ЗОРИЛГО #1:  
Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах

ЗОРИЛГО #2:  
Усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөллийг  
бууруулах  
Тогтвортой усны нөөцийн удирдлагыг цогцлоох

2030 онд ↓ 30%

2030 онд ↓ 5%



 **ГОЛОМТ БАНК**  
*Сайн сайхныг санхүүжүүлнэ*

УСНЫ ЭЛЧ  
БАНК

ТОГТВОРТОЙ, НОГООН САНХҮҮЖИЛТ

Уур амьсгалын өөрчлөлт нь нэг талаас зээлийн багцад эрсдэл бий болгодог ч нөгөөтэйгөөр банк санхүүгийн байгууллага нь олгож буй санхүүжилтээрээ дамжуулан эерэг нөлөөлөл авчрах боломжтой. Иймд Голомт банк тогтвортой, ногоон санхүүжилтийн бүтээгдэхүүн, үйлчилгээг харилцагчдадаа санал болгох замаар ногоон бизнесийн шилжилт хийх шинэ боломжуудыг нээн ажиллаж байна.

## ТОГТВОРТОЙ, НОГООН ЗЭЭЛИЙН БАГЦ

**1.1** ИХ НАЯД  
ТӨГРӨГ

Нийт ногоон зээлийн олголт

(2019Q3-2025Q4)

**4.9%** НОГООН  
ЗЭЭЛИЙН  
БАГЦЫН ХУВЬ  
**406** ТЭРБУМ  
ТӨГРӨГ

/2025.12.31 ногоон зээлийн үлдэгдэл/

**17.4%**

/зах зээлд эзлэх хувь/

## НИЙГЭМД ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨЛӨЛ

**4,477** ажлын  
байр

ЭМЭГТЭЙ 48%

**205** ТЭРБУМ  
ТӨГРӨГ




2025 оны 12-р сарын 31-ны байдлаар банк нийт ногоон зээлийн багцаар дамжуулан 4,477 ажлын байр, 205 тэрбум төгрөгийн нэмүү өртгийг хадгаламж, татвар болон цалин хэлбэрээр бий болгон тогтвортой хөгжлийн зорилгуудад хувь нэмрээ оруулсаар байна. Нийгэмд үзүүлж буй нөлөөллийг Joint Impact Model /JIM/-ын хэрэгслийг ашиглан гаргав.

## ТОГТВОРТОЙ, НОГООН ЗЭЭЛИЙН БАГЦ

Банк нь 2030 он гэхэд нийт зээлийн багцын 10%-ийг тогтвортой, ногоон зээлийн багцаар бүрдүүлэх зорилтыг тавин ажиллаж байна. Үүний хүрээнд өнгөрсөн зургаан жилийн хугацаанд нийт 1.1 их наяд төгрөгийн тогтвортой, ногоон санхүүжилтийг олгосон байна. Үүнээс 2025 онд нийт 270 (2024: 308 тэрбум төгрөг) тэрбум төгрөгийн ногоон санхүүжилт олгосон ба 2025 оны 12-р сарын 31-ний байдлаарх тогтвортой, ногоон зээлийн багц 406 (2024: 265 тэрбум төгрөг) тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.


2030 он хүртэлх ногоон зээлийн багцын төлөвлөгөө



Банкны ногоон зээлийн багцын бүрдлийг ангилан харвал эрчим хүчний хэмнэлт, тогтвортой хөдөө аж ахуй, тогтвортой ус, хог хаягдлыг дэмжих санхүүжилт нь 97.9%-ийг бүрдүүлж байна.

Таксономийн ангилал	2025 (%)	2024 (%)	2023 (%)
Сэргээгдэх эрчим хүч	0.57	-	-
Карбон бага ялгаруулдаг тээвэр	1.15	1.91	0.66
Эрчим хүчний хэмнэлт	68.76	64.35	52.41
Ногоон барилга	0.08	-	-
Бохирдол багатай эрчим хүч	-	0.11	0.41
Тогтвортой ХАА, газар ашиглалт, ой болон эко аялал зуучлал	24.21	21.92	41.89
Тогтвортой ус, хаягдлын хэрэглээ	4.93	11.26	4.62
Бохирдлоос сэргийлэх, бууруулах үйл ажиллагаа	0.30	0.45	-

Ногоон зээлийн багц, сегментээр



## 1. ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТ (2025: 68.76%)

Доод тал нь 20 хувийн эрчим хүчний хэмнэлт гарган баталгаажуулсан дараах санхүүжилтүүд орно. Үүнд:

- Эрчим хүчний хэмнэлттэй орон сууц, үйлчилгээ, оффисын барилга барих,
- Эрчим хүчний хэмнэлттэй тоног төхөөрөмж, гэр ахуйн цахилгаан бараа худалдаж авах,
- Эрчим хүчний хэмнэлттэй орон сууц, үйлчилгээний талбай худалдаж авах санхүүжилтүүд багтсан болно.


## 2. ТОГТВОРТОЙ ХАА, ГАЗАР АШИГЛАЛТ, ОЙ БОЛОН ЭКО АЯЛАЛ ЗУУЧЛАЛ (2025: 24.21%)

Таксономийн шалгуур ханган баталгаажсан тогтвортой ханган нийлүүлэлтийн сүлжээтэй, тойрог бизнесийн модельтой төслүүд болон биологийн төрөл зүйлийг хамгаалах санхүүжилтүүд орно.


## 3. ТОГТВОРТОЙ УС, ХОГ ХАЯГДЛЫН ХЭРЭГЛЭЭ (2025: 4.93%)

- Доод тал нь 20 хувийн усны хэмнэлт бий болгох тоног төхөөрөмж худалдан авах,
- Усны хүртээмжийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа,
- Үер, усны аюулаас сэргийлсэн далан барих,
- Хаягдал ус цэвэрлэх байгууламж барих,
- Аюултай болон аюулгүй хог хаягдлыг МУ-ын журам, стандартын дагуу цуглуулах /тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах/ санхүүжилтүүд орно.

### Эх үүсвэрээр (2025)



### Байршлаар (2025)



# ТОГТВОРТОЙ, НОГООН ЗЭЭЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН

## ТОГТВОРТОЙ, НОГООН ЗЭЭЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН

Голомт банк харилцагчдынхаа хэрэгцээ шаардлагад нийцүүлэн тогтвортой, ногоон зээлийн бүтээгдэхүүний сонголтыг тогтмол нэмэгдүүлж байна.

### БИЗНЕСИЙН ЗЭЭЛ:

	Хүү (сар)	Дээд хэмжээ	Хугацаа (сар)
Тогтвортой, ногоон бизнесийн зээл	1.3% - 1.6%	5-10 тэрбум төгрөг	30-84
Хүү хуваан төлөх нөхцөлтэй ногоон зээл	1.3% - 1.6%	5-10 тэрбум төгрөг	84
Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих зээл	1.3% - 1.6%	ЭХЗ - 500 сая төгрөг хүртэл, ХОЗ - 1 тэрбум төгрөг хүртэл	36

### ИРГЭДИЙН ЗЭЭЛ:

	Хүү (сар)	Дээд хэмжээ	Хугацаа (сар)
Ногоон АОС зээл	EDGE Certified: Бодлогын хүү+4%, EDGE Advanced болон CARBON ZERO: Бодлогын хүү+2%	160-300 сая төгрөг	120-240
Автомашинны ногоон зээл	1.3%-1.6%	Бүтээгдэхүүний үнийн дүнгээс хамаарна	30-96
Ногоон хэрэглээний зээл	1.3%-1.6%	20 сая төгрөг	30
Эрчим хүчний хэмнэлттэй орон сууц, Амины орон сууцны зээл	1.3%-1.4%	Худалдан авч буй ОС, АОС-ны жишиг үнийн дүнгийн 80%- 100% хүртэл	240

## ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН: ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТТЭЙ ОС, АОС



Голомт банк харилцагчдынхаа хэрэгцээ шаардлагад нийцүүлэн тогтвортой, ногоон зээлийн бүтээгдэхүүний сонголтыг нэмэгдүүлж “Эрчим хүчний хэмнэлттэй орон сууц, амины орон сууцны зээл”-ийн бүтээгдэхүүнийг 2025 онд шинээр нэвтрүүлэв. Ингэснээр иргэд орон сууц худалдан авахдаа эрчим хүчний хэмнэлттэй орон сууц сонгож, эрчим хүчний хэмнэлт үүсгэх, цаашлаад хүлэмжийн хийг бууруулахад хөрөнгө оруулах боломж бүрдлээ. Мөн Голомт банк эрчим хүчний хэмнэлттэй орон сууц барьж буй төслүүдтэй хамтран ажиллаж байна.

### 2025 ОНД:



14 ЭХХ<sub>-тэй</sub>

орон сууц, амины орон сууцтай  
хамтран ажиллах гэрээ байгуулж




17 ТЭРБУМ

төгрөгийн ногоон зээлийг



80

иргэнд олгосон байна.



### СУРГАЛТ

Голомт банк харилцагчдаа ногоон шилжилт хийхийг уриалж, тогтвортой, ногоон санхүүжилтийн сургалт, арга хэмжээг тогтмол зохион байгуулдаг. 2025 онд нийт 16 байгууллагад ганцаарчилсан ногоон санхүүжилтийн сургалтыг орсон ба 5 удаагийн арга хэмжээгээр дамжуулан тогтвортой хөгжлийн үндсэн ойлголтыг таниулах, бизнестээ ногоон шийдэл нэвтрүүлэх боломжуудын талаар сургалтыг нийт 89 байгууллагад орсон байна. Банк харилцагчдадаа ногоон шилжилтийг дэмжих санхүүгийн болон санхүүгийн бус шийдлүүдийг санал болгон хүлэмжийн хий багатай тогтвортой ирээдүйд шилжихэд нягт хамтран ажиллаж байна.

# ТОГТВОРТОЙ, НОГООН ЭХ ҮҮСВЭР

## ТОГТВОРТОЙ, НОГООН ЭХ ҮҮСВЭР

Голомт банк 2025 онд тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд ногоон болон цэнхэр санхүүжилт, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, бууруулахад чиглэсэн эх үүсвэрүүдийг амжилттай татан төвлөрүүлэв.



**179 САЯ**  
АМ.ДОЛЛАР



SAISON  
Investment Management

## НОГООН, НИЙГМИЙН БОНДЫГ ЛЬЮКСЕМБУРГИЙН ХӨРӨНГИЙН БИРЖ ДЭЭР ГАРГАЛАА

**50 САЯ**  
ам.доллар

ногоон болон нийгмийн бонд

**164** аж ахуйн  
нэгж, иргэд



ногоон санхүүжилт

**33** аж ахуйн  
нэгж, иргэд



нийгмийн санхүүжилт

Голомт банк олон улсын зах зээлд жилийн 8%-ийн хүүтэй, 50 сая ам.долларын ногоон болон нийгмийн бонд гаргасан ба энэхүү бонд нь Монголын корпорейт байгууллагаас олон улсын зах зээлд гаргасан хамгийн хямд өртөгтэй бонд болсон. Ногоон болон Нийгмийн бондын 50 сая ам.доллар буюу нийт 170 тэрбум төгрөгийг Монгол Улсын Ногоон Таксономи болон Голомт банкны Тогтвортой санхүүжилтийн хамрах хүрээ баримт бичгийн дагуу 2025 оны эхний хагаст бүрэн зарцуулж дууссан байна.

Бондын санхүүжилтээр дамжуулан эрчим хүчний хэмнэлттэй орон сууц, тогтвортой хөдөө аж ахуй, тогтвортой ус, хаягдлын менежментийг дэмжих, цахилгаан тээврийн хэрэгсэл зэрэг нийт давхардсан тоогоор 164 аж ахуйн нэгж, иргэд болон эрүүл мэнд, боловсролын хүртээмжийг нэмэгдүүлж буй нийт давхардсан тоогоор 33 аж ахуйн нэгж, иргэдэд санхүүжилт олгож харилцагчдын ногоон, тогтвортой ирээдүйг дэмжих төсөл, хөтөлбөрүүдийг дэмжин ажиллаа.

## САНХҮҮГИЙН БОЛОН САНХҮҮГИЙН БУС “ЦЭНХЭР” САНААЧИЛГУУД

**УСНЫ  
НӨӨЦ**



**2030: 5%  
2050: 10%**

6

САТАГГАТ ИЙДЭН-УС  
АРХИТ ЦЭВРИЙН  
САЙГУУЛАГАА  
ХАЙГАХ



2025 ОНД ШИНЭЭР ТАТСАН  
ЦЭНХЭР САНХҮҮЖИЛТИЙН  
ЭХ ҮҮСВЭР

**32 САЯ**  
АМ.ДОЛЛАР


Голомт банк өөрийн болон харилцагчийн усны менежментэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах дунд болон урт хугацааны зорилттой билээ. Энэхүү зорилтод хүрч, тогтвортой усны нөөцийн менежментийг бэхжүүлэхийн тулд оролцогч талуудтай хамтын ажиллагааны цар хүрээгээ тэлж, бодит алхмуудыг хийсээр байна.



Тогтвортой усны нөөцийн  
удирдлагыг бэхжүүлэх



Ус, ариун цэврийн  
хүртээмжийг нэмэгдүүлэх



### МОНГОЛ ДАХЬ АНХНЫ ЦЭНХЭР САНХҮҮЖИЛТ

Олон улсын санхүүгийн корпораци (ОУСК)-иас Голомт банканд олгож буй 160 сая ам.долларын санхүүжилтийн 24 сая ам.доллар нь Монгол улсын тогтвортой усны нөөцийн менежментийг бэхжүүлэх, байгаль орчинд ээлтэй, тогтвортой хөгжлийг дэмжих, мөн жижиг, дунд үйлдвэрлэгчдийг дэмжихэд чиглэгдэнэ. Энэхүү санхүүжилт нь ОУСК-иас Монгол Улсын санхүүгийн салбарт олгосон анхны “цэнхэр хөрөнгө оруулалт” гэдгээр онцлог, өндөр ач холбогдолтой түншлэл юм. ОУСК-иас цэнхэр зээлийн онцлог, шалгуурыг дотоодын зах зээлд таниулахад зориулан техник туслалцааны хөтөлбөрийг мөн хамтран хэрэгжүүлнэ.



### УСНЫ ЭЛЧ БАНК

Дэлхийн усны өдрийг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар зохион байгуулсан “Цэнхэр Алт-2” үндэсний чуулга уулзалтын үеэр Голомт банк 2025 оны “Усны элч” банкаар нэрлэгдсэн билээ. Мөн Голомт банк болон Засгийн Газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газар хамтын ажиллагааны санамж бичгийг сунган 2 дахь жилдээ хамтран ажиллаж байна.



### ТЕХНИК ТУСЛАЛЦАА






Дэлхийн уур амьсгалын хамтын ажиллагааны сан (GCPF)-аас Голомт банкны үйлдвэрлэл эрхлэгч харилцагчдад “Урьдчилан цэвэрлэх байгууламж барих” чиглэлээр техник туслалцааг үзүүлж эхлээд байна. Техник туслалцааны хүрээнд Монгол Улсын нөхцөл болон тухайн бизнесийн онцлогт нийцүүлэн урьдчилан цэвэрлэх байгууламжийн техник, технологийн судалгаа, зөвлөмжийг үнэ төлбөргүй хүргэх юм.

Энэхүү санаачилга нь хаягдал усны менежментийг сайжруулах, улмаар усны нөөцийг хамгаалах, гол мөрөн, хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөг багасгах ач холбогдолтой юм.

# БИДНИЙ ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ

## БИДНИЙ ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ


Бид тогтвортой, ногоон санхүүжилтээр дамжуулан байгаль орчин, нийгэм, эдийн засагт эерэг нөлөөллийг харилцагчидтайгаа хамтран бий болгож байна. 2025 оны 4-р улирлын байдлаар нийт 279 зээлийн данс үлдэгдэлтэй байгаа ба Тогтвортой, ногоон санхүүжилтийн эерэг нөлөөллийг хэмжин дараах санхүүжилтүүдийг онцолж байна.

Харилцагч	Зээлийн зориулалт	Таксономийн ангилал	Санхүүжүүлсэн дүн /төгрөг/	Эерэг нөлөө	Хамаарах ТХЗ
Мон-Ирээдүй ХХК	Германы Трамплер брэндийн DYTAN био химийн бодис худалдан авах	6.1.1 Ус хэмнэх, хэрэглээг хянах, хадгалах, хуваарилах технологи болон системүүд	4 тэрбум ₮	Харилцагч нь 2022 оноос эхлэн хаягдал ус цэвэрлэх байгууламжтай болсон бөгөөд Германы Trumpler компанийн DYTAN био химийн бодисыг ашигладаг. Үйлдвэрлэлд шаардагдах <b>усны хэрэглээ 2023 онд 28.22%, 2024 онд 54.92%-иар буурсан</b> байна.	
Этүгэн их сургууль	Эрчим хүчний хэмнэлттэй бага сургууль барих	3.3.1 Эрчим хүчний хэмнэлттэй шинэ барилга барих	30 тэрбум ₮	Улаанбаатар хотын баруун өмнөд хэсэгт 1,100 хүүхдийн багтаамжтай, <b>31%-ийн эрчим хүчний хэмнэлттэй</b> , таван давхар, хоёр блоктой цогцолбор барих ба жилд бууруулах хүлэмжийн хийн ялгарал <b>307тнCO2e</b> .	
Хидро Инженеринг ХХК	Загас үржүүлгийн лабораторийн тоног төхөөрөмж худалдан авах	7.2.4 Биологийн олон янз байдал болон экосистемийг хамгаалах	500 сая ₮	Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт <b>400,000 - 500,000 ховордсон загас</b> үржүүлэх, биологийн олон янз байдлыг хамгаалах, амьдрах орчныг бүрдүүлэх ашиг тустай.	
КТК ХХК	"Эрдэнэтийн уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй байдлын төсөл"-ийн хүрээнд ус хадгалах байгууламж, суваг/ус зайлуулах хоолой барих	6.1.1 Ус хэмнэх, хэрэглээг хянах, хадгалах, хуваарилах технологи болон системүүд	2.5 тэрбум ₮	Эрдэнэт хотод <b>12 километр</b> үерийн хамгаалалтын далан барих, 8 ус зайлуулах сүлжээ, 4 усан сангийн системийн байгууламжийг барьж ойр орчмын иргэдийг үерийн аюулаас хамгаална.	
Рара Авис Адвентур ХХК	Нарны хавтан болон тэдгээрийн эрчим хүчний эх үүсвэрүүд худалдан авах	1.2.2 Жижиг хэмжээний нарны цахилгаан үүсгүүр	1 тэрбум ₮	Аяллын баазуудыг илүү тогтвортой болгохын тулд нарны хавтан болон халаалтын эрчим хүчний эх үүсвэрүүд, мөн био жорлон, ариун цэврийн байгууламж барьж <b>тогтвортой аялал жуулчлалын</b> менежментийг ханган ажиллаж байна.	

# САНХҮҮЖҮҮЛСЭН ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРАЛ

## САНХҮҮЖҮҮЛСЭН ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРЛЫГ БУУРУУЛАХ ЗАМНАЛ

Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаанаас үүдэх санхүүжүүлсэн ялгарлыг бууруулах замнал  
(нэг сая төгрөг тутамд ногдох тнCO2e)



Банк нь санхүүжүүлсэн ялгарлыг 2023 оны суурь түвшнээс 2030 он гэхэд 30%, 2050 он гэхэд 50% тус тус бууруулах амлалт өгөөд байна. Банкны бизнесийн тэлэлт болон зээлийн багцын өсөлттэй уялдан нийт хүлэмжийн хийн ялгарлын хэмжээ нэмэгдэх хандлагатай тул санхүүжүүлсэн ялгарлын өсөлт болон бууралтыг бид интенсити үзүүлэлтээр (нэг сая төгрөг тутамд ногдох тнCO2e) хянаж байна.

2025 онд нийт санхүүжүүлсэн ялгарлын интенсити хөрөнгийн ангилал тус бүрт буурсан ба 2023 оны суурь онтой харьцуулахад нийт 8%-иар буурсан үзүүлэлттэй байна. Харин хөрөнгө оруулалтын хувьд, Засгийн газрын бонд, үнэт цааснаас үүдэх хүлэмжийн хийн ялгарлын интенсити цаашид ч өсөх үзүүлэлттэй байгаа ба Банк хяналт хийх, бууруулах арга хэмжээг эрэлхийлэх болно.

PCAF хөрөнгийн ангилал	Өгөгдлийн чанар (Өндөр = 1, Бага = 5)		Хүлэмжийн хийн ялгарлын интенсити (тнCO2e/сая төгрөг)		
	2025	2025	2024	2023 (суурь он)	2023 суурь он болон 2025 оны харьцуулалт
Бизнесийн зээл	3	0.14	0.17	0.16	-13%
Орон сууцны зээл	4	0.04	0.04	0.05	-20%
Үйлчилгээний зориулалттай үл хөдлөх хөрөнгийн зээл	4	0.13	0.15	0.15	-13%
Автомашинны зээл	4	0.02	0.04	0.04	-50%
Төслийн санхүүжилт	-	-	0.07	0.23	-
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	3.35	0.11	0.13	0.12	-8%
Засгийн газрын өр	1	0.43	0.39	0.39	10%
Биржид бүртгэлтэй хувьцаа болон компанийн бонд	4	0.06	0.08	0.05	20%
Өрийн болон өмчийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт	1.4	0.39	0.35	0.33	18%

# САНХҮҮЖҮҮЛСЭН ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРАЛ

Голомт Банк нь хамрах хүрээ 3 ангилал 15 буюу санхүүжүүлсэн ялгарлыг Partnership for Carbon Accounting Financials (PCAF)-ийн аргачлалын дагуу ангилан тооцоолж байна. 2025 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар нийт санхүүжилтээр дамжуулан ялгаруулсан хүлэмжийн хийн хэмжээ 662,926 тнCO<sub>2</sub>e (2023 суурь он: 447,590 тнCO<sub>2</sub>e), хөрөнгө оруулалтаар дамжуулан ялгаруулсан хүлэмжийн хийн хэмжээ 1,462,352 тнCO<sub>2</sub>e (2023 суурь он: 582,892 тнCO<sub>2</sub>e) байна. PCAF удирдамжийн дагуу иргэдийн хэрэглээний зээлийн багц нь тооцооллоос хасагдсан тул банкны тайлант оны нийт багцын 75% (2023 суурь он: 76%)-ийг хамруулж санхүүжүүлсэн ялгарлыг тооцоолов. Банкны нийт санхүүжүүлсэн ялгарлын дийлэнх буюу 86% (2023 суурь он: 84%)-ийг бизнесийн зээлийн багц бүрдүүлж байна.



## PCAF хөрөнгийн ангилал

### Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа

	2025	2024	2023 (суурь он)
PCAF хөрөнгийн ангилал	Санхүүжүүлсэн ХХЯ (тнCO <sub>2</sub> e)	Санхүүжүүлсэн ХХЯ (тнCO <sub>2</sub> e)	Санхүүжүүлсэн ХХЯ (тнCO <sub>2</sub> e)
 Бизнесийн зээл	570,493	646,390	377,452
 Орон сууцны зээл	60,242	58,486	52,119
 Үйлчилгээний зориулалттай үл хөдлөх хөрөнгийн зээл	20,359	15,991	10,461
 Автомашины зээл	11,832	6,902	5,223
 Төслийн санхүүжилт	-	736	2,334
<b>Нийт</b>	<b>662,926</b>	<b>728,506</b>	<b>447,590</b>

# САНХҮҮЖҮҮЛСЭН ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРАЛ

## Өрийн болон өмчийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт

	2025	2024	2023 (суурь он)
PCAF хөрөнгийн ангилал	Санхүүжүүлсэн ХХЯ (тнCO2e)	Санхүүжүүлсэн ХХЯ (тнCO2e)	Санхүүжүүлсэн ХХЯ (тнCO2e)
 Засгийн газрын өр	1,430,798	1,012,064	564,521
 Биржид бүртгэлтэй хувьцаа болон компанийн бонд	31,554	32,765	18,371
<b>Нийт</b>	<b>1,462,352</b>	<b>1,044,829</b>	<b>582,892</b>

2024 онд хүлэмжийн хийн ялгарлын тооцооллыг PCAF-ийн аргачлалд бүрэн нийцүүлэн сайжруулж, корпорэйт харилцагчдын өр төлбөр болон эздийн өмчийн мэдээллийг ашиглан банкны хамаарлыг тодорхойлж, ХХЯ-ыг нарийвчлан тооцоолсон. Үүний үр дүнд 2023 суурь оны тооцооллыг ижил аргачлалаар дахин тооцоолж шинэчлэн тодорхойлсон болно. Дэлгэрэнгүй мэдээллийг "Тогтвортой хөгжлийн тайлан 2024"-өөс авна уу.

Банк нь 2024 оноос эхлэн PCAF ангиллын засгийн газрын өр, худалдан авсан бонд, хувьцаа ангиллын буюу хөрөнгө оруулалтаас үүдэх ялгарлыг тооцоолж эхэлсэн. Хөрөнгө оруулалтаас үүдэх ялгарлыг бууруулах зорилт албан ёсоор батлаагүй боловч Банк нь холбогдох хяналтыг тогтмол хийн ажиллах болно.

# САНХҮҮЖҮҮЛСЭН ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРАЛ

## ХХЯ ӨНДӨР САЛБАРУУД БА БУУРУУЛАХ НАРИЙВЧИЛСАН ТӨЛӨВЛӨГӨӨ

Банкны тодорхойлсон хүлэмжийн хий ихээр ялгаруулдаг салбаруудын санхүүжүүлсэн ялгарлын хэмжээ 518,871 тнCO<sub>2</sub>e (2023: 352,220 тнCO<sub>2</sub>e and 2024: 592,559 тнCO<sub>2</sub>e) байна.



Хөдөө аж ахуй

66,696 тнCO<sub>2</sub>e



Эрчим хүчний хуваарилалт  
ба дамжуулалт

30,367 тнCO<sub>2</sub>e



Уул уурхай

207,780 тнCO<sub>2</sub>e



Тээвэр ба агуулах

6,038 тнCO<sub>2</sub>e



Боловсруулах үйлдвэрлэл

88,184 тнCO<sub>2</sub>e



Барилга ба үл хөдлөх

119,805 тнCO<sub>2</sub>e

Дэлгэрэнгүй мэдээллийг “Уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэл” хэсгээс авна уу.

# САНХҮҮЖҮҮЛСЭН ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРАЛ

## ХХЯ өндөр салбаруудын ялгарлын интенсити харьцуулалт

ХХЯ өндөр салбарууд	2025			2024			2023 (суурь он)			2023 ба 2025 онуудын харьцуулалт [тнCO2e/сая. төг]
	Үлдэгдэл [сая.төг]	Санхүүжүүлсэн ХХЯ [тнCO2e]	Ялгарлын интенсити [тнCO2e/сая.төг]	Үлдэгдэл [сая.төг]	Санхүүжүүлсэн ХХЯ [тнCO2e]	Ялгарлын интенсити [тнCO2e/сая.төг]	Үлдэгдэл [сая.төг]	Санхүүжүүлсэн ХХЯ [тнCO2e]	Ялгарлын интенсити [тнCO2e/сая.төг]	
Хөдөө аж ахуй	103,435	66,696	0.64	53,753	47,480	0.88	21,223	13,461	0.63	2%
Уул уурхай	588,888	207,780	0.35	638,524	330,156	0.52	321,181	163,074	0.51	-31%
Боловсруулах үйлдвэрлэл	441,649	88,184	0.20	276,821	64,683	0.23	328,087	76,169	0.23	-13%
Эрчим хүчний хуваарилалт ба дамжуулалт	64,422	30,367	0.47	61,843	35,051	0.57	17,087	9,528	0.56	-16%
Барилга	575,325	50,383	0.09	362,529	38,378	0.11	280,526	29,256	0.10	-10%
Тээвэр ба агуулах	127,574	6,038	0.05	144,226	10,230	0.07	53,273	3,646	0.07	-29%
Үл хөдлөх	1,678,550	69,422	0.04	1,475,928	66,581	0.05	1,088,462	57,085	0.05	-20%
<b>Нийт</b>	<b>3,579,843</b>	<b>518,871</b>	<b>0.14</b>	<b>3,013,624</b>	<b>592,559</b>	<b>0.20</b>	<b>2,109,838</b>	<b>352,220</b>	<b>0.17</b>	<b>-18%</b>

# САНХҮҮЖҮҮЛСЭН ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРАЛ

2025 онд хүлэмжийн хий ихээр ялгаруулдаг салбаруудын ялгарлын интенсити салбар тус бүрт буурсан үзүүлэлттэй байна. Нийт ялгарлын интенсити 2023 суурь онтой харьцуулахад 18 хувиар буурсан байна.

Банк хүлэмжийн хий ихээр ялгаруулдаг салбаруудтай ногоон шилжилт хийхэд хэрхэн хамтран ажиллах тухай дотоодод ашиглах “Шилжилтийн төлөвлөгөө хэрэгжүүлэх заавар”-г Олон Улсын “Transition Plan Taskforce” /TPT/ болон “Glasgow Financial Alliance for Net Zero” (GFANZ)-аас гаргасан аргачлалын дагуу боловсруулаад байна. Энэхүү тайлангийн Уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэл хэсгээс дэлгэрэнгүй мэдээлэл авна уу.

Мөн, Голомт банк нь санхүүжүүлсэн хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтийн шилжилтийн эрсдэлийг удирдах зорилгоор анх удаа дотоод карбон үнийг баталж зээлийн болон хөрөнгө оруулалтын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж эхэллээ. Ингэснээр, тогтвортой ногоон санхүүжилтийг эрчимжүүлэх, харилцагчдын ногоон бизнесийн шилжилтийг дэмжих, уур амьсгалын өөрчлөлтийн шилжилтийн эрсдэлийг удирдах боломжтой болохоос гадна санхүүжүүлсэн хүлэмжийн хийн ялгарлаа бууруулах зорилгын хэрэгжилтийг хангахад хөшүүрэг болж байна.

## Зайлсхийсэн ялгарал

Голомт банк 2025 оны 1-р сарын 2-ны өдөр Люксембургийн хөрөнгийн бирж дээр ногоон, нийгмийн бондыг гаргаж, 50 сая ам.долларын санхүүжилтийг амжилттай татан төвлөрүүлсэн билээ. Бондын эх үүсвэрийг эрчим хүчний хэмнэлт, тогтвортой хог хаягдлын менежмент, байгалийн нөөцийн тогтвортой менежмент болон карбон бага тээвэр зэрэг Монгол Улсын ногоон таксономи болон Банкны Тогтвортой санхүүжилтийн хамрах хүрээ баримт бичгүүдэд нийцүүлэн бүрэн зарцуулсан байна. Эрчим хэмнэлт болон карбон бага тээврийн ангилалд олгосон санхүүжилтээр дамжуулан зайлсхийсэн ялгарлыг тооцоолсон болно. Дэлгэрэнгүй мэдээллийг банкны цахим хуудсанд байрлах [Бондын нөлөөллийн тайлан](#)-аас авна уу.

Ногоон бондын хүрээнд, эрчим хүчний хэмнэлт болон цахилгаан автомашины ангилалд олгосон санхүүжилтээр дамжуулан жилд 32,345 тнCO<sub>2e</sub> хүлэмжийн хий ялгарахаас сэргийлсэн байна.

Ангилал	Олгосон дүн (сая.төгрөг)	Жилийн бууруулсан эсвэл зайлсхийсэн ХХЯ (тнCO <sub>2e</sub> )	Ялгарлын интенсити (тнCO <sub>2e</sub> /сая төгрөг)
Эрчим хүчний хэмнэлт	74,819	1,606	0.02
Карбон бага ялгаруулдаг тээвэр	393	30,739	78.22
<b>Нийт</b>	<b>75,212</b>	<b>32,345</b>	<b>0.43</b>

Нэмэлтээр тэмдэглэхэд, Голомт Банк нь тайлант хугацаанд зайлсхийсэн ялгарлыг нийт санхүүжүүлсэн ялгарлын тооцооллод тусгаагүй бөгөөд хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилттой хэрхэн зөв уялдуулах, зайлсхийсэн ялгарлыг тооцоолон тайлагнахад зориулсан аргачлалыг боловсруулахаар ажиллаж байна

 **ГОЛОМТ БАНК**  
*Сайн сайхныг санхүүжүүлнэ*

УСНЫ ЭЛЧ  
БАНК

ТОГТВОРТОЙ, НОГООН ҮЙЛ АЖИЛЛАГАА

# ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРЛЫН ТООЦООЛОЛ

2030

**-30%**

Голомт банк өөрийн үйл ажиллагаанаас үүдэлтэй ХХЯ-ыг бууруулах, нөөцийг хариуцлагатай, тогтвортой ашиглах замаар байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг багасгах үүрэг хариуцлагыг хүлээн ажиллаж байна. Үүний хүрээнд бид өөрсдийн үйл ажиллагаанаас ялгаруулж буй хүлэмжийн хийн хэмжээг 2030 он болон 2050 он гэхэд 30 болон 50 хувиар тус тус бууруулах зорилтуудыг баталсан юм.

## ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРЛЫН (ХХЯ) ТООЦООЛОЛ

2023 суурь оны тооцоололд ашиглаж буй өгөгдлүүд:



ХАМРАХ ХҮРЭЭ 1



ХАМРАХ ХҮРЭЭ 2



ХАМРАХ ХҮРЭЭ  
3 (БУСАД)

Хамрах хүрээ 1	Хамрах хүрээ 2	Хамрах хүрээ 3 (Бусад)
<p>Шууд ялгарал</p> <ul style="list-style-type: none"> <li>Улаанбаатарын оффисын өөрийн эзэмшлийн тээврийн хэрэгслийн түлшний зарцуулалт</li> </ul>	<p>Шууд бус ялгарал</p> <p>Байршилд суурилсан арга</p> <ul style="list-style-type: none"> <li>Нийт 4 оффисын эрчим хүч /Төв оффис, 2-р оффис, 3-р оффис, Парк Плэйс/</li> <li>Нийт 3 оффисын дулаан /Төв оффис, 2-р оффис, 3-р оффис/</li> </ul>	<p>Шууд бус ялгарал</p> <ul style="list-style-type: none"> <li>Категори 5: Хог хаягдал – дахин боловсруулах боломжтой картон цаас, хуванцар, шил, хуруу зай, усны ашиглалт болон бусад хог хаягдлыг хамруулж байна.</li> <li>Категори 6: Бизнес томилот – зөвхөн агаараар зорчсон гадаад болон дотоод томилотууд</li> <li>Категори 7: Ажилтнуудын маршрут – Ажилтнуудын гэр-ажил-гэр хооронд зорчиж буй тээврийн хэрэгслийн төрөл, зай (км), 7 хоногт ажилласан цаг</li> </ul>

Хүлэмжийн хийн тооцооллын протоколын (GHG Protocol) стандарт болон Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг засгийн газар хоорондын зөвлөл (IPCC)-өөс гаргасан зөвлөмж

## ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРЛЫН ТООЦООЛОЛ

Банк 2024 оноос хойш дата өгөгдлийн чанар, бүртгэлийг сайжруулж байгаатай холбоотой суурь оны өгөгдлөөс гадна шинэ өгөгдлүүдийг оруулсан тооцооллыг дотоодод ашиглах зорилгоор давхар тооцоолон тайлагнаж байна. “Хүлэмжийн хийн тооцооллын тодруулга” хэсгээс дэлгэрэнгүй танилцана уу.

**БАНК ӨӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС ЯЛГАРУУЛЖ БҮЙ ХҮЛЭМЖИЙН ХИЙН ХЭМЖЭЭГ ДАРААХ БАЙДЛААР АНГИЛАН ТООЦООЛЖ БАЙНА.**

	2025 /тнCO2e/	2024 /тнCO2e/	2023 /тнCO2e/ Суурь он
<b>Хамрах хүрээ 1</b>	<b>234,961.16</b>	<b>96,165.07</b>	<b>231,794.22</b>
Бензин	99,505.54	62,654.13	123,395.10
Дизель	135,455.62	33,476.45	108,399.12
Хөргөгч, хөргүүр	-	0.41	-
Агааржуулагч	-	34.07	-
<b>Хамрах хүрээ 2 (байршилд суурилсан)</b>	<b>1,012.21</b>	<b>4,909.61</b>	<b>1,159.82</b>
Эрчим хүч	715.47	2,627.67	881.30
Оффис	715.47	830.95	881.30
Салбарууд	-	1,796.72	-
Дулаан	296.74	2,281.93	278.52
Оффис	296.74	667.56	278.52
Салбарууд	-	1,614.37	-
<b>Хамрах хүрээ 3 (бусад)</b>	<b>2,014.95</b>	<b>2,447.88</b>	<b>2,506.73</b>
С5: Хог хаягдал	1,711.33	2,050.77	2,175.73
С6: Гадаад томилот	155.27	166.24	145.44
С7: Ажилтнуудын гэр-ажил маршрут	148.36	230.87	185.56
<b>НИЙТ ХХЯ (Хамрах хүрээ1,2,3(бусад))</b>	<b>237,988.32</b>	<b>103,522.55</b>	<b>235,460.77</b>

# ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРЛЫН ТООЦООЛОЛ

## ХАМРАХ ХҮРЭЭ 1

- 2025 онд банкны өөрийн эзэмшлийн машины тоо өмнөх оноос 9% нэмэгдсэн ба дизель түлшний хэрэглээ өссөн нь түлшний хэрэглээнээс үүдэн ялгарч буй ХХЯ-ын өсөлтөд голлон нөлөөлсөн байна.
- Хамрах хүрээ 1-ээс ялгарч буй хүлэмжийн хий нь банкны өөрийн үйл ажиллагаанаас үүсэж буй нийт ХХЯ-ын дийлэнх буюу 99%-ийг эзэлж байгаа тул банк уур амьсгалын нөлөөллийг бууруулах зорилгоор цаашид дизель түлшний хэрэглээг үе шаттайгаар бууруулах, цахилгаан автомашины тоог нэмэгдүүлэх чиглэлд анхааран ажиллах болно.

## ХАМРАХ ХҮРЭЭ 2


- Оффисуудын эрчим хүчний хэрэглээ 2025 онд суурь онтой харьцуулахад 18.8%-иар буурсан үзүүлэлттэй байна.
- Ажилтнуудын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор эрчим хүч хэмнэлтийн талаарх мэдээллийг дотоод сувгаар тогтмол хүргүүлж байна.

## ХАМРАХ ХҮРЭЭ 3 (БУСАД)

- 2025 онд хог хаягдлаас ялгарч буй хүлэмжийн хийн ялгарал суурь онтой харьцуулахад 21%-иар буурсан үзүүлэлттэй байна.
- Ажилтнуудын ажил-гэр хоорондын зорчилтын хэлбэрийг тодорхойлох зорилгоор судалгаа авч, нийт ажилтнуудын 86%-ийн бодит мэдээлэлд үндэслэн тээврийн хэрэгслийн төрөл, зорчих зай (км), долоо хоногт ажилласан өдрийн тоо зэрэг үзүүлэлтүүдийг тооцоонд ашиглав.
- Судалгааны үр дүнд ажилтнуудын бензин, дизель хөдөлгүүртэй автомашин болон нийтийн тээврийн (автобус) хэрэглээ буурч, харин ажил-гэрийн маршрутын хүрээнд алхалт, дугуй болон цахилгаан хөдөлгүүртэй дугуйн хэрэглээ нэмэгдсэн нь байгальд ээлтэй амьдралын хэв маягт шилжиж эхэлснийг харуулж, үүнтэй холбоотойгоор суурь онтой харьцуулахад ажилтны маршрутаас ялгарч буй хүлэмжийн хийн ялгарал 20%-иар буурсан байна.

Нийт хүлэмжийн хийн ялгарал суурь онтой харьцуулахад 1%-иар өссөн хэдий ч хамрах хүрээ 2 болон 3-ыг суурь онтой харьцуулахад 17%-иар буурсан байна. Банк жил бүр өгөгдлийн чанар, бүртгэлийг сайжруулж, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах арга хэмжээг авч ажиллахаар зорьж байна.

## ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРЛЫГ БУУРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ



**ӨӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС ҮҮДЭЛТЭЙ ЯЛГАРУУЛЖ БҮЙ ХҮЛЭМЖИЙН ХИЙН ХЭМЖЭЭГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР 2025 ОНД ДАРААХ АЖЛУУДЫГ ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙНА.**

## НОГООН БАРИЛГЫН LEED ГЭРЧИЛГЭЭ

2024 онд АНУ-ын Ногоон Барилгын Зөвлөл (USGBC)-өөс олгодог LEED O+M (Leadership in Energy and Environmental Design – Operations and Maintenance) стандартын “GOLD” түвшний гэрчилгээг Төв оффисын барилга дээр амжилттай авч хог хаягдлын менежментийг хангах болон эрчим хүч, усны хэрэглээг жил бүр бууруулж байна



Банкны шинэ баригдаж буй оффис (36,618м<sup>2</sup>) дээр АНУ-ын ногоон барилгын LEED гэрчилгээ авахаар ажиллаж байна. Ингэснээр Голomt банкны нийт өөрийн эзэмшлийн оффисын талбайн 90% нь 2027 оноос эхлэн ногоон болох боломж бүрдэж байна.

## СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭРЭГЛЭЭГ НЭМЭГДҮҮЛЭВ.



2025 онд шинээр Амгалан агуулах болон архив байрладаг нийт 2,756м<sup>2</sup> ашигтай талбайтай барилгад 30кВт.ц хүчин чадал бүхий 45 ширхэг нарны панел суурилуулан сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүллээ. Монгол улсын цаг уурын нөхцөл байдалд үндэслэн тооцоолсноор тус нарны панел нь жилд 49,908кВт.ц үйлдвэрлэх боломжтой байна.

Мөн 2022 онд оффисын барилгад суурилуулсан 1080кВт.ц-ын хүчин чадалтай нарны панелаас эрчим хүчний тодорхой хувийг хангаж байна. Цаашид жил бүр өөрийн эзэмшлийн барилгад үе шаттайгаар сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг нэвтрүүлэхээр ажиллаж байна.

## ТОГТВОРТОЙ, НОГООН ХУДАЛДАН АВАЛТЫН СТАНДАРТЫГ ХАНГАН АЖИЛЛАЖ БАЙНА.

2025 онд нийт худалдан авсан компьютер, тоног төхөөрөмжүүд олон улсын эрчим хүчний хэмнэлтийн гэрчилгээтэй, байгаль орчинд сөрөг нөлөөлөл бага гэсэн шаардлагыг хангаж тогтвортой, ногоон худалдан авалтын стандартыг ханган ажиллалаа.



**160Ш**

Зөөврийн компьютер



**377Ш**

Процессор



**425Ш**

Дэлгэц

## БОНЗ ӨГӨГДӨЛ ЦУГЛУУЛАХ ТАЙЛАГНАХ ЗААВАР БОЛОВСРУУЛАВ

Хүлэмжийн хийн тооцоолол хийхэд шаардлагатай өгөгдлүүд болон БОНЗ, тогтвортой байдлын хэрэгжилт, тоон мэдээллийг хамаарал бүхий нийт 11 нэгжээс хэрхэн цуглуулах, тайлагнах тухай зааврыг 2025 онд шинээр батлуулж, өгөгдлийн чанарыг сайжруулж байхад нэгж тус бүр анхааран ажиллаж байна. Мөн эдгээр өгөгдлийн мэдээллийг гар аргаар бүртгэх ажиллагааг багасгаж системээр бүртгэх боломжийг бүрдүүлэн автоматжуулалтын ажил хийгдэж байна.

## ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРАЛ ТООЦОХ ЗААВАР БОЛОВСРУУЛАВ

Дотоодод ашиглах хүлэмжийн хийн ялгарал тооцох заавар батлагдсанаар банкны өөрийн болон санхүүжүүлсэн хүлэмжийн хийн ялгарлын тооцооллыг үнэн зөв, нэг аргачлалаар тасралтгүй тооцоолох боломж бүрдэж байна.

# ТОГТВОРТОЙ, НОГООН ҮЙЛ АЖИЛЛАГАА

## ЭРЧИМ ХҮЧ

### Зорилт

2030 болон 2050 оны банкны хэмжээний зорилтууд (2030:30%, 2050: 50%)

### Тогтвортой хөгжлийн бодлого

Банкны дотоод үйл ажиллагаанд баримтлах бодлого бүлэгтээ “Эрчим хүч болон хүлэмжийн хийн ялгаралт: Дотоод үйл ажиллагаандаа эрчим хүчийг үр ашигтай, ариг гамтай хэрэглэхийг зорих” (заалт 3.6)

### Тогтвортой, ногоон үйл ажиллагааны стандарт

Эрчим хүчний хэмнэлттэй гэрэл, чийдэн, цахилгаан хэрэгсэл (заалт 2.4)

### LEED Gold Standard

Гэрлийн бохирдол бууруулалт;

Эрчим хүчний хэмнэлтийн менежмент зэрэг үзүүлэлтүүдийг хангаж чадсан ба эрчим хүчний хөндлөнгийн аудит хийгдсэн.

## УС

### Зорилт

2030 болон 2050 оны банкны хэмжээний зорилтууд (2030:5%, 2050: 10%)

### LEED Gold Standard

Борооны усны менежмент;

Усны хэрэглээ зэрэг үзүүлэлтүүдийг хангаж чадсан.

### Худалдан авалтын үйл ажиллагааны журам (2023)

2.3.7.1 Хивс угаах процессыг агааржуулалт сайн, ажилтнуудгүй орчинд, хоруу чанар багатай цэвэрлэгээний бодисоор, бага ус ашиглан хийж гүйцэтгэнэ.

## ХОГ ХАЯГДАЛ

### Тогтвортой хөгжлийн бодлого

Банкны дотоод үйл ажиллагаанд баримтлах бодлого бүлэгтээ “Хог хаягдлын менежмент: Агаар, ус, газар зэрэгт үзүүлж буй байгууллагын нөлөөллийг багасгахыг зорих;” (заалт 3.6.2.3)

### Дахивар хог хаягдал

Голомт банк бүх оффис, салбартаа хог хаягдлыг ангилдаг бөгөөд дахивар хаягдлыг ачуулдаг. /шил, лааз, цаас/аюултай хог хаягдал ачих/аюултай хог хаягдлыг хадгалах, дахин боловсруулах, устгалд оруулах/\*\*\*процессор, РС, монитор, батарей, гэр ахуйн цахилгаан тоног төхөөрөмж, утас, принтер, цэнэг хуримтлуур, тог баригч г.м. 2030 онд гэхэд дахивар хог хаягдлын хэмжээг 30% нэмэгдүүлэх зорилт тавьсан байна.

### LEED Gold Standard

Хог хаягдлын менежмент үзүүлэлтийг хангаж чадсан ба хог хаягдлын хөндлөнгийн аудит хийгдсэн.

## ХУДАЛДАН АВАЛТ

### Худалдан авалтын үйл ажиллагааны журам (2023)

Үндэсний үйлдвэрлэл  
Байгаль орчин

### Тогтвортой, ногоон үйл ажиллагааны стандарт (2024)

Тогтвортой, ногоон худалдан авалтын стандарт  
Автомашин, тавилга, тоног төхөөрөмж, принтер, мөнгө тоологч, бичиг хэрэг, хэвлэмэл материал, ариун цэврийн зүйлс (заалт 1.2.1)

Үл хөдлөх, их засвар, урсгал засвар, интерьер дизайн гэх мэт шинэ нэгж байгуулахтай холбоотой (заалт 1.2.2)

Мэдээллийн технологийн газартай холбоотой сүлжээ, дэд бүтэц (заалт 1.2.3)

# АЖИЛТНУУДЫН ОРОЛЦОО

## АЖИЛТНУУДЫН ОРОЛЦОО


Ногоон элч хөтөлбөр

**99** НОГООН  
ЭЛЧ



Ногоон элч хөтөлбөр нь 2024 оноос эхлэн Голомт банкны ажилтнуудын дунд хэрэгжиж эхэлсэн. Голомт банкны тогтвортой хөгжлийн зорилтууддаа хүрэхэд түлхэц үзүүлэх, ажилтнуудын дунд ногоон дадлыг суулгах, тогтвортой санхүүжилт болон тогтвортой хөгжилтэй холбоотой ойлголт, мэдээллийг түгээх, шинэ санал санаачилгыг дэмжих зорилготой хөтөлбөр юм. 2025 онд нийт салбар, төвийн нэгжийн төлөөлөл бүхий 99 ногоон элчтэй үйл ажиллагаа явуулав.

### 1-Р ХАГАСТ:



“Ногоон оффис” сэдвийн хүрээнд:

- Хог хаягдлаа ангилан ялгах сургалтыг “Өнгө нэмье” ТББ-аас,
- Тасалгааны ургамал арчилгааны талаар сургалт, воркшопыг “Ойм” ногоон урлангийн хамт олноос авч, ажлын байран дээрх ногоон дадал, туршлагуудыг түгээв.

### 2-Р ХАГАСТ:

Ногоон элчнүүдийн дунд эрүүл амьдралын хэв маягийг хэвшүүлэх тээврийн хэрэгслийн хэрэглээг бууруулж, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилготойгоор “Эко километр” уралдааныг 30 хоногийн хугацаатай зохион байгуулав. Үүний хүрээнд:

Нийт 146 ажилтан идэвхтэй хамрагдаж,



Давхардсан тоогоор 1.3 сая алхам буюу 1,012 км замыг явган туулж



202кг CO<sub>2</sub>e хүлэмжийн хий ялгаруулахаас сэргийлсэн байна.

Ногоон элчнүүд өөрсдийн салбар, нэгж дотроо хог хаягдлаа зөв ангилах, багасгах, эрчим хүч, усаа хэмнэх зэргийг уриалан манлайлж банкны үйл ажиллагаанаас үүдэх ус, хог хаягдал, эрчим хүчний хэрэглээг бууруулахад хувь нэмрээ оруулсаар байна.



## ТОС ХЭРЭГЖИЛТИЙН САЙН ЖИШГҮҮД:

### Сайн жишиг 1:

Дижитал шилжилтийн газар нь тогтвортой хөгжил, ногоон дадал төлөвшүүлэх зорилгоор 2025 оны турш сар бүр өөрсдийн санаачилгаар уриалга гарган, хамт олноороо ногоон дадлыг идэвхитэй хэрэгжүүлж “Шилдэг ToC хэрэгжүүлэгч нэгж”-ээр тодорлоо. Дараах санаачилгуудыг хэрэгжүүлэн тогтвортой хөгжилд бусдыгаа уриалав. Үүнд:

- Газрын хэмжээнд ToC санаачилгын уралдааныг зохион байгуулж, 15 санаанаас сонгон авч амжилттай хэрэгжүүлсэн.
- “Ногоон тээвэр” аяны хүрээнд хамт олноороо нийт 403км алхалт хийн, 81 кг CO2 ялгаруулалт үүсэхээс урьдчилсэн сэргийлсэн.
- Хог хаягдлыг ангилан ялгах, дахин ашиглах дадлыг хэвшүүлж хуванцар сав, лааз, шил зэрэг дахивар хог хаягдлыг зориулалтын дагуу ялган хаях дадлыг нутагшуулсан.
- Солилцооны сав нэвтрүүлж, “хэрэглэхгүй зүйлсээ хэрэгтэй нэгэндээ” аян зохион байгуулсан.

### Сайн жишиг 2:

Банкнаас зохион байгуулж буй танхимын сургалтуудад нэг удаагийн хэрэглээг бүрэн халж, ажилтнууд сургалтад хамрагдахдаа өөрсдийн аягатай ирэх аль эсвэл дахин ашиглах боломжтой ариутгасан аяганаас сонгон хэрэглэх боломжтой боллоо. Ингэснээр хуванцар хог хаягдлыг бууруулж, ажилтнууд дунд ногоон дадлыг төлөвшүүлж байна.



**ГОЛОМТ БАНК**  
*Сайн сайхныг санхүүжүүлнэ*

**УСНЫ ЭЛЧ  
БАНК**

**НИЙГЭМ**

*Bayn Max*

# ХҮНИЙ НӨӨЦ-ҮЛ ЯЛГАВАРЛАХ, ТЭГШ ЭРХ, ОРОЛЦОО



БОНЗ нь хөрөнгө оруулагчид, харилцагчид, ажилтнууд, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн анхаарлыг ихээр татаж, харгалзан үзэх чухал сэдэв болсон ба банк ч мөн адил тогтвортой хөгжил болон тогтвортой санхүүжилтийг үндсэн стратегийн нэгээр тунхагласан билээ. Үндэсний зорилтот хувь нэмэр, уур амьсгалын өөрчлөлт гэх мэт байгаль орчинтой шууд холбоотой асуудлууд байгаа хэдий ч нийгэм – тэр дундаа ажлын байртай холбоотой олон асуудлуудыг харгалзан авч үздэг. Олон талт, тэгш, хүртээмжтэй, үл ялгаварласан, хүний эрхийг дээдэлсэн үйл ажиллагаа эрхлэх нь банкны хүний нөөцийг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой гэдэгт итгэдэг. Голомт банк жендэрийн тэгш байдал, санхүүгийн хүртээмж, БОНЗ, ТХЗ, хүний эрхийн асуудлуудыг холбогдох бодлого, журам, бусад бичиг баримтуудад тусган, сайжруулалтыг хийн ажиллаж байна.

## ХҮНИЙ НӨӨЦ - ҮЛ ЯЛГАВАРЛАХ, ТЭГШ ЭРХ, ОРОЛЦОО

Голомт банк ажилтны замналыг тасралтгүй сайжруулах, ажилтан бүрд ээлтэй, сурч хөгжих, өөрийгөө сорих боломжоор дүүрэн тогтолцоог бий болгох замаар банкны урт хугацааны, тогтвортой өсөлт хөгжилд хувь нэмрээ оруулан ажиллаж байна.

НИЙТ АЖИЛТНЫ ТОО 2,800	ШИНЭ АЖИЛТАН 440 гаруй 46% шинэ төгсөгч	НИЙТ АЖИЛТНЫ 71% 35-с доош насныхан	АЖИЛТНУУДЫН 28% Career path index
АЖИЛТНУУДЫН ХҮЙСИЙН ХАРЬЦАА Эр: 30% Эм: 70%	УДИРДЛАГЫН БАГ Эр: 58% Эм: 42%	GPTW 91%	АЖИЛТНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ИНДЕКС 91%
АЖИЛТНЫ УР ЧАДВАРЫН ИНДЕКС 92%	АЖИЛТНЫ СЭТГЭЛ ХАНАМЖ 92%	ТОГТВОРТОЙ АЖИЛЛАСАН ЖИЛ 5.7 жил	НЭГ АЖИЛТАНД НОГДОХ СУРГАЛТ 9 өдөр

“Итгэлцэл дээр суурилсан, өндөр гүйцэтгэлтэй байгууллагын соёл”-ыг бий болгох зорилгоор судалгаа хийж, зөвлөх үйлчилгээ үзүүлдэг тусгай эрх бүхий олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн байгууллага болох “Great Place To Work Institute”-ээс “Ажиллахад хамгийн таатай газар” батламжийг Голомт банк байгууллагын дотоод соёлоороо тэргүүлэн дөрөв дэх жилдээ гардан авлаа.



## АЖИЛТНУУДЫН ХАНГАМЖ

### Сургалт хөгжил



Голомт академиар дамжуулан дотоодын сургагч багш нар 150 гаруй цахим сургалт, контентыг бэлтгэж, давхардсан тоогоор 82,000 удаагийн хандалтаар ажилтнууд сургалтад хамрагдаад байна.

### Цалинтай чөлөө



Ажилтны өөрийн болон хүүхдүүдийн төрсөн өдрийн цалинтай чөлөөг олгодог. 2025 онд нийт 61 ажилтан аавын 10 хоногийн цалинтай чөлөө авсан байна.

### Хөхүүл, жирэмсэн ажилтнууд



66 ажилтан жирэмсэн, хөхүүл эхчүүдийн богиносгосон цагаар ажиллаж байна.

### Тэтгэврийн ууган сан



Бид ажилтнууддаа "Тэтгэврийн ууган сан"-аар дамжуулан урт хугацааны хуримтлал үүсгэх боломжийг бүрдүүлэн ажилладаг.

### Сонирхлын клуб



Сонирхлын клубүүдэд нэгдэх, үүсгэн байгуулах, спорт соёлын арга хэмжээ, хичээлүүдэд хамрагдах боломжууд нээлттэй.

### Спорт арга хэмжээ



Голомт банкны адал явдалт спорт, явган аялалд нийт 132 ажилтан 85км зам туулж "Асралт хайрхан"д авиралт хийв. "Голомт банкны спорт наадам"-ыг хавар, намар зохион байгуулдаг ба 1,230 ажилтан хамрагдав.

### Ойн булаг зуслан



Зуны улиралд ажилтнууддаа цэвэр агаарт гэр бүлээрээ гарч, амрах "Ойн булаг зуслан" хөтөлбөрийг хэрэгжүүлдэг. 2025 онд 82 байшинд, 172 ажилтан гэр бүлийн хамт амрав.

### Банкны эмч



Банкны эмчид хандаж нийт 1,282 ажилтан урьдчилан сэргийлэх болон эмчийн анхан шатны үзлэгт хамрагдав. Хавар, намрын эрүүл мэндийн аянд нийт 480 ажилтан хамрагдлаа.


## ONE BIG FAMILY

Монгол Улсын банкны салбарт түүхэн мөр, тод амжилтаа бататгасан Голомт банкны 30 жилийн ойн хүрээнд зохион байгуулсан баярын хурлын үеэр хөдөлмөр, зүтгэлээрээ манлайлан ажиллаж буй ажилтнууддаа хүндэтгэл үзүүлэн төрийн дээд одон, медаль, банк, санхүүгийн салбарын шагналаар шагнаж, урамшуулав. Мөн SocialPay Park-д “One big family” нийт ажилтны арга хэмжээг зохион байгуулж, эх орныхоо хөгжлийн голомт байх эрхэм зорилго дор нэгдсэн хамт олонтойгоо дурсамжит өдрийг бүтээв.



## ГОЛОМТ БАНК БОНЗ-ЫН ХҮРЭЭГЭЭ ӨРГӨЖҮҮЛЭХ НЬ

Голомт банк НҮББОХ-ын Хариуцлагатай банкны зарчмуудын хүрээнд 2030 он хүртэлх шинэчилсэн хамрах хүрээг хэрэгжүүлэх үүргийг 2024 оны 10-р сард албан ёсоор хүлээсэн болно<sup>1</sup>. Үүнд:



Парисын хэлэлцээр болон ТХЗ 13-ын хүрээнд net zero буюу уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй эдийн засгийн хөгжлийг цогцлоох



НҮБ-ын "Хэнийг ч орхигдуулахгүй байх" зарчмын хүрээнд ТХЗ 1,5,8,10-ын хүрээнд санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх



Kunming-Montreal Global Biodiversity Framework болон ТХЗ 14, 15-ын хүрээнд биологийн олон янз байдлыг хамгаалах



НҮБ-ын Бизнес ба хүний эрхийн удирдах зарчмуудын хүрээнд хүний эрхийг хамгаалах

<sup>1</sup>Эх сурвалж: [https://www.unepfi.org/wordpress/wp-content/uploads/2024/10/PRB\\_Leading-the-Way-to-a-Sustainable-Future.pdf](https://www.unepfi.org/wordpress/wp-content/uploads/2024/10/PRB_Leading-the-Way-to-a-Sustainable-Future.pdf)

## ХҮНИЙ ЭРХИЙГ ХҮНДЭТГЭН ДЭЭДЛЭХ



Харилцагчид, Засгийн газар, иргэний нийгмийн байгууллагууд аливаа бизнесийн үйл ажиллагааг байгаль орчин болон нийгэмд сөрөг нөлөөгүй, тогтвортой, ёс зүйтэй байх шаардлагыг тавьсаар байна. Голомт банкны хувьд бизнесийн шударга ёс, хүний эрх, ёс зүй, байгаль орчин, хөдөлмөрлөх эрхийн хүрээнд хүний эрхийг хамгаалж, хүндэтгэхийг нийт ажилтнуудад уриалан, хандлагыг өөрчлөх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлсээр ирсэн. Иймээс НҮББОХ-ын Хариуцлагатай банкны зарчмуудыг хэрэгжүүлдгийн хүрээнд Хүний эрхийн тухай заалтыг илүү нарийвчлан шинэчилж, Тогтвортой хөгжлийн бодлогодоо тусгалаа.

ХҮНИЙ ЭРХИЙН БОДЛОГО  
БОЛОВСРУУЛАХ

ХҮНИЙ ЭРХИЙН МАГАДЛАН  
ШИНЖИЛГЭЭ ХИЙХ

ЗӨРЧИГДСӨН ЭРХИЙГ  
СЭРГЭЭН ЭДЛҮҮЛЭХ

### ХҮНИЙ ЭРХИЙН БОДЛОГО

Банк нь дотоод болон бизнесийн бүхий л үйл ажиллагаандаа хүний эрхийг хүндэтгэн НҮБ-ын Бизнес ба хүний эрхийн удирдах зарчмууд, Олон улсын хөдөлмөрийн байгууллагын суурь 8 конвенц, бусад олон улсын болон үндэсний хүний эрх, хөдөлмөр эрхлэхтэй холбоотой стандарт, зарчмуудыг мөрдөн ажиллахаа Тогтвортой хөгжлийн бодлогодоо тусган амлалт өгөөд байна. Тогтвортой хөгжлийн бодлогыг 2024 оны сүүлийн хагаст шинэчлэн сайжруулахдаа хүний эрхтэй холбоотой заалтуудыг тусган баяжуулав.

### ХҮНИЙ ЭРХИЙН МАГАДЛАН ШИНЖИЛГЭЭ

2025 оны 2-р хагаст банк ажил олгогчийн хувьд нийт ажилтнуудад учирч болзошгүй хүний эрхтэй холбоотой эрсдэлийг илрүүлэх "Хүний эрхийн магадлан шинжилгээ"-г анх удаа хийж гүйцэтгэлээ. Ингэхдээ НҮБ-ын Бизнес ба хүний эрхийн удирдах зарчмууд болон НҮББОХ-Санхүүгийн санаачилгын санхүүгийн байгууллагуудад зориулсан хүний эрхийн хэрэгсэл, зөвлөмжийг ашиглав.

- Хүний эрхийн эрсдэлийн үнэлгээ хийх нөлөөлөл, магадлалыг тодорхойлох хүний эрхийн эрсдэлийн матрицыг шинээр боловсруулав.
- Ажилтнуудын оролцоог хангах үүднээс нийт ажилтнууд хамрагдсан Great Place to Work судалгааны 2022-2025 онуудын үр дүнг ашиглав. Ажиллахад таатай газрын Итгэлцлийн индекс нь Итгэлцэл, Хүндлэл, Бахархал, Нөхөрлөл, Шударга байдал гэсэн суурь 5 үзүүлэлтээс бүрддэг ба судалгаа нь эдгээр үзүүлэлтийг тодорхойлох олон улсын жишиг бүхий 60 асуумжаас бүрддэг.
- Магадлан шинжилгээний үр дүнд гарсан өндөр, маш өндөр эрсдэлүүд дээр авах хариу арга хэмжээг тодорхойлов.
- Цаашид аргачлал, хариу арга хэмжээний механизмыг улам боловсронгуй болгон ажиллахаар байна. Ирэх жилүүдэд банк санхүүжүүлэгчийн хувьд харилцагчдад үүсэх боломжтой хүний эрхийн эрсдэлийг тодорхойлох ажлыг эхлүүлэх юм.

# ХҮНИЙ ЭРХИЙГ ХҮНДЭТГЭН ДЭЭДЛЭХ

## ЗӨРЧИГДСӨН ЭРХИЙГ СЭРГЭЭН ЭДЛҮҮЛЭХ

- Банк нь дотооддоо хүний эрхтэй холбоотой зөрчил мэдүүлэх, зүй бус үйл явдлыг мэдээлэх хэд хэдэн сувгуудыг хэрэгжүүлдэг ба мэдээлэл, мэдээлэгчийн нууцлал бүрэн хамгаалагдсан байдаг. Үүний хүрээнд шүгэл үлээх зааврыг дижитал хэлбэрт шилжүүлэн, ажилтнуудад нээлттэй байршуулав.
- Хүний эрхийг хангахтай холбоотой Шүгэл үлээх заавар, Ажилтны хүсэлт, гомдол шийдвэрлэх заавар, Хүний хувийн мэдээлэл хамгаалах стандарт зэрэг банкны дотоод бодлого, заавар, журмуудаар санал, гомдлыг шийдвэрлэх механизм ажиллаж байна.
- Нийт ажилтнууд Голомт академиар дамжуулан “Хүний эрх”, “Жендэрийн сургалт”-д жил бүр хамрагдаж байна.



2025 онд Глобал Жендэр-Смарт Сан (GGSF)-ийн олон улсын зөвлөх багтай хамтран “Жендэрийн хүртээмжтэй манлайлал” удирдлагын түвшний сургалтыг зохион байгуулав. Сургалтад Голомт банкны 34 удирдах түвшний ажилтан хамрагдаж, байгууллагын түвшинд жендэрийн тэгш, олон талт байдал, шударга ёс, хүртээмжийг (DEI) төлөвшүүлэх чадавхаа сайжруулж, байгууллагын хэмжээнд тэгш байдлыг дэмжих манлайллын жишгийг бий болгох хамтын ойлголт, хандлагыг төлөвшүүлсэн юм.



## БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭГЭЭР ДАМЖУУЛАН НИЙГЭМД ҮЗҮҮЛЖ БУЙ ЗЕРЭГ НӨЛӨӨЛӨЛ

### САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖ

Голомт банкны бүтээгдэхүүн, үйлчилгээг нийгмийн бүх бүлэгт цаг алдалгүй, хүртээмжтэй авах боломжийг олгох нь Тогтвортой Хөгжлийн Зорилгуудыг хэрэгжүүлэх гол хөшүүрэг гэж үздэг. Бид нийгмийн илүү олон бүлэгт хэрэгцээ шаардлагад нь нийцсэн, хариуцлагатай, тогтвортой байдлаар ашиг тустай, хүртээмжтэй санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг авах боломжоор хангахыг зорин ажиллаж байна. 2025 онд бид дотоодод ашиглах “Санхүүгийн хүртээмжийн мэдээлэл цуглуулах, мэдээлэх заавар”-ыг шинээр боловсруулж батлуулав.

### ХҮҮХЭД, ЗАЛУУСТ ЗОРИУЛСАН ХӨТӨЛБӨР

- Санхүүгийн хүртээмжийг оюутан, сурагч залууст хүргэх чиглэлээр нийт 119 ЕБС болон их, дээд сургуулиудад “Санхүүгийн мэдлэг олгох” сургалт, оюутан залууст зориулсан “The Color Card”, “Social-Pay Junior” аппликэйшныг танилцуулах өдөрлөгийг зохион байгуулав.



- Хүүхдүүдийг бага наснаас нь хуримтлуулах зөв дадалд сургах, хуримтлалын ач тусыг таниулах зорилгоор Голомт банк орон нутаг болон нийслэл хотын 1-р ангид элсэн орж буй нийт 22,000 хүүхдэд 100,000₮-ийн хуримтлалын эрхийн бичиг олгов. Аяны үр дүнд нийт 2,156 хүүхэд “Алтантүлхүүр” хүүхдийн хадгаламжийн данс шинээр нээлгэлээ.




- Шинэ үеийн хүүхэд, залуусыг Голомт банкны ирээдүйн харилцагч болгох, банкны үйлчилгээг шинэлэг байдлаар хүргэх GenZ Loyalty урамшуулалт хөтөлбөрийг хэрэгжүүллээ. Тайлант хугацаанд 0-22 насны 270,000 гаруй харилцагч хөтөлбөрт хамрагдаж, 110 харилцагч сугалааны азтан болсон бөгөөд 1 супер азтан Хонг Конг руу хосоороо аялж, “Мама Awards 2025” хөгжмийн наадмыг үзэх эрхийн бичиг хожив.


## ХҮҮХЭД, ЗАЛУУСТ ЗОРИУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮНҮҮД

### THE COLOR CARD

Хүүхэд, залууст багаас нь санхүүгийн боловсролыг олгоход чиглэсэн хэрэглэхэд хамгийн хялбар, өнгөлөг дизайн бүхий картыг 7-22 насны хүүхэд, залууст санал болгож байна.




### SKATE KAPT



Монголын хамгийн анхны wearable карт буюу зайнаас унших технологи бүхий 7-22 насны хүүхэд, залуучуудад зориулсан "Skate" картыг хэрэглээнд нэвтрүүлэв. Skate карт нь банкны картын мэдээллийг суулгасан "skate-board" загвар гэдгээрээ энгийн төлбөрийн картаас онцлог бөгөөд NFC технологийг ашиглан бүх төрлийн ПОС төхөөрөмжид уншуулж, И-коммерс дээр онлайн худалдан авалт хийх боломжтой төлбөрийн хэрэгсэл юм.

### SOCIAL PAY APP

7-18 насныханд зориулсан SocialPay Junior аппликэйшн нь QR ашиглан төлбөр төлөх, шилжүүлэг хийх, мөнгө илгээх болон нэхэмжлэх, кино, үзвэрийн тасалбар захиалах, нэгж, дата авах зэрэг өдөр тутмын амьдралыг хялбарчлах олон үйлчилгээг зөвхөн нэг апп-аас авах боломжийг олгож буй юм. SocialPay Junior аппликэйшн нь хүүхэд багачуудын санхүүгээ бие даан удирдах, орлого зарлагаа хянах цаашлаад санхүүгийн боловсролд суралцахад нь туслах юм.



## СОШИАЛПЭЙ АПП ХЭРЭГЛЭГЧ ХҮҮХЭД, ЗАЛУУСЫН НАСНЫ АНГИЛАЛ



## ДИЖИТАЛ ШИЛЖИЛТ

Дижитал шилжилт нь банкны хувьд үйл ажиллагааны болон гүйлгээний зардлыг бууруулах, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, санхүүгийн салбар болон хүртээмж багатай бүлгүүд болох эмэгтэйчүүд, хүүхдүүд, малчид, алслагдсан бүс нутагт оршин суугаа иргэд, бичил болон жижиг, дунд бизнес эрхлэгчдийн хэрэгцээг хангах, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх боломжийг олгож байдаг. Ухаалаг утас ашиглан цахим үйлчилгээ авах боломжгүй иргэд салбар тооцооны төвүүд болон киоскуудаар дамжуулан бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэсээр байна.

Дижитал шилжилт	2025 /өөрчлөлт %/	2024 /өөрчлөлт %/	2023 /өөрчлөлт %/
Дижитал сувгууд хэрэглэгчдийн тоо	+11.3%	+12.6%	+16.4%
Дижитал сувгууд идэвхтэй хэрэглэгчдийн тоо	+17.3%	+11.3%	+17.1%
Дижитал сувгуудаар хийсэн гүйлгээний тоо	+9.4%	+21.7%	+38.6%
SocialPay хэрэглэгчдийн тоо	+29.9%	+35.1%	+37.2%
SocialPay-ээр хийсэн гүйлгээний тоо	+49.1%	+65.5%	+121.4%

# ЖИЖИГ, ДУНД БИЗНЕС

## ЖИЖИГ, ДУНД БИЗНЕС ЭРХЛЭГЧИЙН ӨРСӨЛДӨХ ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ

Голомт банк Монгол Улсын эдийн засгийн гол тулгуур болсон жижиг, дунд бизнесүүдээ дэмжин ажилласаар ирсэн. Тэр дундаа бизнес эрхлэгчдийн 37 хувийг, жижиг, дунд бизнес эрхлэгчдийн 73 хувийг эзэлдэг бизнес эрхлэгч эмэгтэйчүүдээ санхүүгийн хувьд дэмжин тэдэнд тохирсон бизнесийн орчин, бодит дэмжлэгийг нэмэгдүүлэх бүтээгдэхүүн, үйлчилгээг тасралтгүй хүргэж байна.

ЖДБ ЭРХЛЭГЧДЭД ОЛГОСОН  
ЗЭЭЛ  
27% өсөв

БИЗНЕС ЭРХЛЭГЧ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙГ  
ДЭМЖИХ ЗЭЭЛ  
28% өсөв

МЕНТОРШИП ХӨТӨЛБӨРТ ХАМРАГДСАН  
ААН-ИЙН ТОО  
100

### WOMEN OWNED ТОХИРЛЫН ТЭМДЭГ

100 байгууллагад  
олгов

24 байгууллага шошгодоо  
байршуулав

Албан ёсны цахим хуудас  
[www.womenowned.mn](http://www.womenowned.mn) нээгдэв

2025 онд сургалт, хөгжлийн хөтөлбөрүүдээр дамжуулан 1,000 эмэгтэй бизнес эрхлэгчдэд хүрч ажилласан байна.



Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банктай хамтран эмэгтэй бизнес эрхлэгчид болон залуу бизнес эрхлэгчдийн санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 20 сая ам.долларын урт хугацаат санхүүжилтийн гэрээг үзэглэсэн билээ.

Бизнес эрхлэгчдийн санхүүгийн хэрэгцээг нь хангах зорилготой эх үүсвэрийг татах, зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг сайжруулж, шаардлагатай санхүүжилтүүдийг олгож байна.


Голомт банк хөгжлийн бэрхшээлтэй бизнес эрхлэгчдийг чадавхжуулах, санхүүгийн боловсрол олгох зорилгоор “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэгш хүртээмж итгэл” ТББ-тай хамтран ажиллах санамж бичиг байгуулав. Хамтын ажиллагааны хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжиж, банкны арга хэмжээ, төсөл хөтөлбөрүүдээ хамруулахаас гадна хөнгөлөлттэй санхүүгийн бүтээгдэхүүн санал болгоно.

Euromoney сэтгүүлээс 2025 оны Монгол Улсын “Жижиг, дунд бизнесийг дэмжигч шилдэг банк”-аар өргөмжлөв.



**НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ХҮРЭЭНД НИЙГЭМД ҮЗҮҮЛЖ БУЙ ЭЭРЭГ НӨЛӨӨЛӨЛ**  
2025 оны байдлаар дараах төсөл, хөтөлбөрүүдийг дэмжин ажилласан байна. Үүнд:

## НИЙСЛЭЛИЙН АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ТӨСӨЛ



Голомт банк Тогтвортой хөгжлийн бодлогынхоо хүрээнд нийслэл хотын томоохон асуудал болох агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр Чингэлтэй дүүргийн Засаг даргын тамгын газартай хамтран ажиллалаа. Төслийн хүрээнд тус дүүргийн агаарын бохирдлын түвшин өндөртэй бүсийн 300 өрхөд Эко Сквер Энержи ХХК-ийн “Air to air heat pump” буюу “Агаараас агаарт дулааны насос” төхөөрөмжийг суурилуулав. Төсөлд шаардлагатай хөрөнгө оруулалтыг Голомт банкнаас шийдвэрлэж, агаарын бохирдлыг бууруулахад бодит хувь нэмэр оруулав. Уг төхөөрөмж нь цахилгаан халаалтаас гурав дахин бага эрчим хүч зарцуулахаас гадна 30-40 мкв сууцыг өвлийн улиралд гадна агаараас дулаан нэвтрүүлэх, зуны улиралд хөргөх хүчин чадал бүхий технологийн шийдэлтэй. Төхөөрөмжийг суурилуулснаар айл өрхүүдэд сайжруулсан түлш, нүүрс, мод гэх мэт түлшний хэрэглээг бүрэн халж, утаа үүсгэгч буюу нүүрстөрөгчийн давхар ислийн ялгаруулалтыг бууруулах зэрэг ач холбогдолтой.



### 300 айл өрх

“Агаараас агаарт дулааны насос”

## “ЗҮРХ МАРТАХГҮЙ” ТӨСӨЛ

Голомт банкны зүгээс хүүхэд багачуудын эрүүл мэндийг хамгаалах үйлст хувь нэмрээ оруулж буй томоохон төсөл нь “Бундан” ТББ-тай хамтран хэрэгжүүлдэг “Зүрх мартахгүй” төсөл юм. 2020 оноос хойш энэхүү төслийн албан ёсны түншээр хамтран ажиллаж байгаа бөгөөд Голомт банкны “Алтантүлхүүр” хүүхдийн сангаар дамжуулан санхүүгийн болон бусад дэмжлэгийг тууштай үзүүлж, өнгөрсөн хугацаанд нийт 540 сая төгрөгийн дэмжлэг олгоод байна. Үр дүнд нь өнөөдрийн байдлаар 35 хүүхдэд амьдрал бэлэглэжээ.

# 35

Хүүхдэд амьдрал

# ₮540 САЯ


Санхүүгийн дэмжлэг олгоод байна.



## “ӨВ СОЁЛЫН ГОЛОМТ” ТӨСӨЛ


Голомт банк Монголын түүх соёлын үл хөдлөх дурсгал, биет өвийн хадгалалт хамгаалалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажлуудыг гүнзгийрүүлэн хөгжүүлэх, соёлын өвийг дэлхийд таниулах археологийн олон төслийг хэрэгжүүлэх, урт хугацаанд дэмжихээр “Өв соёлын голомт” төслийг санаачлан 2022 оноос ШУА-ийн Археологийн хүрээлэнтэй 4 дэх жилдээ хамтран ажиллаж байна.

Одоогоор төслийн дэд төсөл болох “Ингэт толгой”-н дурсгалт газрын археологийн судалгааны ажлыг гүнзгийрүүлэн үргэлжлүүлж байгаа бөгөөд энэ нь Монголд төдийгүй олон улсад анхаарал татаж буй түүх, археологийн олдвор болоод байна. Археологийн олдворууд нь Монгол Улсын түүх, өв соёл, зан заншил, шашин шүтлэгтэй салшгүй холбоотой бөгөөд “Өв соёлын голомт” төслийг хэрэгжүүлснээр хойч үедээ үнэн зөв, бодитой мэдээллийг бататган үлдээх, цаашлаад дэлхийд таниулах ач холбогдолтой.



## “AI FOR WOMEN 100X100” ХӨТӨЛБӨР


Мэдээллийн технологийн салбар дахь эмэгтэйчүүдийн манлайллыг нэмэгдүүлэн боловсролын салбарт технологийн дэвшлийг нэвтрүүлэхээр AI Academy Asia-тай 2025 онд хамтран ажиллалаа. Алслагдсан аймаг, дүүргийн сурагчдыг тэгш хамруулахыг зорьсон уг хөтөлбөрт Монгол Улсын 21 аймаг, нийслэлийн 9 дүүргийн ерөнхий боловсролын сургуулиудын 100 багш, 13-18 насны 100 сурагч хамрагдан, хоёр сар гаруйн хугацаанд эрчимжүүлсэн сургалтаар дамжуулан хиймэл оюуны үндэс, Python программчлал, өгөгдөл боловсруулах аргачлал, хэлний загварчлал, машин сургалт, Vibe coding, AI ethics зэрэг сэдвүүдийг судалсан. Хөтөлбөрийн төгсгөлд оролцогчид “Capstone” буюу хиймэл оюунд суурилсан төслөө танилцуулж, шилдэг төслийн багуудыг шалгаруулсан юм.



## ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР

### “ТЭРБУМ МОД” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН

Монгол Улсын хэмжээнд 2030 он гэхэд тэрбумаар тоологдох мод тарьж, арчлан хамгаалж, ойн санг 9%-д хүргэх, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах зорилготой “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд ногоон хөгжлийн сэргэлтийг эрчимжүүлэхээр Голомт банк хамтран ажилладаг. 2025 онд “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг дэмжих санг банк хоорондын төлбөр тооцооны үйл ажиллагаагаар дэмжин **1.2 ТЭРБУМ ТӨГРӨГИЙГ САНД ТӨВЛӨРҮҮЛСЭН БАЙНА.**



### “АЛТАНТҮЛХҮҮР” ХҮҮХДИЙН ХАДГАЛАМЖ

Хүүхдүүдийг бага наснаас нь хуримтлуулах зөв дадалд сургах, хуримтлалын ач тусыг таниулах зорилгоор Голомт банк орон нутаг болон Улаанбаатар хотын 1-р ангид элсэн орж буй нийт **22,000 ХҮҮХДЭД 100,000₮-ИЙН ХУРИМТЛАЛЫН ЭРХИЙН БИЧИГ ОЛГОВ.** Аяны үр дүнд нийт 2,156 хүүхэд “Алтантүлхүүр” хүүхдийн хадгаламжийн данс шинээр нээлгэлээ.

### МИК ОРОН СУУЦ

Орон сууцны ипотекийн зээлийг нэн тэргүүнд зорилтот харилцагчид нь хүргэх, нээлттэй шударга тогтолцоог бүрдүүлэхийг зорилгоо болгож, зохицуулагч байгууллагуудтай хамтран удирдлагаар ханган **267 ТЭРБУМ** төгрөгийн эх үүсвэрээр **2,118 ИРГЭНД 6%-ИЙН ХҮҮТЭЙ ИПОТЕКИЙН ЗЭЭЛ** олгож, орон сууцжуулав.



## ГОЛОМТЫН ТӨГӨЛ

Голомтын төгөлд 6 дахь жилдээ шинээр 226 ширхэг гацуур мод тарьж нийтдээ 1,256 модтой боллоо.

6 дахь жилдээ 226 ширхэг гацуур мод тарьж  
**1,256 МОД**



## ЦУСАА ХАНДИВЛЯ

Голомт банкны ажилтнууд 2019 оноос жил бүр цусаа хандивладаг уламжлалтай ба 2025 оны хувьд 190 гаруй ажилтан цусаа хандивлаж 570 гаруй хүний амь аварлаа.

**190**  
гаруй ажилтан  
цусаа хандивлаж

**570**  
гаруй хүний амь  
аварлаа



### ХАЙРАА ХУВААЛЦЬЯ

Бид жил бүр “Хүүхдийн баяр”, “Шинэ жилийн баяр”-аар зорилтот бүлгийн хүүхдүүдэд зориулан “Хайраа хуваалцъя” аяныг зохион байгуулдаг билээ. 2025 онд нийт 56 салбар нэгж, 1,500 гаруй ажилтнаас цугларсан хувцас хэрэгсэл болон мөнгөн хандивыг Улаанбаатар хот болон хөдөө орон нутгийн зорилтот бүлгийн хүүхдүүдэд гардуулан өглөө.

**56** салбар нэгж **1,500** гаруй ажилтнаас цугларсан хувцас хэрэгсэл болон мөнгөн хандив



### GOOD VIBES

Ажилтнуудынхаа 2,500 гаруй хүүхдэд 3 удаагийн сургалтаар санхүүгийн боловсрол, мэдээллийн аюулгүй байдал, тогтвортой хөгжлийн (ус, эрчим хүч, хог хаягдал) сургалтуудыг зохион байгуулж мөн голын дагуух хог түүн нийгмийн ажилд оролцов.

**2,500** гаруй хүүхдэд 3 удаагийн сургалт

# ОЮУТНУУДЫГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

## ОЮУТНУУДЫГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР



Голомт банкны нэрэмжит “Оюутны тэтгэлэгт хөтөлбөр”-ийн 2025 оны шилдэг 100 оюутныг шалгаруулж, сургалтын тэтгэлэг гардууллаа.

Оюутан, залуусын боловсролыг дэмжих, санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилгоор Голомт банк нийгмийн хариуцлагын хүрээнд бизнесийн байгууллагуудаас анхлан “Оюутны тэтгэлэгт хөтөлбөр”-ийг санаачлан хэрэгжүүлсэн түүхтэй. 2025 онд Голомт банкны түүхт 30 жилийн ой тохиож буй бөгөөд үүний 21 жилд нь “Оюутны тэтгэлэгт хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж, өдгөө үндэсний хэмжээний хөтөлбөр боллоо өргөжжээ.

Энэхүү хөтөлбөрийн хүрээнд тэтгэлэгт оюутан Голомт академийн хувь хүний хөгжлийн болон мэргэжлийн сургалт, эрүүл мэндийн хөтөлбөрт хамрагдаж, суралцах хугацаандаа мэргэжлийн ментор, коучингийн удирдлагатай хамтран ажиллах давуу талтай. Мөн 2024 оноос эхлэн Голомт банканд урилгаар бүтэн болон хагас цагаар шууд ажиллах боломжийг бүрдүүлснээр оюутнуудын хөдөлмөр эрхлэлтийг бодитоор дэмжин ажиллаж байна.

Голомт банкны нэрэмжит “Оюутны тэтгэлэгт хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж буй 21 жилийн хугацаанд 2,000 гаруй оюутан нийт 1.5 тэрбум төгрөгийн сургалтын тэтгэлэг хүртээд байна.



 **ГОЛОМТ БАНК**  
*Сайн сайхныг санхүүжүүлнэ*

УСНЫ ЭЛЧ  
БАНК

ОЛОН ТАЛТ ОРОЛЦОО

## “ЦЭНХЭР” САНХҮҮЖИЛТИЙН БОЛОМЖУУД БА ОЛОН ТАЛТ ХАМТЫН ОРОЛЦОО

Голомт банкнаас уламжлал болгон зохион байгуулдаг бүхий л арга хэмжээнүүдийг тогтвортой хөгжилд нийцүүлэн зохион байгуулж байна. Энэ жилийн тухайд “Цэнхэр” буюу тогтвортой усны нөөцийн менежментийг бэхжүүлэх, ундны усны хүртээмжийг нэмэгдүүлэх санхүүжилтийн ач холбогдол болон боломжуудыг онцлон “Монгол Улсын тогтвортой усны удирдлагын өнөөгийн нөхцөл байдал ба аж ахуй нэгжүүдэд тулгарах эрсдэл”, “ОУСК-тай хамтран “цэнхэр” эдийн засгийг бэхжүүлэх санхүүжилтийн боломжууд” зэрэг сэдвүүдээр салбарын төлөөлөгчдийг хамруулж, хэлэлцүүлгийн хүрээнд харилцагч нарт ногоон эдийн засгийн шилжилтийг цогцлоох мэдээллийг хүргэлээ.



## НОГООН ДЭЛХИЙГ ӨВЛҮҮЛЬЕ ХӨТӨЛБӨР

Голомт банк болон Нэгдсэн Үндэсний Байгууллага (НҮБ)-тай хамтран 2025 онд “Ногоон дэлхийг өвлүүлэх” уриатай цөлжилт, гантай тэмцэх дэлхийн өдөр болон МУ-д зохион байгуулагдах Талуудын бага хуралдаан (COP17) тохиолдуулан “Ногоон дэлхийг өвлүүлэх” уриатай аяныг санаачлан олон нийтийн сувгаар өрнүүлсэн билээ. Энэхүү аяны хүрээнд 3 сарын хугацаанд 9 удаагийн постер, рийл болон бичлэгээр мэдээлэл бэлтгэж нийт 484,377 хүнд хүрсэн байна.

## НОГООН ӨСӨЛТ-2025 ХӨТӨЛБӨР

Голомт банкнаас Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч харилцагч байгууллагууддаа байгальд ээлтэй инновац, ногоон болон цэнхэр шилжилтийн шийдлүүдийг таниулах, томоохон корпорайт байгууллагуудын хэрэгжүүлсэн сайн туршлагаадаас суралцах, бизнесийн үр дүнтэй менежментийг хэрэгжүүлэх зорилготой “Ногоон өсөлт-2025” бизнес аялыг амжилттай зохион байгууллаа. Уг хөтөлбөрт нийт 29 байгууллага хамрагдаж:

- Ногоон бизнесийн соёлоос суралцах,
- Тогтвортой хөгжлийн үндсэн ойлголтыг таниулах,
- Ногоон бизнесийн чиг хандлагыг судлах,
- Бизнесийн стратегид тогтвортой, ногоон шийдлүүдийг нэвтрүүлэх зэрэг олон чухал сэдвийн хүрээнд суралцаж, харилцан туршлага солилцсон үр дүнтэй хөтөлбөр боллоо.



# ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

## ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Банк, санхүүгийн байгууллагын хувьд өөрийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүн үйлчилгээгээр дамжуулан байгаль орчин болон нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулахад оруулах хувь нэмэр өндөртэй салбаруудын нэг билээ. Иймд БОНЗ-ын хүрээнд оролцогч талуудын хүлээлтийг хангах чухал үүргийг хүлээгээд байна.

Хөрөнгө оруулагчид	Харилцагчид	Ажилтнууд	Нийгэм	Зохицуулагч байгууллагууд	
Бид БОНЗ-ын тайлагналыг ил тод, нээлттэй байдлаар тайлагнаж байна.	Бид харилцагчдынхаа хэрэгцээ шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээг, түргэн шуурхай хүргэхээр ажиллаж байна.	Бид чадварлаг хамт олон бүрдүүлэх зорилгоор ажилтнуудаа хөгжүүлэн ажиллаж байна.	Бид нийгэмд тулгамдаад буй санхүүгийн асуудлууд, хүртээмжтэй байдлыг хэрхэн бий болгох талаар онцгойлон анхаарч ажиллаж байна.	Бид хууль, дүрэм журмын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.	
Бид хэрхэн хамтын ажиллагааг өрнүүлж байна вэ?	<ul style="list-style-type: none"> <li>• Тогтвортой хөгжлийн тайлан / жил бүр/</li> <li>• НҮББОХ-Банк Санхүүгийн санаачилга, Хариуцлагатай банкны зарчмуудын хэрэгжилтийн тайлан /жил бүр/</li> <li>• Санхүүгийн тайлангууд / улирал бүр, жил бүр/</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Салбар, дижитал сувгууд, харилцагчийн үйлчилгээний утас зэрэг олон сувагт харилцаа</li> <li>• Харилцааны болон корпорэйт менежерүүд</li> <li>• Харилцагчдын сэтгэл ханамжийн судалгаа /жил бүр/</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Ажилтнуудын сэтгэл ханамжийн судалгаа /жил бүр/</li> <li>• Ажиллахад хамгийн таатай газар батламж /жил бүр/</li> <li>• Удирдах ажилтнуудад зориулсан арга хэмжээ /жил бүр/</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• АмЧам, АустЧам, Монголын бизнесийн зөвлөл, Худалдаа аж үйлдвэрийн Танхимын гишүүн байгууллага ба үйл ажиллагаануудад идэвхтэй оролцдог.</li> <li>• НҮБ болон холбогдох байгууллагуудтай хамтын ажиллагааг бэхжүүлж байна.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо болон Хөрөнгийн биржтэй хамтран ажиллаж байна.</li> <li>• Эдийн засаг хөгжлийн яамтай хамтран ажиллаж байна.</li> </ul>

## ГИШҮҮНЧЛЭЛ БА ХАМТЫН АЖИЛЛАГАА

Голомт банк хурдацтай хувьсан өөрчлөгдөж буй БОНЗ-ын олон улсын стандарт, шаардлагуудтай нийцсэн байх, сайн туршлагуудаа оролцогч талуудтай хуваалцах үүднээс олон талт хамтын ажиллагааг өргөжүүлсээр байна.



### МОНГОЛЫН ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТИЙН ХОЛБОО

Монголын Тогтвортой Санхүүжилтийн Холбоо (ТоС) нь гишүүн санхүүгийн байгууллага, аж ахуйн нэгжүүдийн тогтвортой байдал, ногоон хөгжлийг дэмжих замаар санхүүжилтийн тогтолцоог ногоон болгох зорилготой ГҮТББ юм. Голомт банк Удирдах зөвлөлийн гишүүний хувьд Уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийн зөвлөл болон Тайлагналын зөвлөлд тус тус идэвхтэй хувь нэмрээ оруулж байна.



### НҮБ-ЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ХӨТӨЛБӨР-САНХҮҮГИЙН САНААЧИЛГА, ХАРИУЦЛАГАТАЙ БАНКНЫ ЗАРЧМУУД UNEP-FINANCE INITIATIVE, PRINCIPLES FOR RESPONSIBLE BANKING

НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр, Санхүүгийн санаачилга нь НҮБ-ын Хариуцлагатай банкны зарчмуудаар дамжуулан олон улсын банкнуудтай хамтран ажиллаж, эерэг, ногоон шилжилтийг хурдасгах зорилготой юм. Голомт банк тус санаачилгыг үүсгэн байгуулагч гишүүний нэг бөгөөд Монгол Улсыг төлөөлөн дангаараа ажилладаг.



### НҮҮРСТӨРӨГЧИЙН НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН САНХҮҮГИЙН ТҮНШЛЭЛ PARTNERSHIP FOR CARBON ACCOUNTING FINANCIALS (PCAF)

PCAF нь олон улсын банк, санхүүгийн байгууллагуудыг санхүүжүүлсэн хүлэмжийн хийн ялгаруулалтыг тооцоолох, ил тод нээлттэй болгох нэгдсэн аргачлалаар ханган ажилладаг юм. Голомт банк 2023 оны 2-р сард PCAF-ийн гишүүнээр элссэн бөгөөд PCAF аргачлалыг ашиглан нийт зээлийн багцын хүлэмжийн хийн ялгаруулалтыг тооцоод байна.



### JOINT IMPACT MODEL FOUNDATION

Голомт банк Нидерландын нөлөө бүхий FMO банкнаас эхлэлтэй "Joint Impact Model Foundation" байгууллагад 2024 оны 3-р сарын 15-ны өдөр албан ёсны гишүүнээр элсэв. Joint Impact Model Foundation-д гишүүн болсноор Голомт банк олгож буй санхүүжилтээрээ дамжуулан ялгаруулж буй хүлэмжийн хий, шинээр бий болгож буй ажлын байрны тоо болон эдийн засгийн өсөлтөд хэрхэн хувь нэмрээ оруулж байгаа зэргийг олон улсын аргачлалын дагуу тооцоолон бодит нөлөөллийг хэмжиж, нээлттэй ил тод тайлагнах боломжтой болсон байна.



### НОГООН АРИЛЖААНЫ БАНКНЫ ЭВСЭЛ

Голомт банк Монгол Улсын Тогтвортой хөгжлийн зорилтууд болон уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицоход анхааран ажиллаж байгаагийн хувьд Олон улсын санхүүгийн корпорац (ОУСК)-ийн дэргэдэх "Ногоон арилжааны банкны эвсэл"-д 2025 оны 12-р сард албан ёсоор нэгдлээ. Тус эвслийн гишүүнчлэлээрээ дамжуулан бүс нутгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, дэлхийн шилдэг туршлагаас суралцах, Монгол Улсын тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулж, ногоон санхүүгийн шинэлэг шийдлүүдийг дэмжих боломжууд нээгдэх юм.

 **ГОЛОМТ БАНК**  
*Сайн сайхныг санхүүжүүлнэ*

УСНЫ ЭЛЧ  
БАНК

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЭРСДЭЛ

# УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЭРСДЭЛ

## УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЭРСДЭЛ БА БОЛОМЖУУД

Голомт банкны үйл ажиллагаа болон биет хөрөнгүүд шууд бус санхүүжилт болон хөрөнгө оруулалтаар дамжин уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлд өртөж байдаг. Уур амьсгалтай холбоотой эрсдэлийн үндсэн хоёр ангилал нь биет ба шилжилтийн эрсдэл юм.

Биет болон шилжилтийн эрсдэлийн нөлөөлөл нь мэдэгдэхүйц бөгөөд өргөн цар хүрээтэйгээр Голомт банкны багц болон богино, дунд, урт хугацаанд санхүүгийн гүйцэтгэлд нөлөөлөх эрсдэлтэй.

Биет болон шилжилтийн эрсдэлийн хүчин зүйлс нь Голомт банкны багцын бүтэц, эдийн засгийн салбар, газарзүйн байршил, бизнесийн үйл ажиллагаа болон бусад нөхцөлөөс хамаарч өөр өөр байна.

## БИЗНЕСИЙН ДАВАН ТУУЛАХ ЧАДВАРЫГ СОРИХ НЬ

Голомт банк шилжилтийн эрсдэлийг удирдах зорилготой дараах хоёр ажлыг батлан үйл ажиллагаандаа хэрэгжилтийг хангуулахаар ажиллаж байна. Үүнд:

1. 2025 оны 11-р сарын 19-ний Удирдлагын хорооны шийдвэрийн дагуу Голомт банк үйл ажиллагаандаа ашиглах дотоод карбон үнийг дараах байдлаар тогтоосон болно.





2. 2025 онд “Шилжилтийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх заавар” баримт бичиг шинээр батлуулсан ба дараах ач холбогдолтой байна.

а) Ялгарал өндөртэй эдийн засгийн салбарт үйл ажиллагаа явуулж буй харилцагчид болон тухайн харилцагчийн хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах стратеги, хамтын ажиллагааг тодорхойлох.

б) Үнэт цаас, хувьцаа худалдан авахад банканд ногдох хүлэмжийн хийн ялгарлын хэмжээг тодорхойлсон дүгнэлт гаргах зорилготой болно. Ингэснээр банк дунд болон урт хугацаанд уур амьсгалын өөрчлөлтийн шилжилтийн эрсдэлийг бууруулах буюу санхүүжилт болон хөрөнгө оруулалтаас ялгарч буй хүлэмжийн хийн хэмжээг удирдах, цаашлаад бууруулах боломжтой гэж үзэж байна.

Хүлэмжийн хий ихээр ялгаруулж буй эдийн засгийн салбарууд дараах байдлаар тодорхойлогдоно.

1. Эрчим хүч
2. Уул уурхай
3. Үйлдвэрлэл (хүнд үйлдвэрлэл болон хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрүүд)
4. Хөдөө аж ахуй
5. Тээвэр
6. Барилга

### **САНХҮҮЖИЛТ БУЮУ БАГЦААС ЯЛГАРЧ БУЙ ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРЛЫГ БУУРУУЛАХ**

Банкны хэмжээнд шилжилтийн эрсдэл өндөр буюу банкны багц дахь хүлэмжийн хий өндөр эдийн засгийн салбаруудыг дараах байдлаар тодорхойлох ба харилцагчдын шилжилтийн бэлэн байдлыг үнэлэн “таг” хийн зэрэглэл тогтоох ажлыг эхлүүлээд байна.

# УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЭРСДЭЛ

## БАГЦЫН ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРАЛ, ЭДИЙН ЗАСГИЙН АНГИЛЛААР

ISIC код	Салбар	2025 /тнCO2е/	2024 /тнCO2е/	2023 /тнCO2е/
ISIC-A	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	66,696	47,480	13,461
ISIC-B	Уул уурхай, олборлолт	207,780	330,156	163,074
ISIC-C	Боловсруулах үйлдвэрлэл	88,184	64,683	76,169
ISIC-D	Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	30,367	35,051	9,528
ISIC-E	Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	4,041	570	696
ISIC-F	Барилга	50,383	38,378	29,256
ISIC-G	Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ	117,327	113,424	82,138
ISIC-H	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	6,038	10,230	3,646
ISIC-I	Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	3,199	2,781	2,112
ISIC-J	Мэдээлэл, холбоо	424	577	335
ISIC-K	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	840	1,007	548
ISIC-L	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	69,422	66,581	57,085
ISIC-M	Мэргэжлийн, шинжлэх ухаан, техникийн; захиргааны үйл ажиллагаа	108	117	219
ISIC-N	Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	187	48	54
ISIC-O	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	299	32	12
ISIC-P	Боловсрол	3,509	1,361	931
ISIC-Q	Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	2,169	2,301	1,582

## УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЭРСДЭЛ

ISIC-R	Урлаг, үзвэр, тоглоом, наадам	173	199	76
ISIC-S	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	10,485	11,016	4,962
ISIC-T	Өрхийн ажил олгогчийн үйл ажиллагаа; өрхийн өөрийн хэрэгцээнд зориулан ялгаваргүй бараа, үйлчилгээ үйлдвэрлэх үйл ажиллагаа	58	30	1
ISIC-U	Нутаг дэвсгэрээс гадуурх байгууллага, үйл ажиллагаа	1,236	2,486	1,704
Нийт		662,926	728,506	447,590

Үнэлгээний үр дүнд харицлагчдыг дараах байдлаар "таг" хийж тэднийг ногоон шилжилт хийх бэлэн байдлыг нэмэгдүүлэхэд хамтран ажиллаж байна.

Ялгарал бууруулах бэлэн байдлын түвшин	Бага	Дунд	Өндөр
	D, DD, C	CC	B, BB, A, AA
	Тогтвортой ногоон бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэх		
	Сургалт	Шилжилтийн/ногоон санхүүжилт	

2026 оноос эхлэн корпорэйт харилцагчдын ногоон шилжилтийн бэлэн байдлыг үнэлэн "таг" хийх, шилжилт хийх бэлэн байдлыг нэмэгдүүлэх ногоон бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгох, сургалт орох, техник туслалцаа үзүүлэх, хамтран ажиллах боломжуудыг илүү оновчтой болгож, урт хугацаанд банкны багцын шилжилтийн эрсдэлийг удирдах боломжийг бий болгох эхний алхам болоод байна. Энэхүү үнэлгээнд үндэслэн тухайн харилцагчийн бизнесийн ногоон шилжилтийг хэрхэн дэмжиж, хамтран ажиллах стратеги боловсруулан ажиллах юм. Түүнчлэн ялгарал өндөр салбарын харилцагчид энгийн нөхцөлөөр санхүүжилт хүсэх тохиолдолд дотоод карбон үнийг шийдвэр гаргахад харгалзан үзэх нөхцөлийг бүрдүүлж байна.

### УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН СЦЕНАРИ АНАЛИЗ

Бид уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийн нөлөөг стратегийн, санхүүгийн болон санхүүгийн бус шийдвэр гаргахад хэрхэн нөлөөлж болохыг сценари анализ хийн үнэлэхээр зорин ажиллаж байна. 2024 онд Голомт банк, Монголбанкны удирдамжийн хүрээнд NGFS<sup>2</sup> -ийн сценариудын дагуу урьдчилсан байдлаар сценари анализ хийн Монголбанканд хүргүүлсэн ба 2025 онд дараах аргачлалын дагуу хийсэн болно.

<sup>2</sup>NGFS буюу Санхүүгийн системийг ногооруулах сүлжээ

# УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН СЦЕНАРИ АНАЛИЗ

	Өнөөгийн бодлого хэвээр үргэлжлэх	Дулаарлыг 2°C-ийн дотор барих	Шилжилтийг хойшлуулах
Дэлхийн дулаарлын хэм барих зорилт	3°C+	1.6°C-д барих боломж 67%	1.7°C
Биет эрсдэл	Өндөр	Дунд зэрэг	Дунд зэрэг
Шилжилтийн эрсдэл	Дунд зэрэг	Өндөр	Өндөр
ХХЯ-ын бууралт, 2030 он гэхэд	14%	19%	14%
ХХЯ-ын бууралт, 2050 он гэхэд	24%	55%	52%
Нүүрстөрөгчийн үнэ тогтоож, хэрэгжүүлэх	Өөрчлөлтгүй	Нэн даруй	2030 оноос хойш
Нүүрстөрөгч 2030 (US\$/tCO <sub>2e</sub> )	5.63	35.2	5.63
Нүүрстөрөгч 2050 (US\$/tCO <sub>2e</sub> )	6.16	131.1	161.9
Эрчим хүчний эцсийн үнэ	Эрчим хүчний тогтмол үнэ	Үнийг яаралтай чөлөөлөх	Үнийн өөрчлөлт 2030 оноос хойш
Эрчим хүчний хосолсон хэрэглээ	Нүүрсний хэрэглээг үе шаттай бууруулах ч, 2050 оноос хойш эзлэх хувь 8% байх, Шингэн түлшний хэрэглээг үе шаттай бууруулж, бага хэмжээний хийн түлшний хэрэглээтэй байх, Энэ зууны эцэс хүртэл сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр, хэрэглээг бага багаар нэмэгдүүлэх, 2050 он гэхэд нийт эрчим хүчний хэрэглээнд эзлэх халаалтын хэрэгцээг 50%-иар нэмэгдүүлэх.	2030 он гэхэд нүүрсийг нэн даруй болон аажим хэрэглээнээс гаргах, Шилжилтийн түлшинд шингэн түлшний эзлэх хувь, хэмжээг нэмэгдүүлэх, Сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь 2050 он гэхэд 30%-д хүрч нэмэгдэх, 2020 онд эрчим хүчний хэрэглээнд эзлэх халаалтын эзлэх хувь хэмжээ 26% байгаа нь 2050 онд 50%-д хүрч нэмэгдэх.	Нүүрсийг 2030 он хүртэл үе шаттай бууруулж, 2045 он гэхэд хэрэглээнээс гаргах, Шингэн түлшийг шилжилтийн түлшээр хэрэглэх, Сэргээгдэх эрчим хүчний хэрэглээний боломж аажмаар нэмэгдэх, Халаалтын эзлэх хувь 2050 онд 50%-д хүрч нэмэгдэх.
Технологийн өөрчлөлт	Аажим/удаан өөрчлөлт	Дунд зэргийн өөрчлөлт	2030 он хүртэл аажим өөрчлөлт, түүнээс цааш хурдтай өөрчлөлт
CO <sub>2</sub> ялгарлыг багасгах	Бага хэрэглээ	Дунд зэргийн хэрэглээ	Дунд зэргийн хэрэглээ
Бүс нутгийн бодлогын өөрчлөлт	Өөрчлөлт бага, улс орнууд бодлогоо төдийлөн дорвитой өөрчлөхгүй.	Өөрчлөлт бага, бүх улс орнууд бодлогын арга хэмжээг даруй авч хэрэгжүүлэх.	Өөрчлөлт их, энэ нь дэлхийн дулаарлыг тодорхой түвшинд хязгаарлах зорилтыг хангах шилжилтийн хэрэгцээ гэнэт үүссэнтэй холбоотой байна.

ҮЕРИЙН СЦЕНАРИЙН ҮЕД ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ҮНЭД ҮЗҮҮЛЭХ ШОК:

Тухайн газрын үерийн эрсдэл	Бизнесийн зориулалттай үл хөдлөх хөрөнгийн үнийн шок	Орон сууцны үнийн шок
Бага	0%	0%
Дунд зэрэг	0%	0%
Өндөр	-3%	-5%
Маш өндөр	-9%	-12%

**Шилжилтийн эрсдэл:** NGFS-ийн 3 сценарийн дагуу эдийн засгийн секторуудад үзүүлэх нөлөөг макро үржүүлэгч болон нөлөөллийн онооны дагуу тооцоолсон. Сценари нөхцөл тохиолдоход макро эдийн засгийн хувьсагчдын өөрчлөлтийг тооцсон Монголбанкнаас боловсруулсан ирээдүйн таамаглал ашиглан макро үржүүлэгчийн нөлөө болон зээлдэгчийн эдийн засгийн секторт үзүүлэх шилжилтийн бодлого, технологийн өөрчлөлт, зах зээлийн хувьсгалын нөлөөг тодорхойлсон нөлөөллийн оноог 2030 онд зээлийн хүлээгдэж буй алдагдалд тусгасан ба доорх түвшингээр илэрхийлэв.

Хэрэглээний зээл болон орон сууцны зээлийн багцын хувьд зээлдэгчийн орлого олдог секторын нөлөөг үнэлэх боломж хязгаарлагдмал байсан тул шилжилтийн эрсдэлийг тооцоолоогүй.

**Биет эрсдэл:** Биет эрсдэлүүд нь цаг уурын өөрчлөлтөөс үүдэлтэй бөгөөд үер, ган, зуд зэрэг цаг агаарын эрс тэс үзэгдлийн давтамж нэмэгдэх үйл явдлаас үүдэлтэй байж болох ба банкнаас зээлийн багц дээр тус биет эрсдэлүүдийг дараах байдлаар тооцоолсон.



ГАН, ЗУД

- Ган, зуд хавсран тохиолдох сценарийг ашиглан Монголбанкнаас Уур амьсгалын өөрчлөлтийн сценари шинжилгээний хүрээнд боловсруулсан макро эдийн засгийн параметруудийн таамаглалуудыг ашиглан банкны зээлийн багц дээр тооцоолол хийв. Ингэхдээ зээлдэгчийн үйл ажиллагаа эрхэлдэг эдийн засгийн секторт үзүүлэх параметруудийн таамаглалыг хүлээгдэж буй алдагдалд нөлөөлүүлж, 3 сценарийн дагуу дундаж утгуудыг авсан.



ҮЕР

- Үерийн эрсдэлийг зээлийн багцын барьцаа хөрөнгийн үнийг бууруулах боломжтой сценариар тооцоолов. Орон сууц болон бизнесийн зориулалттай үл хөдлөх хөрөнгөд гарах үнийн шокиг хөрөнгийн байршлаар хамааруулан тодорхойлсон. Тус барьцаа хөрөнгийн үерийн шокт Монголбанкны шинжилгээний арга зүйн баримт бичигт тусгасан үнийн бууралтыг ашиглав.

# УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН СЦЕНАРИ АНАЛИЗ

## ГОЛОМТ БАНКНЫ ЗЭЭЛИЙН БАГЦЫН ХУВЬД:

Эдийн засгийн салбарууд	2025 оны байдлаарх зээлийн багц / тэр.төг/	Нийт хувь	Шилжилтийн эрсдэлийн зээлийн алдагдлын санд үзүүлэх дундаж нөлөө 2030	Биет эрсдэлийн зээлийн алдагдлын санд үзүүлэх дундаж нөлөө 2030
Хэрэглээ	1,982	23.8%	N/A	Low
ISIC-G Бөөний ба жижиглэнгийн худалдаа; моторт хөдөлгүүр бүхий тээврийн хэрэгсэл, мотоциклийн засвар үйлчилгээ	1,957	23.5%	Low	Low
ISIC-L Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	1,547	18.6%	N/A	High
ISIC-B Уул уурхай, олборлолт	589	7.1%	Moderate	Low
ISIC-F Барилга	575	6.9%	High	High
ISIC-C Боловсруулах үйлдвэрлэл	442	5.3%	Low	Low
ISIC-S Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	374	4.5%	Moderate	Low
ISIC-K Санхүүгийн ба даатгалын үйл ажиллагаа	172	2.1%	Low	Low
ISIC-L Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	131	1.6%	Moderate	High
ISIC-H Тээвэр, агуулах	128	1.5%	High	Low
ISIC-A Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас агнуур	103	1.2%	Low	Moderate
ISIC-D Цахилгаан, хий, уур болон агааржуулалт	64	0.8%	Moderate	Low
ISIC-I Зочид буудал, хоол хүнсний үйлчилгээ	53	0.6%	High	Moderate
ISIC-E Усан хангамж; ариутгах татуурга, хог хаягдлын менежмент ба нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа	9	0.1%	Moderate	High
Бусад	192	2.3%	Moderate	Low
<b>Нийт</b>	<b>8,318</b>	<b>100%</b>		

Голомт банк СТОУС ТБ1, ТБ2 стандартуудын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд сайжруулалтыг хийсээр байх болно.

## ХАРИЛЦАГЧДЫН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН ЭРСДЭЛИЙГ УДИРДАХ НЬ

Бид байгаль орчин, нийгмийн эрсдэл ба нөлөөллийг банкны харилцагчдын гүйлгээ ба харилцаан дээр үр дүнтэй удирдахыг зорин ажилладаг. 2015 оноос Байгаль орчин, нийгэм, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлснээр бид эдийн засгийн бүхий л салбарт шилдэг туршлагыг амжилттай хэрэгжүүлж байна. Тогтвортой санхүүжилтийн хэлтсийн мэргэшсэн байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээчид нь банкны харилцагчдын Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээг хариуцан ажилладаг.

Бидний хэрэгжүүлж буй аргачлал нь зээл батлах үйл явцад шууд тусгагдсан бөгөөд санхүүжилтийн шийдвэрээс үүдэн гарч болзошгүй нөлөөллийг тодорхойлох, удирдах, бууруулах, хянахад оролцогч талуудтай хамтран ажиллахад дэмжлэг үзүүлдэг.

Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээний журам нь Гүйцэтгэх захирлаар баталгаажсан ба Зээлийн үйл ажиллагааны журмын салшгүй хэсэг бөгөөд зээлийн хороо болон харилцагчдад үзүүлэх БОНЭҮ хийхэд салбар хоорондын болон салбарын онцлог шалгууруудыг тодорхойлдог.

Голомт банк “Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээний журам”-ыг 2025 онд ОУСК-ийн гүйцэтгэлийн 8 стандарттай бүрэн нийцүүлэн шинэчлэв. Үүний хүрээнд гаднын эх үүсвэртэй ногоон зээлийн санхүүжилтэд **“Байгаль, орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө”** (ESAP)-г харилцагчийн зээлийн гэрээнд нэмэлтээр оруулж, хэрэгжилтийг хянан ажиллаж эхлээд байна. Ингэснээр харилцагч Монгол Улсын хууль журам болон олон улсын эх үүсвэр олгогч байгууллагуудын шаардлагыг хангаж өөрсдийн үйл ажиллагаанаас үүдэх БОНЗ эрсдэлийг бууруулах, удирдах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.

## “БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ЖУРАМ”-ЫГ 2025 ОНД ОУСК-ИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН 8 СТАНДАРТТАЙ БҮРЭН НИЙЦҮҮЛЭВ.



- Гүйцэтгэлийн стандарт 1: Байгаль орчин нийгмийн эрсдэл, нөлөөллийн үнэлгээ ба удирдлага
- Гүйцэтгэлийн стандарт 2: Ажиллах хүч ба ажлын байрны нөхцөл
- Гүйцэтгэлийн стандарт 3: Нөөцийг үр ашигтай ашиглаж, бохирдлоос сэргийлэх
- Гүйцэтгэлийн стандарт 4: Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал, хамгаалалт
- Гүйцэтгэлийн стандарт 5: Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлт
- Гүйцэтгэлийн стандарт 6: Биологийн олон янз байдлын хамгаалалт болон байгалийн нөөцийн тогтвортой удирдлага
- Гүйцэтгэлийн стандарт 7: Нутгийн уугуул иргэд
- Гүйцэтгэлийн стандарт 8: Соёлын өв

# БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН ЭРСДЭЛ

Голомт банк байгаль орчин, нийгмийн эрсдэлийг таних, хэмжих, үнэлэх, хянах, тайлагнах, бууруулах, удирдахад шаардлагатай банкны бодлого журмууд болон тогтолцоог ногоон эдийн засагт шилжих Үндэсний төлөвлөгөөтэй уялдуулан байгаль орчны холбогдох хууль тогтоомж, бодлого журамд нийцүүлэн үйл ажиллагаанаас учирч болох эрсдэлийг удирдаж байна. 2025 онд байгаль орчин, нийгмийн эрсдэлийн нийт 1,646 (2024: 2,321) үнэлгээг зээлийн үйл ажиллагаанд хийж гүйцэтгэлээ. Нийт хийсэн үнэлгээний 71% (2024: 72%) нь эрсдэлгүй салбаруудад харьяалагдах ба үүнээс 69% (2024: 84%)-д нь санхүүжилт олгогдсон байна. Үлдсэн 29% (2024: 28%) нь байгаль орчин, нийгэмд нөлөөлөх нөлөө өндөр салбаруудад харьяалагдах ба үүнээс 56% (2024: 81%)-д нь санхүүжилт олгогджээ.

# 1,646

Нийт хийсэн байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээ

Нийт олгосон зээл

266

808

Нийт үнэлгээ хийсэн тоо

472

1,174

■ Эрсдэл өндөр салбар

■ Эрсдэлгүй салбар

## ЭРСДЭЛ ӨНДӨРТЭЙ САЛБАРТ ОЛГОСОН ЗЭЭЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН, САЛБАРААР:

	AA	AB	B	C	C+
A_ХАА_ОЙН_АЖ_АХУЙ_ЗАГАС_БАРИЛТ_АН_АГНУУР			3	17	
B_УУЛ_УУРХАЙ_ОЛБОРЛОЛТ		9	10	2	
C_БОЛОВСРУУЛАХ_ҮЙЛДВЭРЛЭЛ		1	12	79	
D_ДЭД_БҮТЭЦ		1	3		
E_Ус_хангамж_Сувагжилт_Хог_хаягдал			2		
F_БАРИЛГА			60	28	
/Q_ХҮНИЙ_ЭРҮҮЛ_МЭНД_НИЙГМИЙН_ХАЛАМЖИЙН_ҮЙЛ_АЖИЛЛАГАА					
L_ҮЛ_ХӨДЛӨХ_ХӨРӨНГИЙН_ҮЙЛ_АЖИЛЛАГАА					
P_БОЛОВСРОЛ					
G_ХУДАЛДАА			4	3	
H_ТЭЭВЭР_БА_АГУУЛАХЫН_ҮЙЛ_АЖИЛЛАГАА			6	22	
I_ЗОЧИД_БУУДАЛ_БАЙР_СУУЦ_НИЙТИЙН_ХООЛНЫ_ҮЙЛЧИЛГЭЭ				4	
НИЙТ		11	100	155	

 **ГОЛОМТ БАНК**  
*Сайн сайхныг санхүүжүүлнэ*

УСНЫ ЭЛЧ  
БАНК

ТООН ТОДРУУЛГА



# АЖИЛТНУУДЫН ТООН МЭДЭЭЛЭЛ

## АЖИЛТНУУДЫН ТООН МЭДЭЭЛЭЛ

Эрэгтэй vs Эмэгтэй (албан тушаалаар)

Тогтвортой хөгжлийн зорилго:



Албан тушаал	2025				2024				2023			
	Эмэгтэй	Эрэгтэй	Нийт	Хүйсийн харьцаа	Эмэгтэй	Эрэгтэй	Нийт	Хүйсийн харьцаа	Эмэгтэй	Эрэгтэй	Нийт	Хүйсийн харьцаа
Газрын захирлууд	7	11	18	0.6	10	14	24	0.7	7	12	19	0.6
Хэлтэс, салбарын захирлууд	72	62	134	1.2	72	67	139	1.1	60	64	124	0.9
Ажилтнууд	1,661	768	2,429	2.2	1,852	741	2,593	2.5	1,680	671	2,374	2.5
<b>Нийт</b>	<b>1,740</b>	<b>841</b>	<b>2,581<sup>3</sup></b>	<b>2.1</b>	<b>1,934</b>	<b>822</b>	<b>2,756</b>	<b>2.4</b>	<b>1,747</b>	<b>747</b>	<b>2,517</b>	<b>2.3</b>

## АЖИЛТНУУДЫН ТООН МЭДЭЭЛЭЛ

Эрэгтэй vs Эмэгтэй (байршлаар)

Тогтвортой хөгжлийн зорилго:



Байршил	2025				2024			
	Эмэгтэй	Эрэгтэй	Нийт	Хүйсийн харьцаа	Эмэгтэй	Эрэгтэй	Нийт	Хүйсийн харьцаа
<b>Баруун бүс</b>	<b>60</b>	<b>34</b>	<b>94</b>	<b>1.8</b>	<b>55</b>	<b>31</b>	<b>86</b>	<b>1.8</b>
Баян-Өлгий	13	14	27	0.9	14	14	28	1.0
Говь-Алтай	-	-	-	-	-	-	-	-
Завхан	9	4	13	2.2	-	-	-	-
Увс	14	5	19	2.8	14	6	20	2.3
Ховд	24	11	35	2.2	27	11	38	2.5
<b>Хангайн бүс</b>	<b>91</b>	<b>42</b>	<b>133</b>	<b>2.2</b>	<b>92</b>	<b>41</b>	<b>133</b>	<b>2.2</b>
Архангай	9	6	15	1.5	12	5	17	2.4
Баянхонгор	13	4	17	3.2	13	5	18	2.6

<sup>3</sup>Жирэмсний болон урт хугацааны амралттай ажилтнууд ороогүй бодит ажилтны тоо

## АЖИЛТНУУДЫН ТООН МЭДЭЭЛЭЛ

Булган	-	-	-	-	-	-	-	-
Орхон	40	16	56	2.5	35	16	51	2.2
Өвөрхангай	14	7	21	2	12	6	18	2.0
Хөвсгөл	15	9	24	1.7	20	9	29	2.2
<b>Төвийн бүс</b>	<b>122</b>	<b>58</b>	<b>180</b>	<b>2.1</b>	<b>131</b>	<b>46</b>	<b>177</b>	<b>2.8</b>
Говьсүмбэр	-	-	-	-	-	-	-	-
Дархан-Уул	38	22	60	1.7	35	17	52	2.1
Дорноговь	33	10	43	3.3	45	7	52	6.4
Дундговь	-	-	-	-	-	-	-	-
Өмнөговь	34	16	50	2.1	37	17	54	2.2
Сэлэнгэ	17	10	27	1.7	14	5	19	2.8
Төв	-	-	-	-	-	-	-	-
<b>Зүүн бүс</b>	<b>41</b>	<b>17</b>	<b>58</b>	<b>2.4</b>	<b>45</b>	<b>17</b>	<b>62</b>	<b>2.6</b>
Дорнод	21	8	29	2.6	26	8	34	3.3
Сүхбаатар	9	7	16	1.3	9	7	16	1.3
Хэнтий	11	2	13	5.5	10	2	12	5.0
Улаанбаатар	1,426	690	2,116	2.1	1,611	687	2,298	2.3
<b>Нийт</b>	<b>1,740</b>	<b>841</b>	<b>2,581<sup>4</sup></b>	<b>2.1</b>	<b>1,934</b>	<b>822</b>	<b>2,756</b>	<b>2.4</b>

### ЭГНЭЭНДЭЭ НЭГТГЭСЭН ШИНЭ АЖИЛТНУУД/ДАДЛАГАЖИГЧ

Тогтвортой хөгжлийн зорилго:



Төрөл	2025	2024	2023
Нийт	440	880	750
Шинэ төгсөгч	207	288	282
Дадлагын оюутан	61	284	290

<sup>4</sup>Жирэмсний болон урт хугацааны амралттай ажилтнууд ороогүй бодит ажилтны тоо

# БАЙГАЛЬ ОРЧИНТОЙ ХОЛБООТОЙ ТООН МЭДЭЭЛЭЛ

## БАЙГАЛЬ ОРЧИНТОЙ ХОЛБООТОЙ ТООН МЭДЭЭЛЭЛ

Тогтвортой хөгжлийн зорилго:



ЭРЧИМ ХҮЧ		2025			2024			2023		
		Оффисууд	Салбарууд	Нийт	Оффисууд	Салбарууд	Нийт	Оффисууд	Салбарууд	Нийт
Нийт эрчим хүчний хэрэглээ (кВт.ц)	2023 суурь оны өгөгдөл <sup>5</sup>	953,961.46	-	<b>953,961.46</b>	1,066,481.32	-	<b>1,066,481.32</b>	1,181,445.00	-	<b>1,181,445.00</b>
	Бүртгэл сайжруулсан өгөгдөл	1,129,010.82 <sup>6</sup>	804,658.25 <sup>7</sup>	<b>1,933,669.07</b>	1,066,481.32	608,631.45 <sup>8</sup>	<b>1,675,112.77</b>	1,181,445.00	-	<b>1,181,445.00</b>
Нийт сэргээгдэх эрчим хүчний хэрэглээ (кВт.ц)		(10,572)	-	<b>(10,572)<sup>9</sup></b>	(4,539)	-	<b>(4,539)</b>	(6,376)	-	<b>(6,376)</b>
Нийт орлого (сая төгрөг)				<b>601,235</b>			<b>564,620</b>			<b>477,292</b>
Эрчим хүчний интенсити (кВт.ц/сая төгрөг)- суурь он				<b>1.6</b>			<b>1.9</b>			<b>2.5</b>

УС	2025			2024			2023		
	Оффисууд	Салбарууд	Нийт	Оффисууд	Салбарууд	Нийт	Оффисууд	Салбарууд	Нийт
Нийт усны хэрэглээ (м3)	10,783.61	7,648.87	<b>18,432.48<sup>10</sup></b>	6,934	1,562	<b>8,496<sup>11</sup></b>	7,581	-	<b>7,581</b>
Төвийн шугам	10,783.61	7,648.87	<b>18,432.48</b>	6,934	1,562	<b>8,496</b>	7,581	-	<b>7,581</b>
Гүний ус	-	-	-	-	-	-	-	-	-
Нийт орлого (сая төгрөг)			<b>601,235</b>	-	-	<b>564,620</b>	-	-	<b>477,292</b>
Усны интенсити (м3/сая төгрөг)			<b>0.03</b>			<b>0.015</b>			<b>0.016</b>

<sup>5</sup>2023 суурь оны өгөгдөлд нийт 4 оффис хамаарч байна. Үүнд: Төв оффис, 2-р оффис, 3-р оффис, Парк Плейс

<sup>6</sup>Нийт 7 оффисын бодит эрчим хүчний хэрэглээ

<sup>7</sup>Нийт 42 салбаруудын бодит эрчим хүчний хэрэглээ

<sup>8</sup>Нийт 32 салбаруудын бодит эрчим хүчний хэрэглээ

<sup>9</sup>Амгалан агуулах болон 2-р оффис

<sup>10</sup>7 оффис, 23 салбарын усны хэрэглээ

<sup>11</sup>4 оффис, 9 салбарын усны хэрэглээ

# БАЙГАЛЬ ОРЧИНТОЙ ХОЛБООТОЙ ТООН МЭДЭЭЛЭЛ

## БАЙГАЛЬ ОРЧИНТОЙ ХОЛБООТОЙ ТООН МЭДЭЭЛЭЛ

Тогтвортой хөгжлийн зорилго:



ХОГ ХАЯГДАЛ	2025			2024			2023		
	Оффисууд	Салбарууд	Нийт	Оффисууд	Салбарууд	Нийт	Оффисууд	Салбарууд	Нийт
Нийт хог хаягдал (тн)									
Нийт дахин боловсруулсан (тн)	1.113	-	1.113	1.567	-	1.567	1.048	-	1.048
Нийт хогийн цэгүүд рүү ачуулсан (тн)	1,360.36	-	1,360.36 <sup>12</sup>	1,916.68	-	1,916.68	1,682.37	-	1,682.37
Эрчим хүчний интенсити (кВт.ц/сая төгрөг)			2.4			2.9			2.5

БУСАД	2025			2024			2023		
	Оффисууд	Салбарууд	Нийт	Оффисууд	Салбарууд	Нийт	Оффисууд	Салбарууд	Нийт
Худалдан авсан А4 цаас (тн)	11.71	48.61	60.32	10.4403	34.6486	45.0889	9.5431	31.2451	40.7882
FSC гэрчилгээтэй цаас (%)	100%	100%	100%	100%	100%	100%	100%	100%	100%

<sup>12</sup>Нийт хогийн цэгүүд рүү ачуулсан дахин боловсруулах боломжгүй бусад хог хаягдлын хэмжээг 1 ажилтны хоногт гаргах дундаж хаягдлын хэмжээнд үндэслэн тооцоолол гаргаж байна.

# БАЙГАЛЬ ОРЧИНТОЙ ХОЛБООТОЙ ТООН МЭДЭЭЛЭЛ

## БАЙГАЛЬ ОРЧИНТОЙ ХОЛБООТОЙ ТООН МЭДЭЭЛЭЛ

Тогтвортой хөгжлийн зорилго:



ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРУУЛАЛТ	2025			2024			2023		
	Оффисууд	Салбарууд	Нийт	Оффисууд	Салбарууд	Нийт	Оффисууд	Салбарууд	Нийт
Хамрах хүрээ 1 (тнCO <sub>2</sub> e)			234,961.16			96,165.07			231,794.22
Бензин			99,505.54			62,654.13			123,395.10
Дизель түлш			135,455.62			33,476.45			108,399.12
Хөргөгч, хөргүүр			-			0.41			-
Агааржуулагч			-			34.07			-
Цэвэр хүүгийн орлого / сая төг/			601,235			564,620			477,292
Интенсити (тнCO <sub>2</sub> e/ сая төг)			0.39			0.17			0.48
Хамрах хүрээ 2 (тнCO <sub>2</sub> e)			1,012.21			4,909.60			1,159.82
Эрчим хүч (байршилд суурилсан)	715.47		715.47	830.95	1,796.72	2,627.67	881.3	-	881.3
Халаалт (байршилд суурилсан)	296.74		296.74	667.56	1,614.37	2,281.93	278.52	-	278.52
Цэвэр хүүгийн орлого / сая төг/	-		601,235	-	-	564,620	-	-	477,292
Интенсити (тнCO <sub>2</sub> e/ сая төг)	-		0.002	-	-	0.009	-	-	0.002

<b>Хамрах хүрээ 3–бусад (тнCO2e)</b>	<b>2,014.95</b>	<b>2,447.88</b>	<b>2,506.73</b>
Категори 5: Хог хаягдал	1,711.33	2,050.77	2,175.73
Хог хаягдал /хогийн цэг рүү ачуулсан/	1,651.60	1990.90	2,120.70
Цаас	0.001	0.003	0.00
Хуванцар	0.004	0.004	0.01
Шил	0.0003	0.004	0.005
А4 цаасны хэрэглээ	53.09	54.33	49.15
Хуруу зай	0.0005	0.0004	0.001
Усны хэрэглээ	6.63	5.52	5.86
Категори 6: Томилолт (нислэг)	155.27	166.24	145.44
Категори 7: Ажилтнуудын гэр- ажил-гэр	148.36	230.87	185.56
<b>Нийт хамрах хүрээ 1,2,3(бусад)-тнCO2e</b>	<b>237,988.32</b>	<b>103,522.55</b>	<b>235,460.77</b>
Цэвэр хүүгийн орлого / сая төг/	601,235	564,620	477,292
Интенсити (тнCO2e/ сая төг)	0.39	0.18	0.49
<b>Хамрах хүрээ 3 – санхүүжүүлсэн (тнCO2e)</b>	<b>2,125,278</b>	<b>1,773,334</b>	<b>1,030,481.29</b>
Категори 15: Нийт багцын ХХЯ	662,926	728,506	447,590
Хөрөнгө оруулалт / өрийн хэлбэр/	1,448,515	1,028,393	582,621
Хөрөнгө оруулалт / өмчийн хэлбэр/	13,837	16,435	271
Цэвэр хүүгийн орлого / сая төг/	601,235	564,620	477,292
Интенсити (тнCO2e/ сая төг)	3.53	3.14	2.16

## БУСАД МЭДЭЭЛЭЛ

### БУСАД МЭДЭЭЛЭЛ

Ажилтнуудад зориулсан сургалт

Тогтвортой хөгжлийн зорилго:



Сургалт	2025	2024	2023
БОНЗ-ын сургалтад хамрагдсан ажилтнуудын тоо	8,862	5,970	7,362
Нийт сургалтын цаг /хүн.цаг/	73,776	194,848	164,738

### АЖИЛТНУУДАД ЗОРИУЛСАН ТЭТГЭМЖ

Тогтвортой хөгжлийн зорилго:



Тэтгэмж	2025	2024	2023
Эрүүл мэнд			
Эрүүл мэндийн аянд хамрагдсан ажилтнуудын тоо	480	551	1063
Оффис дээр эмчид хандан үзүүлсэн ажилтнуудын тоо	1282	1783	1275
Банкнаас эрүүл мэнд болон гэнэтийн ослын даатгалд хамруулсан ажилтны тоо	400 <sup>13</sup>	382	346
Тусгай хэрэгцээтэй ажилтнууд			
Ажлын байран дээрх ослын улмаас тэтгэмж авч буй ажилтнуудын тоо	2	5	4

<sup>13</sup>Эрүүл мэнд болон гэнэтийн ослын даатгалд банкнаас хамруулсан ажилтны тоо.

**ДИЖИТАЛ ШИЛЖИЛТ**

Тогтвортой хөгжлийн зорилго:



Дижитал шилжилт	2025 /өөрчлөлт %/	2024 /өөрчлөлт %/	2023 /өөрчлөлт %/
Дижитал сувгууд хэрэглэгчдийн тоо	+11.3%	+12.6%	+16.4%
Дижитал сувгууд идэвхтэй хэрэглэгчдийн тоо	+17.3%	+11.3%	+17.1%
Дижитал сувгуудаар хийсэн гүйлгээний тоо	+9.4%	+21.7%	+38.6%
SocialPay хэрэглэгчдийн тоо	+29.9%	+35.1%	+37.2%
SocialPay-р хийсэн гүйлгээний тоо	+49.1%	+65.5%	+121.4%

2 болон түүнээс дээш үйлчилгээ авдаг харилцагчдын эзлэх хувь	2025	2024	2023
Иргэд	61.3%	60.8%	60.8%
Бизнес	46.3%	34.5%	31.8%

**КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДАЛ**

Тогтвортой хөгжлийн зорилго:



Зөрчлүүд	2025 /өөрчлөлт %/	2024 /өөрчлөлт %/	2023 /өөрчлөлт %/
Хамгаалагдсан халдлагын тоо	883,457	3,964,544	7,500,000
Хамгаалагдсан халдлагын хувь	100%	100%	100%

## БУСАД МЭДЭЭЛЭЛ

### ОЛОН ТАЛТ ОРОЛЦОО

Тогтвортой хөгжлийн зорилго:



Харилцагчид	2025	2024	2023
Нийт гарсан гомдлын тоо	32,493	29,015	24,431
Нийт шийдвэрлэсэн гомдлын тоо	32,493	29,015	24,431
Ажлын 5 өдрийн дотор шийдвэрлэсэн гомдлын тоо	29,050	25,820	22,655
Харилцагчдын сэтгэл ханамжийн судалгааны үр дүн	75.8%	76.4%	77.4%
Ажилтнууд	2025	2024	2023
Ажилтнуудын сэтгэл ханамжийн судалгааны үр дүн	92%	91%	87%

### "ТЭРБУМ МОД" САН

Тогтвортой хөгжлийн зорилго:



Хамтын ажиллагаа	2025	2024	2023
Санхүүгийн дэмжлэг <sup>14</sup>	1,232.6 сая төгрөг	1,155 сая төгрөг	868 сая төгрөг
Тарьсан мод /Тэрбум мод сангаар дамжуулан/		440,432.16	
Тарьсан мод /Ажилтнууд болон гэрээт/	226	400	290
Нарс	-	25	25
Гацуур	226	225	165
Буйлс	-	150	100

<sup>14</sup>Монголбанкны оруулсан дүн ороогүй, зөвхөн Голомт банкнаас гүйлгээний шимтгэлийн орлогоос оруулж буй дүн.

**ХАРИЛЦАГЧИДАЙ ХОЛБООТОЙ ТООН МЭДЭЭЛЭЛ**

Банкны харилцагчид, хүйсээр

Тогтвортой хөгжлийн зорилго:



	2025	2024	2023
<b>Банкны нийт харилцагчдын хувь, хүйсээр</b>			
Эмэгтэй	51%	48%	48%
Эрэгтэй	48%	44%	44%
Бусад	1%	8%	8%
<b>Банкны нийт зээлийн бүтээгдэхүүний хүртээмж, хүйсээр</b>			
Эмэгтэй	54%	53%	52%
Эрэгтэй	46%	46%	46%
Бусад	0%	1%	1%
<b>Банкны нийт хадгаламжийн бүтээгдэхүүний хүртээмж, хүйсээр</b>			
Эмэгтэй	56%	56%	56%
Эрэгтэй	44%	44%	44%
Бусад	0%	0%	0%



ШИЛДЭГ ТоС БАНК 2025



ТоС МАНЛАЙ БАНК 2026



УСНЫ ЭЛЧ БАНК 2025

Голомт банк дөрвөн жилийн дараа ТоС холбооны 2026 оны “Манлайлагч байгууллагаар”-аар дахин тодорч, шилжин явах тугийг нэр хүндтэйгээр гардан авлаа. Энэ нь Голомт банкны хувьд тогтвортой санхүүжилтийн зарчмуудыг амжилттай хэрэгжүүлж, ногоон эдийн засгийн хөгжлийг дэмжихэд манлайлж, тогтвортой санхүүжилтийн чиглэлд гаргасан санал санаачилгаа үнэлүүлж, цаашид үлгэрлэн манлайлах томоохон үүрэг хариуцлагыг хүлээн авч буй бөгөөд 2026 онд манлайлан ажиллах болно.



2020

Онцлох ТоС Банк



2021

ТоС Манлайлагч Байгууллага



2022

Онцлох ТоС Банк



2023

Жендэрийн Манлай Банк



2024

Онцлох ТоС Банк



2025

Шилдэг ТоС Банк  
ТоС Манлайлагч Байгууллага 2026  
Усны Элч Банк

Тайлангууд	Хамаарах жил	Холбоос
Тогтвортой хөгжлийн тайлан	2020	ENG: <a href="https://golombank.com/sustainable-development">Sustainable Development (golombank.com)</a>
Тогтвортой хөгжлийн тайлан	2021	MON: <a href="https://golombank.com/togtvtorтой-хөгжлийн-тайлан">Тогтвортой хөгжлийн тайлан (golombank.com)</a>
Тогтвортой хөгжлийн тайлан	2022	
Тогтвортой хөгжлийн тайлан болон дэд тайлангууд	2023	
<ul style="list-style-type: none"> <li>Монголын хөрөнгийн биржийн БОНЗ, тогтвортой байдлын тайлагналын стандарт (GRI стандарт)</li> </ul>		
Тогтвортой хөгжлийн тайлан болон дэд тайлангууд	2024	
<ul style="list-style-type: none"> <li>Монголын хөрөнгийн биржийн БОНЗ, тогтвортой байдлын тайлагналын стандарт (GRI стандарт)</li> <li>Хөгжлийн нөлөөллийн үнэлгээний тайлан (Ногоон бондын хүрээнд нөлөөллийг үнэлсэн тайлан)</li> <li>НҮББОХ-ийн Хариуцлагатай банкны зарчмуудын хэрэгжилтийн тайлан 2024</li> </ul>		
Тогтвортой хөгжлийн тайлан болон дэд тайлангууд	2025	
<ul style="list-style-type: none"> <li>Монголын хөрөнгийн биржийн БОНЗ, тогтвортой байдлын тайлагналын стандарт (GRI стандарт)</li> <li>Хөгжлийн нөлөөллийн үнэлгээний тайлан (Ногоон бондын хүрээнд нөлөөллийг үнэлсэн тайлан)</li> <li>НҮББОХ-ийн Хариуцлагатай банкны зарчмуудын хэрэгжилтийн тайлан 2025</li> </ul>		
Хариуцлагатай банкны зарчмууд: Явцын тайлан	2021	ENG: <a href="https://golombank.com/sustainable-development">Sustainable Development (golombank.com)</a>
Хариуцлагатай банкны зарчмууд: Явцын тайлан (E&Y баталгаажуулсан)	2022	
Хариуцлагатай банкны зарчмууд: Явцын тайлан (E&Y баталгаажуулсан)	2023	
Хариуцлагатай банкны зарчмууд: Явцын тайлан (Дотоод аудит баталгаажуулсан)	2024	2024 оноос эхлэн Хариуцлагатай банкны явцын тайлан нь Тогтвортой хөгжлийн тайлантай нийлж гардаг болов.
		2024 оны 11-р сараас эхлэн бүх гишүүн байгууллагуудын хувьд 2024 оны нэгтгэсэн Хариуцлагатай банкны явцын тайлан нь өмнөх Хариуцлагатай банкны зарчмуудын тайлан болон өөрийн үнэлгээний загварыг орлох болно.
		Холбоос: <a href="https://www.unepfi.org/wordpress/wp-content/uploads/2024/11/PRB-Responsible-Banking-Progress-Statement.pdf">https://www.unepfi.org/wordpress/wp-content/uploads/2024/11/PRB-Responsible-Banking-Progress-Statement.pdf</a>

 **ГОЛОМТ БАНК**  
*Сайн сайжрыг санхүүжүүлнэ*

УСНЫ ЭЛЧ  
БАНК

**БОНЗ ТАЙЛАГНАЛЫН ОЛОН УЛСЫН  
СТАНДАРТУУДЫН НИЙЦЭЛ**

## НҮББОХ-САНХҮҮГИЙН САНААЧИЛГА, ХАРИУЦЛАГАТАЙ БАНКНЫ ЗАРЧИМ (ХБЗ)-УУДЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

Зарчим 1: Нийцэл	Зарчим 2: Нөлөөлөл ба зорилтот түвшин	Зарчим 3: Харилцагч, үйлчлүүлэгчид
<p>Голомт банк нь Тогтвортой хөгжлийн зорилтууд (ТХЗ), Парисын Уур амьсгалын хэлэлцээр, Уур амьсгалын эсрэг хамтын амлалт (СССА) болон Үндэсний зорилтуудад хувь нэмэр оруулахаар бизнесийн стратегидаа уялдуулан хэрэгжүүлсээр ирсэн бөгөөд банкны стратегийн гол тулгууруудын нэг юм.</p> <p>2024 оны 4-р сард Ж.П.Морганы Хөгжлийн Санхүүгийн Байгууллагаас, Голомт банкны санхүүжилт, үйл ажиллагааг НҮБ-ын Тогтвортой Хөгжлийн Зорилтууд болох #2, #4, #5, #6, #7, #8, #12, #13-т, 2024 оны 08 сарын 02-ны байдлаарх хувь нэмрийг өндөр байхаар үнэлэв.</p> <p>Тайлант хугацаанд Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/ ТБ1: Тогтвортой байдалтай холбоотой мэдээллийн ил тод байдлын ерөнхий шаардлага болон СТОУС ТБ2: Уур амьсгалтай холбоотой тодруулга стандартуудыг хэрэгжүүлэх бэлэн байдлын төлөвлөгөөний дагуу холбогдох нэгжүүд хэрэгжилтийг ханган улирал бүр Удирдлагын хороонд тайлагнаж байна. 2025 оны 12-р сарын 31-ний байдлаар хэрэгжилтийн бэлэн байдал СТОУС ТБ1-90%, СТОУС ТБ2-91%-тай байна. Банк 2026 оны тайланг СТОУС ТБ1 болон ТБ2 стандарттай бүрэн нийцүүлж тайлагнахаар зорин ажиллаж байна.</p> <p>Банкны тогтвортой хөгжлийн стратегид заасанчлан дараах үндсэн дөрвөн чиглэлд анхаарч байна.</p> <p>(1) Тогтвортой засаглал                  (2) Уур амьсгалын эрсдэлийн удирдлага                  (3) Тогтвортой ногоон санхүүжилт                  (4) Хөрөнгө оруулагчдын оролцоо</p>	<p>Голомт банкны нийт хөрөнгө зах зээлийн 22.3 хувийг бүрдүүлдэг бөгөөд байгууллагын банк, жижиг дунд банк, иргэдийн банк, дижитал банк, санхүүгийн менежмент зэргээр үйлчилгээ үзүүлж байна. НҮББОХ, Санхүүгийн санаачилга – ХБЗ-аас гаргасан аргачлалыг ашиглан 2021, 2023 онуудад банкны хөрөнгийн нөлөөллийн шинжилгээг хийсэн. Банкны хөрөнгийн бүтцэд 2025 онд томоохон өөрчлөлт гараагүй тул хөрөнгийн нөлөөллийн шинжилгээ хийх шаардлагагүй гэж үзэж байна.</p> <p>Голомт банк нь 2021 оны Монгол Улсын тогтвортой хөгжлийн нэн чухал сорилтууд болох Үндэсний Тодорхойлсон Хувь Нэмэр (NDC) болон Тогтвортой хөгжлийн зорилтууд (SDG) зэргийг стратегидаа уялдуулан хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах замаар уур амьсгалын тогтвортой байдлыг хангах болон Усны нөөцийн тогтвортой менежментийг хангах хоёр зорилтыг тодорхойлж, чигээ болгосон. Үүний хүрээнд банк НҮББОХ, Санхүүгийн санаачилга – ХБЗ -ын үйл явцын 2023 оны тайландаа 2030, 2050 оны зорилтуудад ХХЯ-г 30%, 50% бууруулах болон усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөллийг 5%, 10% бууруулахаар тусгав.</p> <p><b>ХХЯ-г бууруулах замаар уур амьсгалын тогтвортой байдлыг хангах</b></p> <p>Голомт банк санхүүжүүлсэн болон хөрөнгө оруулсан хүлэмжийн хийн тооцооллыг PCAF аргачлалын дагуу тооцоолж байна.                  Хуудас: 33-36</p> <p>2025 оны санхүүжүүлсэн ХХЯ-г эдийн засгийн салбараар харьцуулсныг Тогтвортой хөгжлийн тайлангийн “Уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийн удирдлага” хэсгээс харна уу.                  Хуудас: 66-72</p> <p><b>Тогтвортой усны менежмент</b></p> <p>а) 2025 оны ус их ашигладаг харилцагчдын авсан санхүүжилтийн төлөгдөөгүй үлдэгдэл</p>	<p>Ногоон эдийн засгийн шилжилт, улс орны Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд Голомт банк харилцагчийн оролцоог чухал гэдэгт итгэдэг. Банк нь дараах сувгуудаар үйлчлүүлэгч, харилцагчидтай харилцдаг.</p> <p><b>1. Харилцагчийн сургалт:</b></p> <p>Голомт банк ногоон бизнесийн шилжилтийг дэмжих, ногоон санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх, байгаль орчин, нийгмийн эрсдэлийг таньж, удирдах талаар харилцагч нартаа БОНЗ-ын сургалтыг тогтмол орж байна. Манай сургалт, уулзалтууд нь 2023 оны хоёрдугаар хагас жилээс хойш KPI-ийн салшгүй хэсэг болсон ба 2025 онд нийт 56 аж ахуйн нэгжийн төлөөлөл бүхий 182 (Эмэгтэй: 86, Эрэгтэй: 57, бусад: 39) хүмүүст сургалт, уулзалт зохион байгууллаа.</p> <p><b>2. Харилцагч нарт зориулсан арга хэмжээ:</b></p> <p>Манай харилцагч нар дунд хамгийн эрэлттэй жил бүр зохион байгуулагддаг арга хэмжээ бол “Байгууллагын харилцагч” нарт зориулсан “Санхүүгийн менежерүүдийн чуулга уулзалт”, мөн Жижиг, дунд бизнес эрхлэгчдэд зориулсан “Бизнес Хурал” билээ. 2025 онд дээрх арга хэмжээ нь “Back to the future” сэдвийн доор зохион байгуулагдаж нийт 1000 гаруй төлөөлөгч оролцов. Арга хэмжээний үеэр Тогтвортой хөгжилтэй холбоотой дараах сэдвүүдийг хэлэлцэв.</p>

## Зарчим 1: Нийцэл

## Зарчим 2: Нөлөөлөл ба зорилтот түвшин

## Зарчим 3: Харилцагч, үйлчлүүлэгчид

Эдийн засгийн салбар	2025		2024	
	сая м <sup>3</sup>	Харилцагч #	сая м <sup>3</sup>	Харилцагч #
ХАА	-		-	-
Үйлдвэр	9.95	15	9.97	13
Уул уурай болон хайгуул	8.63	15	8.46	16
Дэд бүтэц	1.17	3	29.3	5
Усан хангамж, хог хаягдлын менежмент	-	-		3
Худалдаа	0.5	3	0.5	3
Зочид буудал, эмнэлэг, нийгмийн үйлчилгээ	0.02	1	0.02	1
Тээвэр, логистик	0.003	1	0.003	1
<b>НИЙТ</b>	<b>20.27</b>	<b>38</b>	<b>48.21</b>	<b>39</b>

1) Монгол Улс усны хязгаарлагдмал нөөц, ундны усны хүртээмж, хаягдал ус цэвэрлэх зэрэг усны менежменттэй холбоотой олон сорилтуудтай тулгарч байна. Эдгээр сорилтуудыг даван туулах, эрүүл аюулгүй усны хүртээмжийг нэмэгдүүлэх, мөн байгаль орчинд ээлтэй, тогтвортой хөгжлийг дэмжих санаачилгаар зогсохгүй, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор Голомт банк нь Олон улсын санхүүгийн корпорацаас (ОУСК) 160 сая ам.долларын санхүүжилтийг амжилттай татан төвлөрүүлсэн бөгөөд "Цэнхэр Санхүүжилт"-ийн боломж бололцооны талаар арга хэмжээний үеэр танилцуулав.

2) Усны газрын дарга З.Батбаяр арга хэмжээний үеэр Монгол улсын гүний усны нөөц болон тогтвортой усны менежментийг аж ахуйн нэгжүүд хэрэгжүүлэх шаардлагатай талаар илтгэл тавьж Голомт банкны тогтвортой усан хангамжийн чиглэлээр олгох зээлийг онцлон тэмдэглэв.

### 3. Ногоон зээлийн багц

2025 оны байдлаар Голомт банк нь тогтвортой, ногоон зээлийн 6 бүтээгдэхүүн, ногоон санхүүгийн шийдлийг харилцагч нартаа санал болгож байна.

Банкнаас хэрэгжүүлж буй хөтөлбөр болон сургалтуудын үр дүнд ногоон зээлийн багц мэдэгдэхүйц өссөн бөгөөд 2024 оны эцэст 265 тэрбум төгрөг байсан бол 2025 оны эцэс гэхэд 406 тэрбум төгрөг болж өсөв.

### Ногоон болон тогтвортой бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжих дотоод сургалтууд:

1. Тогтвортой, ногоон санхүүжилтийн чиглэлээр сургагдсан 377 харилцааны шинэ менежерүүд.

2. UNEP FI PRB Academy-с зохион байгуулдаг хариуцлагатай банкны зарчмын цахим сургалтад нийтдээ 30 ажилтнууд, Хариуцлагатай банкны зарчмууд, Уур амьсгалын өөрчлөлт, Харилцагчаа танин мэдэх зэрэг сэдвийн хүрээнд сургалтад хамрагдав.

## Зарчим 1: Нийцэл

## Зарчим 2: Нөлөөлөл ба зорилтот түвшин

## Зарчим 3: Харилцагч, үйлчлүүлэгчид

Голомт банк 2021 оноос хойш НҮББОХ, Санхүүгийн санаачилга – ХБЗ –ын үйл явцын тайланг нээлттэй нийтэлсээр байна. Өмнө жилүүдэд дээрх хүснэгтийн дагуу эдийн засгийн салбараар ангилж ус ихээр ашиглаж буй харилцагчдын мэдээллийг цуглуулж тайлагнадаг байсан ба сүүлийн гурван жилийн өгөгдөл дээр үндэслэн анализ хийж үзэхэд Монгол улсын “Усны Тухай” хуулийн хүрээнд ус ихээр ашиглаж буй эдийн засгийн салбарын усны экологи эдийн засгийн үнэлгээ, ус бохирдуулсны төлбөр, ус дахин ашиглах, хязгаарлах, усны экосистем нөхөн сэргээх зэрэг голлох заалтууд 2012 оноос хойш дахин шинэчлэгдээгүй байгаа тул дээрх хүснэгтэд буй ус ихээр ашиглаж, мөн бохирдуулж буй “Уул уурхай олборлолт”, “Дэд бүтэц”, “Хөдөө аж ахуй” зэрэг эдийн засгийн салбарын эрх зүйн хязгаарлагдмал орчноос үндэслэн банк цэнхэр санхүүжилт өгөх боломж хязгаарлагдмал байгаа ба 2026 оноос эхлэн дээрх эдийн засгийн сектороор бус Монголын өнөөгийн зах зээл, хууль эрх зүйн орчинд тохируулан худалдаа, цэвэр усны хүртээмжийг нэмэгдүүлэх тоног төхөөрөмж, усан сан, хөв цөөрөм байгуулах төсөл хөтөлбөр болон үйлдвэрүүдэд цэнхэр санхүүжилтийг олгож, усны өгөгдлийг цуглуулах тал дээр багц бүрдүүлэн ажиллаж байгаа болно. Ирэх онуудад тогтвортой усны удирдлагыг бэхжүүлэхэд чиглэсэн санхүүжилтийг хэмжээ болон нөлөөлөл дээр суурилсан өгөгдөл, мэдээллийг тайлагнан толилуулах болно.

Голомт банкны “Цэнхэр санхүүжилт”-ийн санаачилгуудын талаар дэлгэрэнгүй мэдээллийг тайлангийн 31 – 32 хуудаснаас харна уу.

Усны эх үүсвэр	2025		2024	
	сая м³	Харилцагч #	сая м³	Харилцагч #
Гадаргын (гол, нуур)	-	-	-	-
Гүний	10.39	27	9.93	25
Зөврийн	-	-	-	-
Төвийн сүлжээ	9.88	10	29.26	11
Давхар	0.0004	1	9.02	3
N/A	-	-	-	-
<b>НИЙТ</b>	<b>20.27</b>	<b>38</b>	<b>48.21</b>	<b>39</b>

Зарчим 1: Нийцэл	Зарчим 2: Нөлөөлөл ба зорилтот түвшин	Зарчим 3: Харилцагч, үйлчлүүлэгчид										
	<p>2025 оны байдлаар ус их хэмжээгээр ашиглаж буй харилцагчдын тоо 39-с 38 болж буурсан бөгөөд усны хэрэглээ мөн адил 48.21 сая.м3-с 20.27 сая.м3 болж буурав. Усны хэрэглээ буурсан гол шалтгаан нь 2024 онд Голомт банк дөрвөн ДЦС-д эргэлтийн хөрөнгийн санхүүжилт олгосонтой холбоотой огцом өсөлт бий болсон байсан бол 2025 оноос эзэл төлөгдсөнтэй холбоотойгоор усны хэрэглээ буурсан. Сүүлийн гурван жилийн өгөгдөл дээр үндэслэн анализ хийсний үр дүнд Монгол улсын голлох усны хэрэглээ гүний уснаас шууд хамааралтай, ус дахин ашиглах системийн хомсдолтой байдал, усны төвийн сүлжээний техникийн элэгдэл, хуучирсан нөхцөл байдал, хариуцлагагүй усны хэрэглээ их байгаагаас усны нөөцийн хомсдол үүсэх, гол мөрөн ширгэх зэрэг байгалийн доройтол, гамшиг, уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт хурдацтай явагдаж байна. Тиймээс Голомт банкны хувьд усны дэд бүтцийн сайжруулалт, гадаргын усны хэрэглээг нэмэгдүүлэх, усны тогтвортой менежмент зэргийг дэмжих технологи, систем зэрэгт цэнхэр санхүүжилтийг өгч Монгол улсын урт хугацааны усны нөөцийг хадгалах, нэмэгдүүлэх, сайжруулах чиглэлд ажиллаж байна.</p> <table border="1" data-bbox="763 783 1451 1011"> <thead> <tr> <th>Ангилал</th> <th>Ам.доллар</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Цэвэр ус хангамж, бохир ус зайлуулах шугам хоолой барих</td> <td>5,052,687</td> </tr> <tr> <td>Сантехникийн тоног төхөөрөмж, ус хадгалах сав</td> <td>1,993,881</td> </tr> <tr> <td>Хиймэл нуур</td> <td>370,837</td> </tr> <tr> <td>НИЙТ</td> <td>7,417,406,73</td> </tr> </tbody> </table> <p>b)2025 оны эцсээр бүрдүүлсэн ус ариун цэврийн хүртээмжийг нэмэгдүүлэх багц</p>	Ангилал	Ам.доллар	Цэвэр ус хангамж, бохир ус зайлуулах шугам хоолой барих	5,052,687	Сантехникийн тоног төхөөрөмж, ус хадгалах сав	1,993,881	Хиймэл нуур	370,837	НИЙТ	7,417,406,73	
Ангилал	Ам.доллар											
Цэвэр ус хангамж, бохир ус зайлуулах шугам хоолой барих	5,052,687											
Сантехникийн тоног төхөөрөмж, ус хадгалах сав	1,993,881											
Хиймэл нуур	370,837											
НИЙТ	7,417,406,73											

Зарчим 1: Нийцэл	Зарчим 2: Нөлөөлөл ба зорилтот түвшин	Зарчим 3: Харилцагч, үйлчлүүлэгчид
	<p>Голомт банк нь 2023 оны сүүлчээс эхлэн байгууллага болон жижиг дунд бизнес эрхлэгчдэд ус ариун цэврийн хүртээмжийг нэмэгдүүлэх тогтвортой, ногоон санхүүжилтийг олгож эхэлсэн. Тайлант оны эцэст банкны ус ариун цэврийн хүртээмжийг нэмэгдүүлэх багц олон улсын фондод тайлагнасан дүнгээр 6.9 сая ам. доллар байгаа ба өөрийн эх үүсвэрээр санхүүжүүлсэн дүнтэй нийлээд 7.4 сая ам. доллар байна.</p> <p>с) Усны газартай хамтран ажиллах санамж бичиг, хийгдсэн ажлууд                      “УСНЫ ЭЛЧ БАНК”                      Дэлхийн усны өдрийг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар зохион байгуулсан “Цэнхэр Алт-2” үндэсний чуулга уулзалтын үеэр Голомт банк 2025 оны “Усны элч” банкаар нэрлэгдсэн билээ. Мөн Голомт банк болон Засгийн Газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газар хамтын ажиллагааны санамж бичгийг сунган 2 дахь жилдээ хамтран ажиллаж байна.</p> <p>“ТЕХНИК ТУСЛАЛЦАА”                      Дэлхийн уур амьсгалын хамтын ажиллагааны сан (GCPF)-аас Голомт банкны үйлдвэрлэл эрхлэгч харилцагчдад “Урьдчилан цэвэрлэх байгууламж барих” чиглэлээр техник туслалцааг үзүүлж эхлээд байна. Техник туслалцааны хүрээнд Монгол Улсын нөхцөл болон тухайн бизнесийн онцлогт нийцүүлэн урьдчилан цэвэрлэх байгууламжийн техник, технологийн судалгаа, зөвлөмжийг үнэ төлбөргүй хүргэх юм. Энэхүү санаачилга нь хаягдал усны менежментийг сайжруулах, улмаар усны нөөцийг хамгаалах, гол мөрөн, хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөг багасгах ач холбогдолтой юм.</p>	

Зарчим 1: Нийцэл	Зарчим 2: Нөлөөлөл ба зорилтот түвшин	Зарчим 3: Харилцагч, үйлчлүүлэгчид
<p><b>Эх сурвалж ба холбоос</b></p> <p>Голомт банкны Тогтвортой хөгжлийн бодлогын дэлгэрэнгүй мэдээлэлтэй дараах холбоосноос орж танилцана уу.</p> <p>Холбоос: <a href="#">Тогтвортой хөгжлийн бодлого</a></p> <p>2024 оны Тогтвортой хөгжлийн нөлөөллийн үнэлгээг дараах холбоосноос харна уу.</p> <p>Холбоос: <a href="#">J.P. MORGAN DEVELOPMENT IMPACT ASSESSMENT</a></p> <p>2025 оны Тогтвортой хөгжлийн тайлангийн Тогтвортой засаглалын хэсгийг дараах хуудаснаас харна уу. Хуудас: 13 – 20</p> <p>2025 оны Тогтвортой хөгжлийн тайлангийн уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийн удирдлагын хэсгийг дараах хуудаснаас харна уу. Хуудас: 66 – 72</p> <p>2025 оны Тогтвортой хөгжлийн тайлангийн Тогтвортой ногоон санхүүжилтийн хэсгийг дараах хуудаснаас харна уу. Хуудас: 25 – 35</p> <p>2025 оны Тогтвортой хөгжлийн тайлангийн хөрөнгө оруулагчдын оролцооны хэсгийг дараах хуудаснаас харна уу. Хуудас: 63</p>	<p><b>Эх сурвалж ба холбоос</b></p> <p>Банкны санхүүгийн гүйцэтгэл болон зээлийн багцын дэлгэрэнгүй мэдээллийг 2025 оны жилийн тайлангаас харна уу. Холбоос: <a href="#">2025 оны жилийн тайлан</a> Хуудас: 76</p> <p>НҮББОХ, Санхүүгийн санаачилгын хүрээнд банкны 2021 оны тайлангийн үйл явцын нөлөөллийн дүн шинжилгээ, хоёр зорилт тодорхойлох хэсгийг доорх холбоосноос харна уу. Холбоос: <a href="#">Golomt-Bank-PRB-Stand-Alone-Report-2021.pdf</a>. Хуудас: 4 – 11</p> <p>Дунд болон урт хугацааны зорилтуудыг НҮББОХ, Санхүүгийн санаачилга – ХБЗ хүрээн дахь банкны 2023 оны явцын тайлангаас харна уу. Холбоос: <a href="#">UNEP-FI-PRB-2023-report_1</a>. <a href="#">Хуудас: 19 – 20</a></p> <p>Голомт банкны “Цэнхэр санхүүжилт”-ийн санаачилгуудын талаар дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 31 – 32 хуудаснаас харна уу.</p> <p>Харилцагчийн “Тогтвортой ногоон санхүүжилтийн сайн туршлагуудыг доорх холбоосноос харна уу. Холбоос: <a href="#">ТОГТВОРТОЙ-НОГООН-САНХҮҮЖИЛТИЙН-САЙН-ТУРШЛАГУУД1.pdf</a></p>	<p><b>Эх сурвалж ба холбоос</b></p> <p>Голомт банкны Тогтвортой, Ногоон зээлийн бүтээгдэхүүнтэй дараах холбоосоор танилцана уу.</p> <p>(a) Иргэдийн ногоон зээлийн бүтээгдэхүүн Холбоос: <a href="#">Зээл</a></p> <p>(b) Бизнесийн ногоон зээлийн бүтээгдэхүүн Холбоос: <a href="#">Зээл</a></p> <p>2025 оны Тогтвортой хөгжлийн тайлангийн Тогтвортой ногоон санхүүжилтийн хэсгийг дараах хуудаснаас харна уу. Хуудас: 25 – 35</p>

Зарчим 4: Оролцогч талууд	Зарчим 5: Засаглал ба соёл	Зарчим 6: Ил тод байдал ба хариуцлага
<p>2021 оноос хойш Голомт банкны Тогтвортой хөгжлийн стратеги дараах үндсэн дөрвөн чиглэлд төвлөрч байна.</p> <p>(1) Тогтвортой засаглал (2) Уур амьсгалын эрсдэлийн удирдлага (3) Тогтвортой ногоон санхүүжилт (4) Хөрөнгө оруулагчдын оролцоо</p> <p>Тайлант жилийн хугацаанд Тогтвортой хөгжлийн стратегид олон улс болон үндэсний хүрээний зорилго, стандартад томоохон өөрчлөлт ороогүй байна.</p>	<p>Голомт банкны Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ), Гүйцэтгэх удирдлага, Удирдлагын баг болон бусад холбогдох хороод нь тогтвортой хөгжил, уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэл ба боломжуудыг хянах, удирдах ажлыг хэрэгжүүлэх тогтолцоог бий болгон бэхжүүлсээр байна. 2025 онд Голомт банк Эрсдэлийн удирдлагын тогтолцоондоо "Тогтвортой хөгжлийн болон уур амьсгалын эрсдэл"-ийг харгалзан үзэх бодлогын чиглэл нэмж эрсдэлийн таксономид тусган Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулсан юм. Ингэснээр тогтвортой хөгжлийн болон уур амьсгалын эрсдэлийг бусад банкны уламжлалт эрсдэлүүдтэй эн зэрэгцэн тодорхойлох, үнэлэх, удирдах, хянах болон тайлагнах тогтолцоо, зарчим, удирдлагыг тодорхойлж урт хугацаанд тогтвортой үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэх, хөрөнгө оруулагч, харилцагч, ажилтан болон бусад оролцогч талуудыг ашиг сонирхлыг хамгаалах, Монгол Улсын хууль тогтоомж, Монголбанк болон бусад холбогдох эрх бүхий байгууллагуудын шаардлагыг ханган ажиллаж байна.</p>	<p>Голомт банк 2021 оноос хойш НҮББОХ, Санхүүгийн санаачилга – ХБЗ -ын үйл явцын тайланг нээлттэй нийтэлсээр байна.</p> <p>2021-2023 оны хугацаанд тус тайланг Эрнст энд Янг Монголиа ХХК хянасан бөгөөд банкны тайлангийн үнэн зөв байдлыг хянаж, хараат бус үнэлгээ хийснээр үйл ажиллагааны ил тод, хариуцлагатай байдлыг баталгаажуулсан болно.</p> <p>Дотоод аудитын газар нь НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн "Хариуцлагатай банкны зарчим"-д нэгдсэн банкнуудын "Хариуцлагатай банкны зарчмын тайлан" бэлдэх удирдамжийн дагуу тайланг бэлтгэсэн эсэх болон тус тайланд тусгасан 6 зарчмын хэрэгжилтийг нотлох мэдээлэл, тооцоолол, үр дүнд 2024.12.31-ний өдрийн байдлаар баталгаажуулалт хийсэн.</p> <p>"Хариуцлагатай банкны зарчмын тайлан"-д хийсэн баталгаажуулалтаар тус 6 зарчмын хүрээнд хийгдсэн ажил, тооцоолол нь бодит байдлаас зөрүүтэй тусгагдсан эсвэл материаллаг хэмжээний өөрчлөлт, сайжруулалт хийхүйц асуудал тухайн үед илрээгүй. Харин баталгаажуулалтын явцад сайжруулах шаардлагатай асуудлууд гарсныг тухай бүр явцын үүрэг өгч засварлуулсан ба тооцоололд ашиглагдах өгөгдлийн чанар, хамрах хүрээг нэмэгдүүлэх, автоматжуулах боломжийг судлах, үйл ажиллагаанд нэвтрүүлэх чиглэл өгч, 2025 болон 2026 онд төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p>
<p><b>Эх сурвалж ба холбоос</b></p> <p>2024 оны Тогтвортой хөгжлийн нөлөөллийн үнэлгээг дараах холбоосноос харна уу. Холбоос: <a href="#">J.P. MORGAN DEVELOPMENT IMPACT ASSESSMENT</a></p>	<p><b>Эх сурвалж ба холбоос</b></p> <p>2025 оны Тогтвортой хөгжлийн тайлангийн Тогтвортой засаглалын хэсгийг дараах хуудаснаас харна уу. Хуудас: 13 – 20</p>	<p><b>Эх сурвалж ба холбоос</b></p> <p>НҮББОХ, Санхүүгийн санаачилга, ХБЗ-ын 2021-2025 оны үйл явцын тайланг дараах холбоосноос харна уу. 1) <a href="#">Principles for Responsible Banking – Progress report 2021</a></p>

Зарчим 4: Оролцогч талууд	Зарчим 5: Засаглал ба соёл	Зарчим 6: Ил тод байдал ба хариуцлага
<p>2025 оны Тогтвортой хөгжлийн тайлангийн Тогтвортой засаглалын хэсгийг дараах хуудаснаас харна уу. Хуудас: 13 – 20</p> <p>2025 оны Тогтвортой хөгжлийн тайлангийн уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийн удирдлагын хэсгийг дараах хуудаснаас харна уу. Хуудас: 66 – 72</p> <p>2025 оны Тогтвортой хөгжлийн тайлангийн Тогтвортой ногоон санхүүжилтийн хэсгийг дараах хуудаснаас харна уу. Хуудас: 25 – 35</p> <p>2025 оны Тогтвортой хөгжлийн тайлангийн хөрөнгө оруулагчдын оролцооны хэсгийг дараах хуудаснаас харна уу. Хуудас: 63</p>	<p>2025 оны Тогтвортой хөгжлийн тайлангийн уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийн удирдлагын хэсгийг дараах хуудаснаас харна уу. Хуудас: 66 – 72</p>	<p>2) <a href="#">Principles for Responsible Banking – Progress report 2022</a></p> <p>3) <a href="#">Principles for Responsible Banking – Progress report 2023</a></p> <p>4) <a href="#">Principles for Responsible Banking – Progress report 2024</a> Хуудас: 94 – 99</p> <p>5) <a href="#">Principles for Responsible Banking – Progress report 2025</a> Хуудас: 94 – 99</p> <p>6) <a href="#">Дотоод Аудитын Газрын зөвлөмж</a> Хуудас: 5</p>

## БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Энэхүү тайлан нь Монголын Хөрөнгийн Биржид бүртгэгчтэй компанийн байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын чиглэлээр тайланг хугацаанд авч хэрэгжүүлсэн стратеги, арга хэмжээ, ноцлон байдалг хоронго оруулагчид, хувираа эзэмшигчид, олон нийтэд ил тод нээлттэй тайлагнах зорилготой.

Хэсэг 1, 2, 3 нь нийт үнэт цаас гаргагч компаниудад хамааралтай бөгөөд Хэсэг 4 нь зөвхөн тухайн салбарт үйл ажиллагаа явуулж буй үнэт цаас гаргагчдад хамаарна.

Хэрэв тайлангийн маягтад зэвсэг алив мэдээллийг нуглуулах, тайлагнах боломжгүй бол тайлагнах боломжтой талварх тайбар, шашинд мэдээллийг тайлагнах чиглэлд авч хэрэгжүүлдэг буй арга хэмжээний талвар "тайбар" хэсэгт бичнэ үү.

Бүлэг	Шалгуур үзүүлэлт		Үзүүлэлт (омнох он)	Үзүүлэлт (тайлант он)	Хэмжих нэгж	Нэмэлт мэдээлэл	Тайлбар	Холбоос
<b>Тогтвортой хөгжлийн удирдлагын системтэй холбоотой шалгуур үзүүлэлтүүд</b>								
MS1.1	Тогтвортой хөгжлийн удирдлагын систем	Удирдлагын амлалт	Удирдлагаас баталсан тогтвортой хөгжлийн амлалт/мэдэгдэл байдаг эсэх	Тийм	Тийм	Голомт банк нь 2019 онд НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр-Санхүүгийн санаачилга "Хариуцлагатай банкны зарчмууд"-д нэгдэн орж НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтууд болон Парисын уур амьсгалын гэрээ зэрэг олон улсын гэрээ хэлэлцээртэй үндсэн стратеги, шийдвэр гаргах, зээл олгох, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа уялдуулахаар амлалт өгөн, жил бүр хэрэгжилтийг тайлагнаж байна. Мөн МУ-ын Тогтвортой санхүүжилтийн 8 зарчмыг баримтлан ажилладаг.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичиг үү.	GRI 102
MS2.1		Тогтвортой хөгжлийн бодлого, зохицуулалт	Тогтвортой хөгжлийн бодлого, зорилтуудыг тодорхойлж баталсан эсэх	Тийм	Тийм	Голомт банк нь анх 2015 онд "Тогтвортой санхүүжилтийн бодлого" -ыг батлан, хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд 2019 оноос "Тогтвортой хөгжлийн бодлого" болгон бодлогын хүрээг өргөжүүлэн, 2024 онд дахин шинэчлэн найруулснаар Банкны үйл ажиллагаанд баримтлах үндсэн чиглэл, хэм хэмжээ, мөн зээлийн үйл ажиллагаа дахь Байгаль орчин, нийгмийн эрэлтийн удирдлагыг тодорхойлох баримт бичиг болгон мөрдөж байна. Бодлогын хураангуйтай дараах линкээр танилцана уу. <a href="https://golombank.com/about-bank/sustainable-development/sustainable-finance">https://golombank.com/about-bank/sustainable-development/sustainable-finance</a>	мэдээлэл байхгүй бол тайлбар бичиг үү.	GRI 103, ISO 14001
